

Ногоон хөгжлийн төлөө

EMONGOLIAN ECONOMY



Уул уурхай "утаагүй үйлдвэрлэл"-ийг
сөнөөх нь...

"Амжилт хүсье"

Ус усаа санхүүжүүлдэг болно

2011. 06, 07 сар. №005

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

**Монголын элсэнд зөвхөн
ашигт малтмал байна гэж үү?**





*Бизнес дэвжээх
шийдлийн эрхэмлэнэ*

БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

- ✓ 8 хүртэлх жил
- ✓ Барьцаа хөрөнгийн уян хатан шийдэл
- ✓ Бизнесээс хамаарах хүүгийн бодлого

EMONGOLIAN ECONOMY

Эдийн засаг, санхүү,
бизнесийн мэдлэг мэдээллийг
БИД ТҮТЭЭНЭ



Сэтгүүлийн захиалгыг редакцид авч байна.

Утас: 70110064, 88800825, 99015476
Хаяг: Улаанбаатар, СБД VI хороо, Бага-Тойруу
37Б, Байр - 206 тоот

Эрхлэгчийн зурвас

Үүсгэн байгуулагч,

Эрхлэгч: Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч,

Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
J.Itofo

Сэтгүүлч:

Д.Мөнхчимэг
Х.Хулан
Э.Зоригт

Орчуулагч:

Э.Өлзийлхам

Дизайнер:

Э.Чингүүн

Маркетингийн менежер:

Д.Барянжав
8880 0825
Б.Энхцэцэг
9901 5476

Утас/Факс: 976 - 7011 0064

Вэб: www.mongolianeconomy.mn

И-мэйл: info@mongolianeconomy.mn

Хаяг:

Улаанбаатар, СБД VI хороо,
Бага-Тойруу
37Б, Байр - 206 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Борлуулах цэгүүд:

"Интер ном"

"Majestic" их дэлгүүр

"Цэцэг төв"

"Зиг заг" автосервис

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza" дахь салбар

"Мир" номын дэлгүүрийн

"Metro mall" дахь салбар

"Минж плаза"

"Sky" супермаркет

"Алтантүлхүүр" номын дэлгүүр



Монгол орон гаднынхны нүдэнд олон зүйлээрээ өртөж байна. Ардчиллын салхи үлээсэн 1990-ээд оноос хойш Чингисийн Монголыг үзэхийг хүссэн жуулчдын тоо жилээс жилд өсөж байна. Мэдээж манай орны унаган байгалийн төрх тэдний нүдийг хужирладаг. Мөн өвөг дээдсээс уламжилсан соёл иргэншил, түүх, нүүдэлчин монголчуудын заншил гаднынхны сонирхлыг эрхгүй татна. Дэлхийд ганцхан буй эрийн гурван наадам, үлэг гүрвэлийн өлгий нутаг, дэлхийд хамгийн тунгалаг Хөвсгөл далай, Монголын говь энэ бүхэн гайхалтай. Үлэг гүрвэлийн томоохон музей байгуулахад л хилийн чанадаас манай орныг зорих жуулчдын тоо их хэмжээгээр

өсөхөөр байгааг бид онцлох сэдвүүдээрээ хөндлөө. Монгол гэж хаана ямар улс байдгийг ч мэдэхгүй мөртлөө Чингис хааны төрсөн нутагт очиж үзэхийг хүсдэг олон олон хүмүүс бий, дэлхий дахинд. Тэгвэл Монголын түүхийг сонирхон судалсан зохиогч Жак Уэтерфорд "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан" номыг бүтээж, дэлхийн анхаарлыг татлаа. Монгол үнэрийг гэртээ шингээсэн номын зохиолчийнд манай сэтгүүлчид зочилж, ярилцсан нь олон хүний сонирхлыг татах нь лав. Тэрбээр таваг дүүрэн ааруул, өрөм тавьсан идээгээр сэтгүүлчдийг дайлжээ. "Надад Монгол орон маш их таалагдсан тул он жил өнгөрөхийн хэрээр хэрэв би бичихгүй юм бол өөр хэн ч Монголын түүхийг дэлхий дахинаа тайлбарлан, мөн түүнчлэн орчин үеийн Монгол Улс хэрхэн бий болсныг бичихгүй юм байна гэдгийг ухаарсан. Монгол бол зэлүүд, алслагдсан орон биш, харин орчин цагийн дэлхийн төв юм" хэмээн яриагаа эхэлжээ.

Хөрөнгийн зах зээл буланд институционал хөрөнгө оруулагчдын талаарх цуврал нийтлэлээ хүргэж байна. Мөн Өмнөд Солонгос улс дахь хөрөнгө оруулалтын хамгийн том банкиртай хийсэн ярилцлагаас манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил Солонгосын 20 жилийн өмнөхтэй яг адилхан байгааг мэдэж авах болно.

Машины хурд ямар нэг байдлаар гай дагуулдгийг бид мэднэ. Тэгвэл эдийн засгийн хөгжлийн эрчимтэй хурд юуг дагуулах бол? Энэ талаар та манай сэтгүүлч Д.Мөнхчимэгийн "Амжилт хүсье" нийтлэлийг уншаарай.

Бид энэ дугаараа ногоон хөгжлийн төлөө анхаарахад зориулж хэд хэдэн нийтлэл зориуллаа. Монголын төр, засаг, Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих хөтөлбөрөө тоож харахгүй байхад Германы Фрайбург хот тэр чигээрээ ногоон өнгөнд дарагдаж, бүр мужийн захирагчаараа хүртэл Ногоон намын хүнийг сонгосон тухай, Сингапур улс Моджилтын аяныг хэрхэн дэмжиж, ногоон байгууламж бүхий өндөр хөгжилд хүрсэн улс болсон тухай, мөн манай дулааны гуравдугаар цахилгаан станцынхан үнсэн дээр бургас ургуулж буй зэрэг мэдээллийг таны сонорт хүргэж байна. Түүнчлэн уул уурхайгаас өөр зүйл ярихаа байсан өнөө цагт нөхөн сэргээлт хэр буй нь манайд хамгийн анхаарал татсан асуудал болоод буйг ч нийтлэлээрээ хөндлөө. За тэгээд "цагаан алт"-ны үнэ цэнэ алдагдаж, хайрлаж хамгаалах талаар дорвитой ажил хийгдэхгүй байгаа нь ирээдүйд ямар гачланд унагах, "цагаан алт"-ыг бохирдуулсан үйлдвэр хүмүүстэй хариуцлага тооцоход төр төмөр нүүрээ харуулах цаг болсон талаарх Ус бохирдуулагчийн торгуулийн тухай мэдээлэл танд нэгийг бодогдуулах биз ээ.

6-26 **Аялал жуулчлал**

- 6 Discover Mongolia
- 7 Дэлхийн хөгжлөөс гээгдсэн “хямдхан Монгол”
Н.Эрдэнэбат: Төрөлжсөн аялал жуулчлал хөгжинө гэдэг тухайн салбар чөмөг сууж буйн шинж
- 9 Монголын элсэнд зөвхөн ашигт малтмал байна гэж үү?
- 14 Хавай арлын аялал жуулчлалын нууц
- 16 Нэрэлхүү дамшиг
- 17 Л.Пүрэвбаатар: Тасалбаргүй, вагон хүрэлцэхгүй гэсэн асуудал үүсэхгүй
- 18 Та аялал жуулчлалын салбарын ирээдүйг хэрхэн харж байна вэ?
- 19 Уул уурхай “утаагүй үйлдвэрлэл”-ийг сөнөөх нь...
- 22 “Америк миний төрсөн нутаг, харин Монгол миний зүрхний нутаг”
- 26 Зочломтгой бас хамтач байхын учир

28-35 **Эдийн засаг**

- 28 Ц.Орхон: МИАТ-ийн үйлчилгээ гурван одын түвшинд явж байна
- 30 “Амжилт хүсье”
- 32 Хөрөнгө оруулагчид ТЭЦ-5 төслийг сонирхож байна
- 33 Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн зарим асуудал
- 35 Грек улс мөхлийн ирмэгт ирлээ

36-46 **Хөрөнгийн зах зээл**

- 36 Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих хөтөлбөр цаасан дээр...
- 39 Дэлхийд алдартай ногоон хот
- 42 Улаанбаатарыг “Ногоон баатар” болгоё
- 43 Салхит уулан дахь салхин паркийн нээлт болов
- 44 Үнсэн дээр ургуулсан бургас
- 45 Уул уурхайн нөхөн сэргээлтийн стандартыг сайжруулъя

47-52 **Хөрөнгийн зах зээл**

- 47 Даатгуулагчдын мөнгөөр хөрөнгийн биржээ дархлаажуулъя
- 50 Пиетро Доран: Солонгосын институционал хөрөнгө оруулагчдыг Монголд татах сонирхол их байна


53-56 **Байгаль эх**

- 53 Ус усаа санхүүжүүлдэг болно
- 55 Богд хаант төрийн “ногоон бодлого”
- 56 XXI зуунд байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд

57-46 **Бизнес**

- 57 Цорын ганц Монгол брэндээрээ гоёцгооё
- 59 Хоромд дамжих мэдээлэл буюу “жиргээ”-ний ноёрхол

64-67 **Market Data**



Эх сурвалж: Аялал жуулчлалын үндэсний төв



Шөг зургийг А.Амарсайхан

...Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл (WTTC) 2011 онд аялал жуулчлалын салбарт 652 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт ногдох төлөвтэйг тэмдэглэсэн....(7)

...Миний бодлоор Монгол шиг түүхтэй улс орон өөр хаа ч байхгүй. Монгол Улс маш ер бус онцгой түүхтэй...(22)

...Ногоон сэтгэлгээг чухалчилж, яам агентлаг бүрийн төлөвлөгөөнд суулгаж, хяналт тавьж шаарддаг байх ёстой...(36)



Онцлох сэдэв

Discover Mongolia

Аялал жуулчлалын бизнес дэлхийд улам хүчээ авч байгааг олон улсын аялагчдын тоо нэгэн жарны дотор 37 дахин нэмэгдэж, 935 саяас давсан явдал гэрчлэх биз ээ. Манай гариг дээрх зургаан хүн тутмын нэг нь жилдээ заавал өөрийнхөө амьдарч байгаагаас өөр орон руу аялж, жуулчилдаг гэсэн үг. Тэднээс аль болох олныг Монголдоо татаж, эдийн засагтаа их мөнгө шингээхийн тулд толгой тархиа ажиллуулах шаардлага бидний өмнө тулгарч байна. Жуулчны улирал эхэлсэнтэй холбогдуулан “Mongolian Economy” сэтгүүл энэ дугаарынхаа онцлох сэдвийг “утаагүй үйлдвэрлэл” рүү чиглүүлэхийг хичээлээ.

1954 онд аялагчдад үйлчлэх “Жуулчин” товчоог байгуулснаар Монголын орчин үеийн аялал жуулчлалын эхлэл тавигдсан гэдэг. Өнгөрсөн хугацаанд жуулчны тоо нэмэгдэж, энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж олширсон ч энэхүү салбар маань Монголын эдийн засгийн хувьд чухал үүрэг гүйцэтгэхгүй байгааг хэн ч үгүйсгэхгүй биз ээ. Төр, засгийн эрх баригчид уул уурхайн орлогоо бусад салбарын хөгжилд зарцуулна хэмээн амлаж байгаа ч бодит байдал дээр гараа хумин суугааг яалтай билээ. “Ашигт малтмалаа зарж олсон мөнгөөрөө Засгийн газар биднийг дэмжих байх” хэмээн

горьдож байсан аялал жуулчлалын салбарынхан хүнд цохилтод автаж эхэлжээ. Эрдэс баялгийн хайгуул, олборлолт хүрээгээ тэлэх тусам хэцүү байдалд орж байгаа аялал жуулчлалын салбарт Голланд өвчин нүүрлэснийг “Уул уурхай утаагүй үйлдвэрлэлийг сөнөөх нь” нийтлэлээс заавал уншаарай.

Ажиглаад байх нь ээ, ашигт малтмалаар баян орнууд хэзээ нэгэн цагт үүцээ шавхаж дуусахаа мэдэж байгаа учраас “нүхээ малтаж”, аялал жуулчлалын салбартаа хөрөнгө мөнгөө харамгүй цацах бодлого баримталдаг гэлтэй. Дубайчууд яагаад дал модны хэлбэртэй арал бий болгохын тулд олон тэрбум доллар зарцуулаад байгаа юм бэ? “Хар алт”-ны нөөц нь ёроолоо шүргэх тэр цаг үед Дубайн иргэдийг гагцхүү аялал жуулчлал л тэжээж, тэтгэж чадах учраас тэр шүү дээ.

Олон улсын аялал жуулчлалын тавцанд манай улс “Discover Mongolia” буюу “Монголыг нээ” гэсэн нэрээр овоглодог. Гэтэл уул уурхай “утаагүй үйлдвэрлэл”-ийн маань уриа үгийг хүртэл “дээрэмдэж”, “Discover Mongolia” нэрийн дор олон улсын хөрөнгө оруулалтын томоохон чуулга уулзалт уламжлал болгон зохион байгуулж эхэлсэн нь эдүгээ дэлхийд байр сууриа олчихсон яваа. Уг нь жуулчид Монголд ирээд, “нээх” зүйл олон бий. Өвөг дээдэс минь бидэнд дэлхийг гайхуулж, олныг

алмайруулах үүх түүх, соёлын хамт харсан үзсэн хэний ч сэтгэл хөдлөм сайхан байгалийг өвлүүлэн үлдээсэн билээ. Манай говийн элсэнд палеонтологийн асар үнэт олдворууд нуугдаж байгааг, Өмнөговийн Булган сумын нутагт орших Баянзаг үлэг гүрвэлийн өлгий нутаг болохыг Та мэдэх үү? 1920-иод онд Рой Чапмэн Эндрюс тэргүүтэй Америкийн байгалийн түүхийн музейн баг соёлт ертөнцөд энэ бүхнийг танилцуулсан тухай “Mongolian Economy” сэтгүүл уншигчдадаа сануулах гэсэн юм.

Жуулчид манайд ахин дахин ирээсэй, ирэх болгондоо Монголыг шинээр нээж, сэтгэл хангалуун буцаасай. Монголчууд бид ч газар шороогоо дэлбэлж, тэслэхэд хамаг анхаарлаа хандуулахаа больж, байгалийн сайхныг үзүүлээд, сурталчлаад мөнгө олдог “боловсон” салбараа хөгжүүлэх боломж байгааг ойлгох цаг иржээ. “Discover Mongolia” уриан дор зэс, алт, нүүрс тэргүүтэй ашигт малтмал хайж, олсон бүхнээ олборлох гэж улайран дайрахыг бус, утаагүй, хязгааргүй нөөцтэй аялал жуулчлалын салбараа хөгжүүлэхийг хэлж, илэрхийлэх хэрэгтэй болжээ. Ингэснээр л жинхэнэ утгаараа баяжих юм гэдгээ бид өөрсдийнхөө хувьд ойлгож, “нээх” цаг ирсэн байна. Таны нээлт амжилттай байх болтугай! ■

Асуудал

Дэлхийн хөгжлөөс гээгдсэн “хямдхан Монгол”

Жилийн дөрвөн улирлын ихэнхийг ичээндээ өнгөрөөдөг салбарынхан маань жуулчны улиралд бэлэн үү? Мэдээж бэлэн, тэгвэл зочдоо хүлээж аваад урагшаа! Нурж унах дөхсөн нэг барилгад аваачаад морин хуур, хөөмий үзүүлж, дараа нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас үйл ажиллагаа явуулахыг нь хориглосон Байгалийн түүхийн музейдээ аялагчдаа дагуулж очино. Хөөрхий жуулчид энд саяхан ОБЕГ-ынхан гамшаас хамгаалах сургуулилалт хийснийг ч мэдэлгүй ганц танхимд “гунигтай” байрлах үлэг гүрвэлийн яс харж баясах нь лавтай. За тэгээд Зайсан толгой гарна, гандангаар нэг орно, Чингис хааны морьт хөшөөг харуулна. Тэгээд Улаанбаатараас гарч нөгөө л Ёлын ам, Эрдэнэ зуудаа хүргэнэ. Монголд үзэх газар цөөн учир амар ч юм уудаа. Жуулчдыг татах арга хэмжээний хувьд ч ялгаагүй. Наадам, цагаан сар, нүүдэлчдийн өдөр, бүргэдийн, цаатны, түмэн тэмээний баяр гээд л дуусна. Гэтэл дэлхий дахинаа “утаагүй үйлдвэрлэл”, “үл үзэгдэх экспорт” хэмээн хүндлүүлсэн аялал жуулчлалын салбар ямар хурдан өргөжин тэлж байна вэ?

Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл (WTTC) 2011 онд аялал жуулчлалын салбарт 652 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт ногдох төлөвтэйг тэмдэглээд, ирэх 10 жилийн хугацаанд энэ үзүүлэлт хоёр дахин өсөж, 1.5 их наяд ам.долларт хүрэх тооцоо байгааг онцолсон юм. Өөрөөр хэлбэл, аялал жуулчлал нь олон улсын том бизнес болжээ. Энэ салбарт эргэлдэх их мөнгөнөөс шанаганыхаа хэрээр хутгахын тулд улс орнууд ухаан бодлоо уралдуулан өрсөлдөнө. Харин монголчууд яст мэлхийний хурдаар сажилна...

Аялал бизнес болсон нь

Хүн төрөлхтөн аль эртнээс шинэ газар үзэх, нээх, худалдаа хийх болон шашин шүтлэг, цэрэг дайны ажлаар алс хол явдаг байсан нь аялал жуулчлалын эхлэлийг тавьсан түүхтэй. Гэхдээ үйлдвэржилт хүчээ авч, галт тэрэг, онгоц, автозам

бий болсон нь энэхүү салбарын хөгжилд түлхэц болсон нь гарцаагүй ээ. Герман, Швейцарьт XIX зууны эхэн үед өндөр зэрэглэлийн зочид буудлууд үүд хаалгаа нээж, төд удалгүй аялал зохион байгуулдаг тур операторууд үүсэн байгуулагдсан байдаг. Харин Дэлхийн II дайны дараа аялал жуулчлалын салбарт эргэлт гарчээ. XX зууны 50-60-аад онд аялал жуулчлын компаниуд бөөн бөөнөөрөө гарч ирж, зугаа цэнгэлийн олон хувилбар бий болсон юм. 1980-аад оноос аялал гэдэг амьдралын хэв маяг болж, энэ салбарын үйлчилгээ төрөлжиж эхэлсэн байна.

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага буюу UN WTO олон улсын жуулчдын тоо 1950 онд ердөө 25 сая байсан бол өнгөрсөн жилийн байдлаар 935 саяд хүрээд байгааг мэдээлсэн юм. Түүнчлэн салбарын орлого 2010 онд 919 тэрбум ам.долларт хүрсэн нь жилийн өмнөхөөсөө таван хувиар өссөн үзүүлэлт болохыг онцолжээ. Тэртээ нэгэн цагт тэмээ, мориор аялдаг байсан хүмүүсийг хоол цай, хоноглох газраар хангах гээд хүлээж

суудаг байсан аялал жуулчлалын салбар өнөөдөр дэлхийн томоохон салбаруудын нэг болоод зогсохгүй олон сая хүнийг тэжээж байгаа юм. Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлийн судалгаанаас үзэхэд “утаагүй үйлдвэрлэл” дэлхий даяар 258 сая хүнийг ажлын байраар хангаж, бөмбөрцгийн ДНБ-ий 9.1 хувийг бий болгож байна. Ингээд зогсохгүй ирэх 10 жилийн хугацаанд ДНБ-д эзлэх хувь нь 4.2 хувиар нэмэгдээд, 65 сая ажлын байр шинээр бий болгох төлөвтэй. 2021 он гэхэд дэлхий дээрх 10 хүн тутмын нэг нь аялал жуулчлалын салбарын гавьяагаар ажлын байртай байх тооцоо ч бий ажээ.

Улс орнууд жуулчдыг татах ямар нэгэн хөшүүрэгтэй байдаг. Хятадын Цагаан хэрэм, Энэтхэгийн Таж Махал, Египетийн пирамидууд, Францын Эйфлийн цамхаг, Нью-Йоркийн Эрх чөлөөний хөшөө гээд л... Иймэрхүү түүхийн үнэт бүтээлгүй нь өөрсдийн ур ухаанаар жуулчдыг татах гэж үзэж тарна. Сингапурчууд өмхий үнэртсэн намгаа цэвэрлэж, хиймэл элс асгаснаар Сентоза арлыг



Эх сурвалж: Аялал жуулчлалын үндэсний төв

Аялал жуулчлал

» бүтээж байхад Малайз улс үүл шүргэсэн өндөр уулын орой дээр казино байгуулсан байх жишээтэй. Харин Дубай 828 метрийн өндөр Бурж Халифа барилгадаа 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө хаяжээ. Энэ мэтээр 935 саяд хүрээд байгаа жуулчдаас аль болох олныг татаж, хэтэвчийг нь тэмтрэхийн тулд улс үндэстнүүдийн дунд ширүүн өрсөлдөөн явагдана. Харин Монголд юу байгаа вэ?

Үүргэвчээ аваад Монголд ир!

Онгон байгаль, нүүдэлчин амьдрал гэх улиг болсон нэр томъёоллоор бид жуулчдыг татах гэж мэрийсээр. Гэтэл монголд ирсэн аялагч энэ бүгдийг ширхэг чихрийн цаас ч гарздалгүйгээр үзэж, сонирхоод авах боломжтой. Улаанбаатараас гарахад л захын монголайл үүдээ дэлгээд угтана шүү дээ. Ер нь дэлхийн жишгээр бол жуулчдын 20 хувь нь “үүргэвчтэй аялагчид”, 20 хувь нь VIP, үлдсэн нь “mass tourism” буюу тур операторуудаар дамжуулаад аялдаг зохион байгуулалттай аялагчид байдаг тухай Аялал жуулчлалын холбооны дэд ерөнхийлөгч Н.Эрдэнэбат ярьж байсан. Гэтэл Монголд “үүргэвчтэнүүд”-ийн нийт жуулчдын дунд эзлэх жин 30-40 хувь болоод ирж байна шүү дээ. Зочид буудалд тав хоночих чадалгүй хэтэвч нимгэнтэй аялагчид Улаанбаатарыг дүүргэснээр хоногийн 5-10 мянган төгрөг л салгаж чаддаг дэн буудлууд борооны дараах мөөг шиг л олширсон билээ.

2015 он гэхэд нэг сая жуулчин хүлээж авна гэсэн том зорилго өвөртлөөд явж байна, бид. Өнгөрсөн онд Монгол Улсад ирсэн жуулчдын тоо өмнөх жилийнхээсээ 10.8 хувиар өсөж, 456 мянгаас давжээ. Гурав хүрэхгүй сая хүн амтай манай орны хувьд чамлахаар чанга атгах тоо. Гэвч тэдний бидэнд өгч буй мөнгө санаа алдмаар бага байгааг сануулах нь зүйтэй болов уу. 2008 онд манай аялал жуулчлалын салбар 236.9 сая ам.долларын орлоготой байсан бол 2010 онд энэ үзүүлэлт 222.4 сая ам.доллар болж буурсан байна шүү дээ.

Гэхдээ энд бас нэг асуудал бий. Өнгөрсөн жилийн байдлаар нийт 557 мянган хүн манай хилийг давсны 456 мянга нь “жуулчин” гэх ангилалд багтсан гэнэ. Хил хамгаалах ерөнхий газраас гаргадаг Монгол Улсад ирж буй гадаадын зорчигчдын тоо нь аялал жуулчлалын салбарын статистик мэдээллийн эх сурвалж болдог ажээ. Харин энэ нь Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тавьдаг шаардлагыг хангахгүй байгааг учир мэдэх хүмүүс тэмдэглэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, дээрх 456 мянган “жуулчны” дотор орос наймаачид, хятад барилгачид цохиж яваа нь тодорхой.

Ер нь бид аялал жуулчлалын хөгжил гэдгийн дор жуулчдын тоо өсөөд байхыг ойлгож байна уу, эсвэл тэднээс авах мөнгө арвижаад байхыг хэлж байна уу? “Утаагүй үйлдвэрлэл” нь дэлхийн бизнес болсон учраас аль болох ашигтай ажиллах нь монголчуудын зорилго баймаар юм.


Тооны биш, чанарын хувьсгал хэрэгтэй

“National Geographic” сэтгүүлээс нэрлэсэн 2011 оны шилдэг 20 аяллын тоонд Улаанбаатар хот оржээ хэмээн манай хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд хэсэгтээ шуугисныг Та санаж байгаа байх. Ямар сайхан мэдээ вэ хэмээн баярлахаасаа өмнө тодотголыг нь уншаад үзэх үү? “Энэ хотод бага мөнгөөр олон зүйл үзэх боломжтой, бас хямдхан бэлэг дурсгалын зүйлс бөөндөх сайн талтай”... Гэтэл бусад орон ирсэн жуулчдаа таван одтой зочид буудалд буулгаж, тансаг зэрэглэлийн үйлчилгээ үзүүлж, үнэтэй брэнд бүтээгдэхүүнүүдээ зарж, товчхондоо, халаасыг нь олигтойхон сэгсэрчихийг бодно. Үүнээс үзэхэд бид дэлхийн хөгжлөөс

гээгдсэн “хямдхан Монгол” ажээ. Яагаад ийм байдалд орчихсон юм бол оо? Үнэндээ бидэнд мөнгөтэй жуулчдад үзүүлэх олигтой үйлчилгээ бий бил үү? VIP зэрэглэлийн аялагчид шороон замаар таваргаж, модон жорлонд бие засаад явахгүй нь лавтай. Зузаан хэтэвчтэй жуулчдыг татахын тулд бидэнд адаглаад л Улаанбаатараас Хар Хорин орох сайн зам хэрэгтэй. Уг нь дэлхийн талыг эзэгнэж явсан том түүх, онгон дагшин байгаль, үлэг гүрвэлийн олдвор, нүүдэлчин, малчин, дархан цаазат ан амьтан гээд жуулчдыг татах зүйл Монголд хангалттай бий. Давуу талаа ашиглаж, далайцтай ажил хийх зорилго байгааг тэмдэглэж, сайшаах нь зүйтэй болов уу.

2012-2015 онд “Хархорин XIII зуун” цогцолбор төслийг хэрэгжүүлнэ гэж байгаа. Түүх соёлын, рашаан сувиллын, археологийн судалгааны аялагчдад зориулан хөгжүүлэх энэ цогцолбор Хархорин музей, сүм дуган, эртний уран барилга, баримал, үзмэрүүд багтах ажээ. Бас болоогүй, ресторан, зочид буудал, шөнийн клуб, хамгийн гол нь онгоцны буудал баригдах гэнэ. Энэхүү цогцолборыг ашиглалтад оруулснаар 2000 гаруй ажлын байр шинээр бий болох тооцоо ч гарсан байдаг. Түүнчлэн Хөвсгөл далайн эрэгт “Хорьдол сарьдаг” амралт зугаалгын цогцолбор байгуулах, Өмнөговь аймгийн Баянзаг орчимд палеонтологийн томоохон музей, эрдэм шинжилгээний төв барих, Хэнтийн бүсэд дэлхийн хамгийн том гэр-тэрэг бүхий музей байгуулж, Чингис хааны үеийн цэрэг армийн сүр хүчийг гайхуулах гээд олон сайхан санаа байна.

Цаасан дээр амилсан энэ бүх санааг амьдрал дээр хэрэгжүүлж чадваас бид тооны биш, чанарын хувьсгал хийж чадах буюу. Тэр үед Монголд ирэх жуулчдын тоо сая байна уу, хагас сая байна уу хамаагүй, харин тэднээс олох орлого хэдэн зуун саяар биш, хэдэн тэрбум ам.доллараар тоологдох вий. Аялал жуулчлалын дэд бүтэц гэх юм бараг үгүй атал өнөөдөр Монголыг зорих хүн байсаар байхад жуулчдыг татах юмтай болсон цагт тэнгэрээс од шүүрч чадна гэтэгт итгэж болмоор. Ялангуяа хөгжиж буй орнуудад ирэх жуулчдын тоо өсөж байгаа тухай сайхан мэдээ олон дуулдах болсон нь бидний хувьд сайхан боломж, завшаан олгож байгаа билээ. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын судалгаанаас үзэхэд Азийг зорих аялагчдын тоо өнгөрсөн онд 13 хувиар нэмэгдэж, 204 саяд хүрсэн байна шүү дээ. Юутай ч амны бэлгээс ашдын бэлгэ гэж монголчууд ярьдаг. Дэлхийн бэл бэнчинтэй жуулчид биднийг зорих цаг ирнэ. Монголд тавтай морилно уу?



Эх сурвалж: Аялал жуулчлалын үндэсний төв

The Mongolian Economy, June & July

Салбарын хүний үг

Н.Эрдэнэбат: Төрөлжсөн аялал жуулчлал хөгжинө гэдэг тухайн салбар чөмөг сууж буйн ШИНЖ

Аялал жуулчлалын холбооны дэд ерөнхийлөгч Н.Эрдэнэбаттай ярилцлаа.

-Монголын аялал жуулчлалын салбарын хөгжил ямаршуу байна вэ?

-Аялал жуулчлал хөгжихгүй байна гэж шүүмжилдэг хүн байдаг л даа. Гэхдээ жилд 10-15 хувийн өсөлттэй л байна. Монголчууд ч гадаадад аялах нь өссөн. Энэ салбарт удсан хүний хувьд гишүүдээ сайн мэднэ. Хөтөч тайлбарлагчдын ур чадвар сайн, гадаад хэлний мэдлэг ч өндөр. Манайхан хэдий ази царайтай ч биеэ авч явах, нээлттэй байдал нь европ маягийн хүмүүс гэдэг.

-Гэхдээ тооноос илүү чанар чухал гэж ярьдаг. Монголд ирэх жуулчдын тоо өссөн ч “үүргэвчтэй аялагчид” хэт олон байгааг Та юу гэж үздэг вэ?

-Тийм ээ, Монголын нөхцөлд тоо нь чанар болоод байгаа. Үнэхээр тоо өсөж байгаа ч жуулчдын бүтэц өөрчлөгдөөд байна. Тавхан хувьтай байсан “үүргэвчтэй аялагчдыг” арван жилийн дотор 30-40 хувь болгоод оруулаад ирлээ шүү дээ. “УАЗ Фургон” маркийн машинд 10-20-иороо суугаад, 5-10 мянган төгрөгийн “guest house” буюу дэн буудалд хоноглоод, ус, талхаар Монголыг үзчихдэг “үүргэвчтэй аялагчид” 30-40 хувь болж өссөн гэсэн үг. Энэ нь цаагуураа бас сөрөг үр дагавартай. Нэг айл “үүргэвчтэн”-д морь унуулаад, 10 мянган төгрөг авсан л бол хүн амын орлогын албан татвар төлөх ёстой, гэтэл үгүй ш дээ. Ингээд л тэр нь “хар мөнгө” болчихож байгаа юм. Уг нь тур операторуудаар дамжвал тэр мөнгийг нь айлд нь өгөөд, татварт тайлан гаргаад явах юм. Ер нь дэлхийн жишгээр бол жуулчдын 20 хувь нь “үүргэвчтэй аялагчид”, 20 хувь нь VIP, үлдсэн нь “mass tourism” буюу тур операторуудаар дамжуулаад аялдаг зохион байгуулалттай аялагчид байдаг.

Харин манайд “үүргэвчтэй аялагчид” олширч байгааг тооцоход их амархан. 2000 онд Монголд 5-6 дэн буудал идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан бол одоо энэ тоо 20 гарчихлаа. Нийт 189 дэн буудал байна гэсэн бүртгэл



ч гарсан байна билээ. Баянхошуу, Баянзүрхэд хүртэл байх жишээтэй.

-Тэгвэл “үүргэвчтэй аялагчдын” тоог багасгахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй юм бол?

-Боль гэхийн аргагүй. Дэн буудлуудыг хааж болохгүй, эрэлт нь байгаа л бол тэд амьдрах ёстой шүү дээ. Нөгөө талаас жуулчдыг ялгах эрх бидэнд байхгүй. “Үүргэвчтэн” ч гэсэн жуулчин. Ерөнхийдөө оюутнууд ч юм уу, мөнгө багатай хүмүүс түүндээ тааруулаад Монголыг үзэхийг зорьж байна. Гэхдээ тэд ч гэсэн сурталчилгаа болно гэдгийг мартаж болохгүй. Манайд ирж үзчихээд найз нөхдөдөө очоод “Монголд Луй Вьетон байдаг юм байна. 3D кино гарч байна, интернэт, банкны картны үйлчилгээ хаа сайгүй нэвтэрчээ” гээд л ярина шүү дээ. Тиймээс тэднийг боомилох тухай бодох ёсгүй. Нэг юм хийх гээд нөгөөг нь устгаж болохгүй. Ер нь бид зохион байгуулалттай аялагчдын тоог өсгөх тал дээр муу анхаарсан болохоор л “үүргэвчтэй аялагчид” нэмэгдсэн. Гэтэл зохион байгуулалттай аялыг идэвхжүүлэхэд гадаад сурталчилгаа их хэрэгтэй байдаг. Сүүлийн 20 жилд бид тур операторын хэмжээнд л сурталчилгаа хийгээд байсан. Зохион байгуулалттай аялагчдад зориулсан ерөнхий мэдээлэл хангалтгүй байсан. Танилцуулга мэдээлэл гаргаад, цахим хуудас нээгээд явах нь үр дүн багатай байна. Гадаадынхан Монголын интернэт хаягаар орох нь ховор. Яагаад гэвэл Монгол аялж болох орон гэдгийг мэдэхгүй байна. Мэдээллээ хүргэж чадахгүй байгаа нь өнөөдрийн аялал жуулчлалын салбарын тулгамдсан асуудал болсон.

-Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд яаж анхаарч байна вэ?

-Дэлхийн хамгийн томд тооцогддог “ITB Berlin 2011” үзэсгэлэн өнгөрсөн гуравдугаар сард болоход Монгол Улс соёлын түншээр оролцлоо. Төрөөс анх удаагаа хагас тэрбум төгрөг гаргасан. Гэхдээ энэ мөнгө магадгүй хэд нугараад ороод ирнэ. Учир нь, уг үзэсгэлэн Монголын талаарх нэлээд том сурталчилгаа болж чадсан гэж бид дүгнэж байгаа. Үүний үр дүнд Европоос ирэх жуулчдын

» тоо тав орчим хувиар өсөх болов уу гэсэн таамаглал бий.

Бид өнгөрсөн жил Японы зах зээлд тусгайлан ажилласан. Тус улсын томоохон тур операторууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийг Монголд урьж авчран, гадаад сурталчилгаан дээр нэлээд анхаарсан. Төр ч дэмжээд, Японы жуулчдыг 30 хоногийн хугацаанд визгүй зорчих нөхцөлийг бүрдүүллээ. Үүний үр дүнд Японоос манайд ирэх жуулчдын тоо 26 хувиар өссөн байгаа. Ер нь богино хугацаанд амжилт гаргаж болох зах зээл Япон юм. Нэг талаас энэ орон Монголтой ойрхон. Нөгөө талаас япончууд майхан бариад хөдөө аялаад явах нь ховор. Жуулчны баазад байрлана, бидэнд өгөх эдийн засгийн үр өгөөж нь ч өндөр.

-Энэ онд Японоос ирэх жуулчдын тоо өсөх болов уу. Газар хөдлөлт танай салбарт яаж нөлөөлөхөөр байгаа вэ?

-Өнгөрсөн онд Япон руу гурван нислэг байхад 26 хувийн өсөлт гарсан. Энэ жил МИАТ долоо хоногийн долоон нислэгтэй. Таван өдөр Нарита, хоёр өдөр Осака нисэж байна. Тийм болохоор Японы жуулчид Монголд ирэхэд хүндрэл багатай. Мэдээж бидний хүсэн хүлээж буй үр дүнд Японы газар хөдлөлт нөлөө үзүүлнэ. Гэхдээ япончууд сэргээн босголтыг хурдан хийж байна. Энэ зургадугаар сарын 18-22-нд Японы 50 хүний бүрэлдэхүүнтэй хэвлэл мэдээлэл, аялал жуулчлалын салбарынхан оролцсон баг Монголд ирэх гэж байна.

-Өвлийн аялал жуулчлал гэдэг ч юм уу, ер нь төрөлжсөн аялал жуулчлал хөгжиж байна уу?

-Төрөлжсөн аялал жуулчлал хөгжинө гэдэг тухайн салбар чөмөг сууж буйн шинж л дээ. Өөрөөр хэлбэл хөрөнгөтэй, хуримтлалтай болж байгаа гэсэн үг. Манайд төрөлжсөн аяллын нэлээд хэдэн компани бий. Уулын аялал, адал явдалтай аялал гээд л. Тухайлбал, "Mongolia Bike Challenge" гэдэг нэртэй дугуйн аяллыг ралли хэлбэрт оруулаад хийж байна. Уг ралли энэ оны долдугаарын сарын 20-нд Сүхбаатарын талбайгаас гараагаа эхэлж, 20 гаруй хоногийн хугацаанд үргэлжилнэ. Өнгөрсөн жил энэхүү дугуйн аялалд 100 гаруй сонирхогч орсон бол энэ онд 200 болох төлөвтэй.

-Уулын ам болгонд л бараг аялал жуулчлалын бааз байна. Энэ салбарт маш олон жижиг "тоглогчид" байгааг Та юу гэж үздэг вэ?

-Аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүд маань хэтэрхий жижгэрчихсэн нь үнэн. Хүчин чадал нь бага байгаа учраас хувиа хичээсэн аж ахуйн маягтай болчихсон, хуримтлал үүсгэж, эргээд бизнесдээ хөрөнгө оруулж чадахгүй байна. Эрэлтээсээ давчихсан нийлүүлэлт аялал жуулчлалын салбарт буйн нэг жишээ нь жуулчны бааз юм л даа. Ер нь Монголын 300 гаруй тур оператороос идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нь 60. Тэднээс хамгийн сайн нь 5-6 компани бий. Үүний дотор гаднын нэг компаниас 1000 жуулчин авдаг нь ганц, хоёрхон.

-Дэлхийн жишгээр бол жуулчдын 20 хувийг VIP аялагчид эзэлдэг гэж Та хэлсэн. Монголд VIP жуулчин ер нь ирдэг юм уу?

-Харьцангуй цөөхөн ирдэг л дээ. 5-10 хувьтай л байгаа болов уу. Монголд таван одтой зочид буудал байгаа ч зам нь хаа байгаа юм бэ? Өндөр зэрэглэлийн аялагчид шороон замаар давхиж Монголыг үзэхгүй нь лавтай. Уг нь ийм аялагчид их мөнгө төлж чадна. Харамсалтай нь манайд тэдэнд үзүүлэх үйлчилгээ тааруу. Яах вэ, уул уурхайн буянаар VIP аялагчдын тоо сүүлийн үед өсөж

байна. Таван одтой буудалд буучихаад, уул уурхайн хэлэлцээрээ хийчихээд, ганц хоёр хоног аялал хийчихээд буцдаг хүмүүс олширч байгаа гэх үү дээ. Гэхдээ энэ тал дээр манай компаниудын хурд, сэтгэлгээ хоцроод байх шиг санагддаг. Хаана олон улсын том хурал болох гэж байгааг мэдээд, оролцогчдод нь аяллын хөтөлбөрөө танилцуулаад аваад явах санаачилга дутмаг байх шиг байна.

-Уул уурхай аялал жуулчлалын салбарынхныг хүнд байдалд орууллаа гэж яриад байгаа. Долларын ханш сулрахын зэрэгцээ хэлний мэдлэг сайтай, өндөр чадвартай мэргэжилтнүүдийг уул уурхайн компаниуд мөнгөөр зодоод "урвуулчихаад" байна гэх юм...

-Энэ нь зөвхөн аялал жуулчлал ч биш, бүх салбарт л ажиглагдаж байна шүү дээ. Төр энэ тал дээр бодлого гаргаад яаралтай арга хэмжээ авах ёстой. Бид Монголбанкинд ханшийн хэлбэлзлийн талаар асуудал тавихад Л.Пүрэвдорж ерөнхийлөгчөөс хариу ирсэн л дээ. Банк хоорондын хэлцлүүд байдаг юм байна, тэрийг нь бид ашиглах боломжтой юм билээ. Энэ мэтээр бид өөрсдөө идэвхтэй ажиллах хэрэгтэй. "Өө, асуудал гараад ирлээ" гээд суух биш, шийдэх арга замаа бодох ёстой. Валютын ханшийн асуудал зөвхөн энэ жил биш, ирэх жилүүдэд ч газар авах шинжтэй байна. Үүний хажуугаар үнэ нэмэгдээд байгаа нь бас нэг дарамт болж байгаа л даа. Монголд бараа, үйлчилгээ үнэтэй болчихдог, дагаад үнээ өсгөх гэхээр чаддаггүй, бусад орноос үнэтэй болоод, өрсөлдөх чадвараа алдах гээд байдаг. Мэдээж энэ нь аялал жуулчлалын компаниудад хүнд тусна. Тэглээ гээд бид төрийг үнэ хямдруул гэж болохгүй шүү дээ. Бид өөрсдөө хөдлөх ёстой юм, яагаад гэвэл бид л бизнес хийж байгаа. Манай жуулчны баазууд хамжиж, хамтрах хэрэгтэй. Ингэснээр боловсон хүчний орон тоо хэмнэнэ, төрд дуу хоолойгоо хүргэнэ, зар сурталчилгааны хөнгөлөлт эдэлнэ, үйлчилгээний шинэ туршлага харилцан солилцоно, үнийн хүндрэлээс гарна гээд олон сайн талтай. Тэнд 100 хүнтэй, энд 100 хүнтэй, харин зочид буудал хоногийн 100 доллар гээд байдаг. Тэвэл хоёулаа нийлээд 200 хүн оруулья, 90 доллар болгоод хямдруулчих гэж болно шүү дээ. Тэр зочид буудал нь ч 200 хүн авахын тулд үнээ буулгана. Товчхондоо, бид хамтарч, нэгдэж байж л хүндрэлийг даван туулах юм.

-Уул уурхайн орлогоороо бусад салбараа төрөөс дэмжинэ л гээд байгаа. Тэгвэл аялал жуулчлалын салбарт энэ нь мэдрэгдэж байна уу?

-Уул уурхайн орлогыг аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах гэж төр ч төлөвлөж байгаа юм билээ, бид ч хүсэж байгаа. Яагаад гэвэл энэ хоёр салбар маань бусад салбараа хамарчихдаг. Ер нь бид өнөө маргаашийн тухай ярих хэрэггүй. Урт хугацааны бодлого хэрэгтэй. Аялал жуулчлалын салбар маань жилдээ 10-15 хувийн өсөлттэй байгаа. Гэхдээ одоо тооноос чанарт шилжих цаг иржээ. Зохион байгуулалттай жуулчдыг нэмэгдүүлэх ёстой. Нэг компаниас 1000 жуулчин авдаг компани Монголд ганц, хоёр байна гэдэг чамлахаар үзүүлэлт шүү дээ. Эхний ээлжинд 5-10 болгох хэрэгтэй, цаашдаа 100 болгох зорилго өвөрлөх учиртай. Японоос л гэхэд жилд 20 сая хүн гадагшаа явдаг. Бид гэтэл тэдний 13-хан мянгыг л авч байгаа. Тэгвэл 20 мянган япон жуулчин авах гээд ажиллая л даа. Энэ мэт алсыг харсан бодлого хэрэгтэй.

Ирээдүйтэй төсөл

Монголын элсэнд зөвхөн ашигт малтмал байна гэж үү?

Д.Мөнхчимэг

Зэс, алт, нүүрс, уранаас эхлээд газрын ховор элементийн асар их баялаг уудам Монголын газрын хэвлийд оршиж байгаа билээ. Оюутолгой, Тавантолгойгоороо дэлхийг гайхуулж, ашигт малтмалын нөөцөөрөө аргагүй толгой цохих улс аа, бид. Гэхдээ өвөг дээдэс минь бидэнд үүнээс ч илүүг өвлүүлэн үлдээсэн байна. Манай говийн элсэнд палеонтологийн асар үнэт олдворууд нуугдаж байгааг, Өмнөговийн Булган сумын нутаг орших Баянзаг маань үлэг гүрвэлийн өлгий нутаг хэмээн алдаршсаныг гаднынхан мэддэг ч бид өөрсдөө нэг л хайхрамжгүй ханддаг нь гайхалтай. Энэхүү баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулах аваас уул уурхайгаас ч илүү ашиг олж чадахыг сануулах нь зүйтэй болов уу.

Нэгэн үе дэлхийн талыг эзэгнэж байсан монгол үндэстнийг ХХ зуун хүртэл соёлт ертөнц мартсан байлаа. Гэвч Рой Чапмэн Эндрюс тэргүүтэй Америкийн Байгалийн түүхийн музейн судалгааны багийн 1920-иод онд Монголын говь нутагт хийсэн ажил дэлхийг ёстой л алмайруулсан байдаг. Төв Азийн эх цөлийн цээжинд орших манай нутаг цөөнгүй гадаад оронд Монгол Улс гэдгээсээ илүүтэй Монголын говь (Mongolian Gobi) гэдэг нэрээрээ шууд танигддаг нь үүнтэй холбоотой буюу.

Эртний хүн төрөлхтөн Арц Богдын өвөр хоолой, Төгрөгийн ширээ, Баянзагийн заг, элсэн манханд амьдран суурьшиж байсныг, олон зууны тэртээгээс Европ Азийг холбосон алдарт Торгоны зам манай нутгаар дайран өнгөрдөг байсныг Эндрюс соёлт ертөнцөд таниулан сурталчилсан билээ. Тэрбээр Монголын говиос палеонтологийн гайхамшигт олдворуудыг олж, үлэг гүрвэлийн өндгөө нуусан газрыг анх удаа нээснээр Ази Тив бол Европын, Америкийн амьтдын өлгий нутаг гэдгийг баталж чадсан юм.

Эндрюсийн бичсэн номнууд, судалгааны багийнх нь хийсэн



дүрс бичлэгүүд олон хүний хорхойг хүргэж, Монголын говь руу далласан байдаг. Үүний нэг тод жишээ нь 10 настай бяцхан хүү Баянзагаас үлэг гүрвэлийн өндөг олсон тухай сэтгэл догдлон уншдаг байгаад хожим нь Америкийн Байгалийн түүхийн музей хийгээд Монголын Шинжлэх ухааны академийн хамтарсан Палеонтологийн шинжилгээний ангийн ахлагчийн нэгээр ажиллах болсон явдал билээ. Энэ тухайгаа Америкийн Байгалийн түүхийн музейн Палеонтологийн хэлтсийн дарга доктор Марк Норелл “Эртний хүний мөрөөр” ном анх удаа монгол хэлнээ хэвлэгдэхэд онцлон бичжээ.

Тухайн үеийнхээ хамгийн шилдэг судлаачдын нэг Рой Чапмэн Эндрюсийн говьд явуулсан судалгааны ажил тэр цаг үеийн хамгийн далайцтай, басхүү хамгийн үнэтэйд тооцогдож, шуугиандэгдээж байв. Судалгааны ажилд таван жил, 250 мянган ам.доллар хэрэгтэй гэсэн тооцоо гарч байжээ. Ингээд Эндрюс маань Ж.П.Моргантай уулзаж, Төв Азийн газрын зургийг гаргаж ирээд судалгааны ажлын төлөвлөгөөгөө 15 хормын дотор танилцуулснаа өөрийн номдоо бичсэн байдаг. Үүнийг сонссон

нэрт хөрөнгө оруулагчийн нүдэнд сонирхлын оч гэрэлтэж, “Наадах чинь сайхан төлөвлөгөө байна. Яаж санхүүжүүлэх юм бэ? Би яаж туслах вэ?” хэмээн уулга алджээ. Ийнхүү Эндрюсийн шинжилгээний ангидаа мөнгө олох хамгийн эхний уулзалт амжилттай болсон явдал нь Америкийн толгой баячуудын нэг, өнөөгийн “J.P.Morgan” хөрөнгө оруулалтын банкны үндэслэгчийн анхаарлыг Монгол орон татаж байсныг гэрчлэх биз ээ.

Дэлхийн II дайны дараагаас Оросын судалгааны баг Монголд ирээд, олон шинэ олдвор бүхий газрыг нээсний нэг нь Нэмэгт юм. Эндээс оросууд өмнө нь хэний ч мэддэггүй байсан 30 метрийн өндөртэй, өвсөн тэжээлт үлэг гүрвэлийн олдворыг нээж, Нэмэгтстраус хэмээн нэрлэсэн нь бий. Үүний дараа Польш-Монголын хамтарсан судалгааны баг Баянзагийн ойролцоох Төгрөгийн ширээ хэмээх газраас 1971 онд “Ноцолдож буй үлэг гүрвэлүүд” олдвороо олсон нь дэлхийг гайхшруулж байсан удаатай. Гэвч энэ бүхэн Монголын өргөн уудам говь нутагт нуугдаж буй гайхамшигт зөвхөн нэгээхэн хэсэг юм. Учир нь, манай орны палеонтологийн

» судалгааны ажил хэдэн зууны түүхтэй биш шүү дээ. Бусад оронтой харьцуулахад цөөн тооны судалгааны баг Монголын говьд үйл ажиллагаа явуулсан ч дэлхийд үнэлэгдэх шинэ олдворуудыг нээж чадсан нь нэгийг өгүүлэх шиг.

Өнөөдөр бид Оюутолгойгоо ашиглаж эхэлж байна, Тавантолгойгоо тун удахгүй эдийн засгийн эргэлтэд оруулна гэж байгаа. Монголын хөгжлийн зүтгүүр болж буй уул уурхай биднийг хэдэн үеэр нь тэжээнэ хэмээн ард түмэн хүлээж буй. Нөөцөөрөө дэлхийд дээгүүртэрэмбэлэгдэх стратегийн ач холбогдол бүхий ордуудаа бушуухан ашиглаад эхлэхэд л бүх зүйл сайхан болчих гээд байгаа мэт санах аж. Гэвч эдийн засгийн эргэлтэд оруулж их мөнгө олж болдог нь зөвхөн ашигт малтмалын орд газрууд биш ажээ. Говь гурвансайхан байгалийн цогцолборт газрын орчим Баянзаг, Төгрөгийн ширээ, Хэрмэнцав, Алтан уул, Бүгийн цав Гурилын цав зэрэг газар үлэг гүрвэлийн олдвороороо дэлхийд хамгийн баялаг болох нь нэгэнт нотлогдсон. Бид үүнийгээ ашиглаж палеонтологийн аялал жуулчлалыг хөгжүүлж чадвал асар их ирээдүй байгаа юм.

Ганцхан жишээ дурдахад л Канадын “Royal Tyrrell Museum” палеонтологийн музей 1985 онд байгуулагдсанаасаа хойш жилдээ л хагас сая хүн хүлээж авдаг болжээ. 2010 онд 10 сая дахь үзэгчээ угтсан энэхүү музейн клубт нэг жилийн хугацаатай элсэхийн тулд 500-50 мянган ам.долларын төлбөр өгч байгаагаас үзэхэд энд ямар их мөнгө эргэлдэж байгаа нь тодорхой. Тэгвэл гадаад, дотоодын палеонтологчдын арааны шүлсийг Монголын үлэг гүрвэлийн өндөг, яс асгаруулсаар байгааг сануулах юун. Яагаад бид энэ боломжоо ашиглаад, дэлхийн хэмжээний ганц музей байгуулчихаж болохгүй гэж?

Өнөөдөр манай оронд ихэвчлэн бага мөнгө зарцуулдаг “үүргэвчтэй аялагчид” ирдэг болсон нь нууц биш. Тэгвэл палеонтологийн аялал жуулчлалыг хөгжүүлж чадсанаар бид зузаан хэтэвчтэй жуулчид хийгээд мэргэжилтнүүдийг татаж, эдийн засагтаа их мөнгө шингээж чадах нь лавтай. Өнөөдөр ч гэсэн Монголд ирчихээд, үлэг гүрвэлийн өлгий нутаг хэмээх Баянзагийг үзэхгүй, харахгүй өнгөрдөг жуулчин гэж үгүй.

Түүнчлэн гадаадын судлаачид, ялангуяа Америкийн Байгалийн түүхийн музейн мэргэжилтнүүд жил бүр энд ирж, судалгаа явуулдаг ажээ. Тэгээд олсон олдворуудаа Палеонтологийн хүрээлэнд тушаадаг ч заримыг нь судлаад эргүүлж авчрахаар нутаг руугаа аваад явдаг байна. Тэгвэл Баянзаг орчимд үлэг гүрвэлийн томоохон хүрээлэн, эрдэм шинжилгээний төв байгуулчих юм бол судлаачид бүтэн жилийн турш тэндээ байж, олсон олдворуудаа газар дээр нь судалж, Монголын эдийн засгийг илүү их мөнгөөр услах бус уу?

Ёлын ам, Хонгорын элс зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд, хавтгай, мазаалай, ирвэс, хулан, аргаль, янгиртэргүүтэй ховорамьтад, ёл, хойлог, шонхор зэрэг жигүүртэн нутагладаг сайхан газар бол яах аргагүй Монголын говь юм. Тэгвэл байгалийн сайхныг үзээд, ховор амьтдыг ажиглаад, палеонтологийн судалгаа хийх бүрэн боломж энд бий шүү дээ. Харамсалтай нь жуулчид болоод судлаачид тав тухтай амарч, ажиллаж, Монголын эдийн засагт аль болох их мөнгө оруулах боломж нь өнөөдөр алга.

Эдүгээ говийн бүсэд ихэнх жуулчин зөвхөн зуны улиралд ирдэг бөгөөд Түмэн тэмээний баяраас өөр үзвэрийн арга хэмжээ болдоггүй. Үүний хажуугаар судлаачид палеонтологийн олдворуудаа судлах боломж нь ч байхгүй. Өнөөдөр үүсэн байгуулагдсанаасаа хойш их засварын нүүр үзээгүй нэгэн жарныг үдсэн Байгалийн түүхийн музейд орших үлэг гүрвэлийн араг ясыг харж, сонирхох л боломжтой. Гэтэл олон тооны үнэт олдвор тоосонд дарагдаад агуулахад хэвтэж байгаа нь харамсалтай.

Уг нь өмнөговьчууд үлэг гүрвэлийн хүрээлэн бий болгох тал дээр анхаарч эхлээд багагүй хугацаа өнгөрч байгаа юм билээ. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас энэ ажилд 100 сая төгрөг гаргахаар шийдвэрлэжээ. Анхандаа үлэг гүрвэлийн хүрээлэнг Баянзагийн орчимд байгуулна гэж ярьж байсан ч тэндээс 18 км-ын зайд орших Булган сумын хажууд ч барьж магадгүй гэнэ. Гэхдээ 100 сая төгрөгөөр үлэг гүрвэлийн хүрээлэн байгуулах нь битгий хэл загвар төслөө гаргахад ч хүрэлцэхээргүй байж мэднэ шүү дээ. Энэхүү ажилд 1.5 тэрбум

төгрөг шаардлагатайг мэргэжлийн хүмүүс нь ярьж байна. Уг нь төрөөс энэ тал дээр анхаараад, хөрөнгө мөнгөө харамгүй өгч, нэгмөсөн Канадын “Royal Tyrrell Museum” палеонтологийн музейн дайтай дорвитой ажил хийчихвэл хожим нь монголчуудыг жинхнээсээ хэдэн үеэр нь тэжээх мөнгөний уурхай болох бус уу? Басхүү байгалийн сайхныг дэлхийд гайхуулж, сурталчлах зэвсэг ч болж чадах биз ээ.

“Яагаад Монголд ирж буй жуулчин болгон Баянзагийг үзэхээр ирдэг юм бэ? Энэ бол дэлхийд танигдчихсан газар учраас тэр шүү дээ. Гэтэл хятадууд Эрээнээс зүүн хойшоо байрлах Эрээнцавын орчимд маш том үлэг гүрвэлийн хүрээлэн байгуулсан. Рой Чапмэн эндээс л түүхэн олдворуудаа нээсэн мэт домгийг манай урд хөрш гаргаад ирсэн учраас хүмүүс тийшээ хошуурч байна. Гэтэл Рой Чапмэн үлэг гүрвэлийн анхны өндгөө Баянзагаас л олсон шүү дээ. Энэ бол үлэг гүрвэлийн өлгий нутаг, дэлхийн шинжлэх ухааны түүхэнд тэмдэглэгдэхүйц газар юм. Бидэнд үүнийг том ажил болгох боломж байгааг ойлгох хэрэгтэй. Үлэг гүрвэлийн хүрээлэн байгуулах нь ямар их ашигтайг мэдрэх учиртай” хэмээн “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбооны тэргүүн Х.Түмэндэлгэр тэмдэглэсэн юм.

Манай оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд, 8000 орчим илрэл бүртгэгдсэн хэмээн бид хөөрцөглөдөг. Харин шим ертөнцийн хөгжлийн түүхийн ховор нандин баримт болох палеонтологийн олдвороор Монголын говь үлэмж баян гэдгийг таг мартжээ. Өвөг дээдсийн минь өвлүүлэн үлдээсэн энэхүү гайхамшигийг бид хайрлан хамгаалж, гаднын жуулчид, мэргэжилтнүүдэд зүгээр л гайхуулж харуулаад асар их мөнгө олох боломж байгааг төрийн эрх баригчдад ахин дахин сануулах хэрэгтэй болов уу. Өмнийн говийн элснээс зөвхөн ашигт малтмал хайж, олсон бүхнээ олборлохын тулд чичирж дайрахаа түр азная. Тэртэй тэргүй одоо ашиглалтад орсон уурхайнуудаас Монгол орон хангалттай их мөнгө олж байгаа учир үлэг гүрвэлийн өлгий нутгаа эдийн засгийн эргэлтэд оруулъя. ■

Инээмсэглэл

Хавай арлын аялал жуулчлалын нууц



<http://www.mongolianeconomy.mn>

“Алоха” инээмсэглэл

“Алоха” буюу “Сайн байна уу” хэмээн жуулчдыг инээмсэглэн угтах хавайчууд их найрсаг, хөгжилтэй сайхан сэтгэлтэй. Тэдний энэхүү инээмсэглэл гадаадын жуулчдыг татах гол хүч гэж хэлэх үндэстэй. Үүнийхээ хүчээр хавайчууд өнөөдөр элбэг хангалуун амьдардаг гэдгийг дэлхийн эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн байдаг юм билээ. Өөрөөр хэлбэл, хавайчуудын гадна дотнын жуулчдыг угтан авах чин сэтгэлийн инээмсэглэл тэдний амьдралын баталгаа болдог гэж ойлгож болно.

XVI зуунд дэлхийн бараг хамгийн ядуу буурай байсан уг арал өнөөдөр таван тивийн хүмүүсийн очихыг хүсдэг мөрөөдлийн газар нь болж хувирчээ. 1700-гаад онд тус арал дээр өнгөт арьст поленесчууд амьдардаг байж. Харин 1778 онд их далайд аялж явсан нэгэн европ хүн анх энэ арлыг нээсэн гэдэг. Түүнээс хойш арал руу зүүн Америкийн орнуудын цагаан арьстнууд олноор нүүдэллэн очиж, газар тариалан эрхлэх болсон түүхтэй. Ази, Америк тивийг холбосон ашигтай байрлалтай энэ газар нэгэн үе япон, америкчуудын харилцааг муутгаж байсан гашуун түүх бас бий. Эзэрхийлэл, түрэмгийлэл, дайн байлдаан багагүй амссан Хавайн арлынхан 1959 оны наймдугаар сарын 21-нд АНУ-ын 50 дахь мужаар албан ёсоор зарлагдсан билээ.

Америкчууд тус арлыг эгнээндээ нэгтгэснээс хойш маш их хөрөнгө хаясны үр дүнд дэлхийн иргэдийн сонирхлыг татахуйц аялал жуулчлалын хамгийн том төвийг байгуулсан. Өнөөдөр энэ аралд жилдээ 8-9 сая жуулчин зочилдог гэхээр ямар их хөдөлмөр хүч, мөнгө зарцуулсныг харуулах биз. Тиймээс ч Номхон далайн гүн цэнхэр усаар хүрээлүүлсэн үзэсгэлэнт байгаль, зөөлөн агаар, өндөр хөгжил, иргэдийнх нь тайван амьдрал гээд бүх зүйл нь гайхалтай зохицсон энэ арал жуулчдыг соронзон мэт татдаг юм. Хавайн уугуул иргэд бор царайтай, олонх нь махлаг. 1852 онд энэ арлын 90 хувь нь нутгийн уугуул иргэд байсан бол өдгөө тав орчим хувийг л эзлэх болж. 1523 мил урт, 10459 ам дөрвөлжин газар нутагтай Хавайн нийслэл нь Хонулулу хот. Тус хотод хамгийн алдартай аялал жуулчлалын томоохон Waikiki төв бий. Энд гадаадын жуулчид олноор очиж шар айраг уунгаа Хавайн арлын соёл урлагийн тоглолт үзэж, далайд сэлж, эрэг дээр нь биеэ шарна. Зөвхөн жуулчид бус, нутгийн иргэд нь ч ийм маягаар амарна. Хавайчууд ажил хийдэггүй, байнгын амралтад байгаа юм шиг сэтгэл төрүүлэх нь бий. Гэхдээ тус арлынхан элсэн чихэр, кофе, төрөл бүрийн жимсний үйлдвэрлэлээр дэлхийд нэлээд дээгүүрт ордог гэж үзэхээр тэд ажлаа ч хийнэ, бас амарч ч чаддаг.

“Монгол инээмсэглэл”

Тэгвэл агуу их түүхтэй монголчууд бид яагаад аялал жуулчлалын салбараа Хавай шиг хөгжүүлж дэлхийн хүмүүсийг эх орондоо татаж чадахгүй гэж. Уг нь гаднынхан манай улсыг сонирхож, жуулчлахыг ихэд хүсдэг юм билээ. Гол бэрхшээл нь аялал жуулчлал нь өндөр хэмжээнд хөгжөөгүй, зам тээвэр, өөрөөр хэлбэл, аялал жуулчлалын дэд бүтэц хөгжөөгүй байгаа нь асуудал болж байна. Үүнээс гадна хамгийн том асуудал бол бид жуулчдад үнэн сэтгэлийн үйлчилгээ үзүүлж чадахгүй байгаа юм. Алс орноос Монголыг зорин ирэх жуулчдыг ядахдаа чин сэтгэлээсээ инээмсэглэн угтаж ч чадахгүй байна шүү дээ. Жуулчдын хувьд тухайн орныг үнэлэх хамгийн эхний үзүүлэлт нь иргэдийн инээмсэглэл, харилцааны соёл байдаг. Олон мянган км-ийг туулаад, манай орныг зориод ирэхэд нь монголчууд хөмсөг зангидсан баргар царайтай угтахаар жуулчид анхандаа ихэд гайхдаг гэсэн. Би ямар алдаа гаргалаа ч гэж боддог гэсэн шүү.

Японы нэг жуулчин манай улсад 14 хоног зочлохдоо нэг л юм үгүйлэгдээд байна, тэгсэн мөртлөө яг юу вэ гэдгээ мэдэхгүй байна аа л гээд байж. Гэтэл тэр жуулчныг явахын урд өдөр байнга ордог зоогийн газрын үйлчлэгч нь сайн яваарай гээд инээмсэглэжээ. Мөнөөх жуулчин тэр даруйд үгүйлэгдээд байсан зүйл нь инээмсэглэл болохыг ойлгож, тэрхүү монгол залуугийн чин сэтгэлийн инээмсэглэл Монгол орныг хэзээ ч мартагчид хүргэлээ гээд сэтгэл хангалуун нутаг буцсан тухай манай аялал жуулчлалын мэргэжилтэн ярьж билээ.

Тиймээ монголчууд бид жуулчдад инээмсэглэн үйлчилж чадахгүй байгаа нь үнэн. Монголын үзэсгэлэнт сайхан байгаль, үндэсний хоол, язгуур урлаг тэдэнд таалагддаг. Дэд бүтэц хөгжөөгүй, үйлчилгээний соёл тааруу гээд олон асуудлыг тэд ойлгодог. Ганцхан жуулчдад инээмсэглэл тодруулсан харилцааны соёл байхгүйг тэд ойлгодоггүй гайхаад байдаг юм. Гаднынхан битгий хэл, дотоодын жуулчид үгээ хэлэх нь олонтаа шүү дээ. Тэгэхээр нарлаг хөх тэнгэр шигээ сэтгэл тэнүүнээр нүүрэндээ инээмсэглэл тодруулан гадна, дотнын жуулчдаа угтан авч, үдэж яагаад болохгүй байна вэ? Инээмсэглэхэд гарз гарахгүй шүү дээ, монголчууд аа.

Хавайн давуу тал бол иргэд маань гадаадын жуулчдад “Алоха” буюу “Сайн байна уу” гэж мэндлэхээс эхлээд “Алоха” буюу “Баяртай” хэмээн үдэх хүртэл тэдний сэтгэлд хүрсэн үйлчилгээг үнэн сэтгэлээсээ үзүүлж чаддаг оршдог хэмээн Хавайн аялал жуулчлалын мэргэжилтнүүд хэлснийг энд онцлон тэмдэглэе. ■

Нэрэлхүү дамшиг



А.Амарсайхан

З ах нь үл харагдах говийн дунд дугуйтай ганц хүнийг хармагцаа Лутаа өвгөний нүд оройдоо гарав. Хурц наранд шарагдаж, халууцаж ядарсан шар толгойтой эр дөрөөгөө арай ядан жийж, жолоогоо замын элсэнд мурилзуулан зүтгэнэ. Гадаадын жуулчин бололтой энэ залуугийн шар царай, нүцгэн булчингууд наранд түлэгдээд, нүд хальтрам улаан ягаан болсон харагдана. Хүүхний шиг урт, буржгар үс нь ширэлдэн даахирч, шанааг нь дагаад шороотой хөлс урсжээ.

-Аймаг ортол 300 килмээтэр. Энэ амьтан яана даа? гэж өвгөн үглэв.

-Доонийчихоод яг миний хүү шиг юм гээч. Нялх амьтан цангаж яваа. Аваад явъя! хэмээн Лутаа гуайн самган Долгор орь дуу болов. Аймаг орохоор өвгөний унаанд дайгдсан Намшир гуай харин толгой сэгсэрлээ.

-Наадуул чинь ингэж зовлогоо зовоож амардаг улс гэсэн. Сүүтэй цай өгөхөөр уухгүй, хар ус залгилчихаад явдаг барамнууд гэнэ лээ! гэж хэллээ.

Ингээд Намшир "Ээ дээ, дэмий дээ" гэж үглэн, Лутаа, Долгор хоёр тэс зөрж зүтгэсээр хөөрхий ядарсан залууг машиндаа авч явах шийд гаргав. Өмнө нь гарч, зам хөндөлдөн зогсоход шар толгойтой залуу инээмсэглээд, мэндэлж байгаа бололтой хоёр үг хэлээд мэхийж байна. Лутаа гуай хуучин цагт орос гийлоогч нартай ойр дотно найзалж явсны хэрэг юу билээ, эдэнтэй хэл нэвтэрч ядах юмгүй гэж бардаад,

-Здравствуй, друг! Давай поедем на машине гээд жуулчин руу харлаа. Цаадах нь нүдээ том болгож, юу ч ойлгохгүй байгаа шинжтэй.

-Наадах чинь орос биш англи жуулчин. Яаж ойлгох вэ? гэж Намшир уцаартай дуугарлаа. Эмгэн өвгөн хоёр харь хэлтэй залууд тэрэгний ачаан дээр дугуйг чинь тавиад, өөрийг чинь арын суудалдаа аваад явна гэж дохиогоор ойлгуултал залуу,

-Өө, но но! гэж чанга хашгирч, гараа зангалаа. Тэгснээ хоёр дугуйт унаагаа заагаад, би өөрөө дугуйгаараа явна гэж байгаа бололтой дохио үзүүлж, хан янхийсэн харь аялгатай хэлээрээ баахан ярьж тайлбарлалаа.

-Ална ч гээд байгаа юм уу, тална ч гээд байгаа юм уу бүү мэд гэснээ Лутаа гуай толгой сэгсэрлээ. Долгор харин уурлаж,

-Нүгэл гэм. Юуны чинь алах. Номхон томоотой хүү

байна даг! гэж өвгөнөө зэмлэлээ. Лутаа гуай залуу жуулчны царай руу харан бодол болж байснаа,

-Хөөрхий минь, замын зардалгүй гэдгээ учирлаад байгаа юм биш үү? гэж сэрхийтэл сэтгээд, хашгиран босч ирэв.

-Яаг тийм байж таарах нь! гэж гэж самган нь дуу алдлаа. Өвгөн,

-Деньги не надо! гэж хэлэнгээ өврөө ухан, зузаан бор түрийвчээ гаргаж, арван мянгатын дэвсгэрт харуулаад, гар хуруугаа гозолзуулан дохиж эхэллээ. Сохор зоос ч авахгүй гэдгээ өвгөн сайн гэгч тайлбарлаж, балай хүн ч ойлгохоор дохиж үзүүллээ. Жуулчин залуу дахиад л толгой сэгсэрч, өнөөх "Но но"-гоо хэлэн, улам олон үг шулганан зогсоно.

-Хөөрхий минь, биднийг дээрэмчин тонуулчин гэж айгаад байх шиг байна гэж Долгор эмээ шивнэхэд,

-Магадгүй шүү! Харц нь айсан шинжтэй. Биднийг цагдаад хэлээд сүйд хийх юм биш үү? Орхиод явцгаая! гэж Намшир уулга алдлаа.

-Мы не бандиты! гэж Лутааг тайлбарлахад, найз өвгөний нь тэвчээр барагдав.

-Орос биш гэж мэдсээр байж л оросоор донгосоод байх юм аа, чи! гэж ундууцлаа.

-Чи тэгээд англи хэл мэдэх юм уу? гээд Лутаа гуай дүрсхийтэл уурлав. Барилцаад авах нь холгүй. Хөөрхий залуу, хоёр өвгөн рүү айсан харцаар ширтэн, бүжин нүдээ бүлтэлзүүлнэ. Долгор гуай үүнийг нь харж зогссоноо залууг өрөвдөж,

-Миний муу доёгор хүү хүний газар ингэж л зүдэрч яваа байх даа гээд нулимсаа арчлаа. Америкт сурдаг бага хүүгээ санаснаас болоод цээж нь бачуурсан нь энэ. Эмгэн залууг арын суудалд суу гэж эелдэг дохиод, толгойг нь иллээ. Залуу гуйсан харцаар ширтээд,

-Но но..., гэснээ бас л баахан юм ярилаа. Гурван хөгшин ойлгосонгүй.

-Наад хүү чинь нэрэлхүү гэж байна аа! Миний найз монхор Коля бас нэрэлхүү гэж дүүрчихсэн золиг байгаагүй юу! Би мах сүү өгөхдөө хүчээр тэргэнд нь тавьж явуулдаг байсан шүү дээ! гэж Лутаа хөгшин хашгирлаа.

-Яг үнэн. Нэрэлхүүд байгаа ухаантай юм байна! гэж Долгор эмгэн хэлээд, дугуйг нь шүүрч аваад, ачаа өөдөө өргөлөө. Залуугийн цэнхэр нүд айдсаар дүүрч, ▶

► дугуйнаасаа зуурч, цахдан чирэгдэнэ. Лутаа гуай түүн рүү инээмсэглэж, далыг нь эелдэг алгадаад,

-Хүү минь, нэрэлхээд нэрээ иддэггүй юм аа. Өвөөгийнхөө тэргэнд тухтай суугаад яв! Энэ жилийн ноолуураар авсан цоо шинэ эд дээ! гэж хэлэх зуураа залууг ухасхийн хөлдөж аваад, хүүхэд шиг өргөн хойд суудалдаа шидлээ.

-Ээ дээ, хэдүүлээ хэрэгт орчих юм биш үү! гээд, Намшир зогсоо зайгүй үглэнэ. Хүчинд автагдан орос тэргэнд суусан англи залуу замын турш Монголыг тойрох дугуйн аялал хийж яваагаа учирлаж, би буцаад яг энэ газартаа ирж цааш аялах гэж өчнөөн чирэгдэл болно гэж тайлбарлаж явлаа. Харамсалтай нь гурван хөгшин нэг ч үг ойлгосонгүй. Лутаа гуай,

-Нэрэлхээд нэрээ иддэггүй юм аа, хүү минь гэх өнөөх үгээ хэлж, тарган хонины чанасан мах, нуугисан сайхан

айргийг ам руу нь цутган дайлж явлаа. Намшир гуай байн байн уулга алдаж,

-Ээ дээ, буулгачихсан нь дээр биш үү? гэж үглэж байлаа.

Аймгийн зочид буудлын үүдэнд ирж зорчигчоо буулгасан хөгшид гараа занган баяртай гээд, буржгар шар толгойтой харийн хүүгийн хацар дээр үнсээд хөдөлцгөөв.

-Нэрэлхүү ч дамшиг бол доо! гэж Лутаа гуай хэллээ.

-Яг л миний хүү шиг гэж Долгор уулга алдаад, нулимсаа арчлаа. Харь хэлийн залуу харин, тус болох гэж үнэн сэтгэлээсээ зүтгэсэн, цагаан цайлган хөгшдийн сэтгэлийг бодож, дотроо буцлах бухимдлаа хүчлэн барьж зогслоо. Орос тэрэг булан тойрон далд ороход, толгой эргүүлэн дөнгөж сая ирсэн зам руугаа хараад, "Буцах унаа олохоос доо" гэж өөртөө хэлээд санаа алдлаа. ■

Тодруулга

Л.Пүрэвбаатар: Тасалбаргүй, вагон хүрэлцэхгүй гэсэн асуудал үүсэхгүй

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газрын дэд дарга

Л.Пүрэвбаатараас аялал жуулчлалын улиралд төмөр замчид хэрхэн бэлдсэн тухай тодрууллаа.

-Аялал жуулчлалын улирал эхэлж буйтай холбоотойгоор төмөр замын ачаалал нэмэгддэг. Үүнээс шалтгаалаад жуулчид болоод аялал жуулчлалын компанийнхан төмөр замын үйлчилгээнд шүүмжлэлтэй хандах нь энүүхэнд. Энэ байдал энэ жил давтагдах уу?

-Монгол орныг зорин ирж буй гадаадын жуулчдаас гадна олон улсын хурал зөвлөлгөөн, ажил бизнесийн уулзалтад оролцохоор ирэх зочид төлөөлөгчид сүүлийн жилүүдэд харьцангуй өссөн. Москва, Бээжин хүртэлх олон улсын суудлын галт тэрэг зорчигчдыг хүргэхээс гадна жуулчдыг аялуулах үйлчилгээг төлөвлөж байна. Галт тэргэнд хооллож ундлаад, юм үзээд өөрийн дураар явах ийм төрлийн аялал бий болж байгаа. "Улаанбаатар төмөр зам"-ын газраас Хятад улстай галт тэрэгний солилцоог нэмж байна. Зорчигч тээврийн зориулалттай шинэ вагон худалдаж авсан. Ресторан, вагон, зоогийн газар, үзвэрийн гэсэн тасалгаа бүхий галт тэргийг

тохижуулан мэргэжлийн аялал жуулчлалын компанитай хамтран ажиллахаар болсон.

Жуулчдын улиралд Улаанбаатар-Бээжингийн чиглэлд нэмэлт галт тэрэг аялна. Нэмэлт вагон ч холбоно. Харин өртөө зөрлөгийн үйлчилгээг сайжруулах үүднээс "City өртөө"-г барьж байгуулах гэж байна. Сүүлийн жилүүдэд гадаадын жуулчдаас илүүтэй дотоодын жуулчдын зорчих байдал ихэссэн шүү дээ. Зуны цагт Бээжин-Улаанбаатарын чиглэлийн галт тэрэг жуулчнаар дүүрдэг. Энэ жилийн хувьд тасалбаргүй гэдэг ч юм уу, вагон хүрэлцэхгүй гэсэн гацаа үүсэхгүй. Олон улсын касс өргөтгөсөн цагаар ажиллаж байгаа.

-Жуулчид галт тэргээр зорчих гэтэл тасалбар нь байдаггүй. Хүлээх шаардлага гардаг. Энэ байдлыг хэрхэн шийдэж байна вэ?

-Зорчигч тээврийн тасалбар хүргэлт, хангалттай холбоотой асуудал байдаг. Энэ асуудлыг шийдэх зорилгоор сүлжээ, интернэт ашиглан тасалбарыг эздэд нь хүргэхээр ажиллаж байна. Олон улсын зорчигч тээврийн харилцаанд бүртгэлтэй томоохон өртөөнөөс билетийг худалдаж авах боломжтой болсон. Албан ёсны www.ortoo.net гэдэг цахим хуудас нээсэн. Эндээс тасалбараа төлбөрийн картаар төлбөрөө төлөөд авах боломжтой.

Жуулчид Монголд аялах билетээ гадаадад байхдаа худалдаж аваад ирэх нөхцөлийг бүрдүүлсэн.

-Жуулчдыг хүлээн авах бэлтгэлээ төмөр замынхан хангасан гэж үзэж болох уу?

-Жуулчны байгууллагууд дотоодын галт тэрэгний хуваарь, үйлчилгээнд тааруулаад жуулчдаа аялуулж байна. Төмөр замын газрын дэргэдэх "Аялал жуулчлалын төв" гэж байгуулсан. Бэлтгэл ажлыг шалгах ажлын хэсэг ажиллаж байна. Төмөр замын өртөө зөрлөгүүдэд сүлжээ программыг ашиглан тасалбар худалдан авах боломжийг бүрдүүлж байна. Москвад яваа хүн Монгол Улсын дотоодын галт тэрэгний билетийн Оросын кассаас тасалбар худалдан авах техникийн боломж бий болсон. Ганцхан яриа хэлэлцээр л дутуу байна. Төмөр замын байгууллагуудад зорчигч тээврийн үйлчилгээнд шинэ стандарт мөрдүүлэх, үйлчилгээний нэр төрлийг олшруулах талаар бодлогын хүрээнд ярьж, хэлэлцэж байгаа. Жуулчны тав тухыг хангах, жишиг үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагыг Төмөр замын газраас зорчигч тээврийн байгууллагад тавьсан. Энэ мэтчилэн аялал жуулчлалд төмөр замын гүйцэтгэх үүргийг өргөжүүлэх, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн ажлууд хийж байна. ■

Та аялал жуулчлалын салбарын ирээдүйг хэрхэн харж байна вэ?

Т.Батжаргал /“Ар Монгол Травэл”/ группийн ерөнхий захирал:

-Өнөөдрийн байдал үргэлжлээд байвал боломжтааруухан гэж үздэг. Төрөөс аялал жуулчлалын салбарт бодитой анхаарал тавихгүй байна шүү дээ. Хувийн компаниуд энэ салбарыг хөгжүүлнэ гэхээр хөрөнгө мөнгөний бололцоогүй байна. Одоо төрөөс аялал жуулчлалын шинэ үйлчилгээ гаргах тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй. Манай салбарын өнөөгийн үйлчилгээ 1960-1970-аад оных гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй.

Наад зах нь Казиногийн тухай хуулийг батлаад, амралтын томоохон цогцолбор байгуулах юм бол сайн байна. Онгон байгаль, нүүдэлчин соёл гэдгээр л бид жуулчдыг татах гэж мэрийсээр байгаа. Гэтэл болохгүй байна шүү дээ. Газрын мухарт байгаа манай орныг үнэхээр үзье гэсэн хүн нь л зорьж ирж байна. Түүнээс биш, Азийн зарим орон шиг үзэхгүй байхын аргагүй, жуулчдыг даллаад, татаад байхаар юм одоогоор алга.

Ш.Нэргүй /“Нью Жуулчин”/ группийн ерөнхийлөгч:

-Засгийн газраас аялал жуулчлалыг дэмжих тодорхой, цэгцтэй, зөв бодлого хэрэгжүүлэх юм бол энэ салбар уул уурхайгаас ч илүү үр өгөөжтэй байхаар шүү дээ. Даанч одоогоор бодитой дэмжлэг алга байна. 15-17 байгууллагын үйл ажиллагааны өртгөөс аялал жуулчлалын бүтээгдэхүүний өртөг бий болдог.

Өөрөөр хэлбэл, зочид буудал, агаарын тээвэр, зоогийн газар, үзвэрийн газар зэргийн үнэ ханшаас аяллын зардал шууд хамаардаг гэсэн үг. Гэтэл үнийн өсөлт, тогтворгүй байдлаас болоод

манай салбарын аж ахуйн нэгжүүд хүнд байдалд орох нь бий. Өртгөө дагаад олон улсын хэмжээнд үнээ нэмэх гэхээр өрсөлдөх чадвараа алдах гээд байдаг.

Тиймээс үнийн тогтвортой байдал бидний хувьд их чухал. Төр энэ тал дээр анхаарахын зэрэгцээ аялал жуулчлал болон бусад салбарын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй болов уу. Нөгөө талаас гадаад сурталчилгааг төрөөс нэлээд анхаарч, сайн хийх шаардлагатай байна.

М.Навчаа /“Цолмон Травэл” компанийн ерөнхий менежер/:

-Аялал жуулчлал бол хамгийн ирээдүйтэй салбарын нэг гэж би үздэг. Манайх хүн ам цөөтэй, нягтаршил багатай учир бусад үйлдвэржсэн орон шиг хөгжих боломжгүй, ялангуяа дэд бүтцийн хувьд. Энэ бол муу тал нь. Харин сайн тал нь бидэнд хүний гар бага хүрсэн сайхан байгаль байна. Үүнийгээ ашиглаад байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх нь ирээдүйтэй. Тиймээс “mass tourism” гэхээсээ илүү тодорхой зорилго бүхий аялал жуулчлал Монголд зохих юм шиг санагддаг.

Өнөөдөр бид уул уурхайгаар хөгжинэ гэж яриад байгаа. Гэхдээ уул уурхай хэдий хугацаанд Монголыг авч явах билээ гэдгийг тооцох хэрэгтэй болов уу. Үнэндээ аялал жуулчлал бол уул уурхайн эсрэг салбар. Тиймээс бид байгаль орчноо сүйтгэдэггүй, байгалийн сайхан, өв соёлоо харуулж сурталчлаад мөнгө олдог салбараа хөгжүүлэх хэрэгтэй.

Хельге Раймц /“Nomads Tours and Expeditions” компанийн захирал/:

-Монголд ирж байгаа ихэнх жуулчин онгон байгаль, үе дамжин ирсэн нүүдэлчний соёлыг үзэхээр ирдэг. Монголыг аялал жуулчлалын хувьд олон улсын хэмжээнд, ялангуяа Америкт нэлээд сонирхож байгаа ч Европ болон Америкаас ирэх жуулчдын тоо 2008 оноос хойш санхүүгийн хямралаас үүдэн одоог хүртэл буурсан хэвээр байгаа. Энэ байдал ойрын ирээдүйд сайжрах байх гэж найдаж байна.

Азийн аялал жуулчлал, ялангуяа Хятадаас ирэх жуулчдын тоо нэмэгдэж буй энэ үед бид монголчууд хятадуудад дургүй гэж ирсэн хятад хүн бүрт хэлэхээ болих шаардлагатай. Түүнчлэн олон улсын нислэгийн тоо нэмэгдэж, Европоос МИАТ-ийн зорчих тасалбарыг авах боломжтой болсон нь аялал жуулчлалд сайн нөлөө үзүүлнэ.

Ирээдүйд Монгол Улсад аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэхэд олон нийтийн хүчин зүтгэл оролцоо маш чухал. Сүүлийн үед Монгол Улс хөрөнгө оруулалт, уул уурхайгаар олонд танигдаж байгаа нь аялал жуулчлалын хөгжилд төдийлэн таатай бус байх болов уу. Тиймээс аль алинийг нь тэнцвэржүүлэхийн тулд маркетингийн стратеги шаардлагатай.

Монголд жуулчлахад харьцангуй үнэтэй тусдаг. Чадварлаг боловсон хүчний хомсдол, орон нутгийн үнийн өсөлт, мөнгөний ханш унах зэрэг хүчин зүйлс үүнд нөлөөлдөг. Мөн жуулчдын анхаарлыг Киргизстан, Сибирь, Непал, Бутан гэх мэт Азийн бусад орон татдаг. Эдгээр орныг аялал жуулчлалын хувьд Монгол Улстай өрсөлдөгч гэж үзэж болно. Амжилтад хүрэхийг хүсэж байгаа бол энэ байдлаа ойлгож, эдгээр баримтыг стратегидаа оруулж өгөх хэрэгтэй байна. ■

Голланд өвчин

Уул уурхай “утаагүй үйлдвэрлэл”-ийг сөнөөх нь...

“Ийм бахархал болсон хэрмийг байгуулсан ард түмэн аугаа их түүхтэй байж таарна. Аугаа их түүхтэй ард түмэн аугаа их ирээдүйтэй байж таарна”.

-Хятадын цагаан хэрэм дээрх Ричард М.Никсоны хэлсэн үг-

“Ийм бахархал болсон хэрмийг баруулахад хүргэсэн ард түмэн мөн дутуугүй аугаа их түүхтэй байж таарна”.

-“Монголчууд нүүдэл суудал” номын зохиогч Баабарын үг-

“Монголчууд нүүдэл суудал” номын тэргүүн хуудсанд дурайх дээрх үгс сэтгэл хөдөлгөж, “Би монгол хүн шүү” гэдгээрээ бахархах сэтгэлийг гижигдэж билээ. Тийм ээ, бид монголчууд, бидэнд ч аугаа их ирээдүй байгаа нь лавтай. Гэхдээ тэр ирээдүйг бид яаж бүтээх вэ? Өнөөдөр монголчууд үүцээ задалж, үсрэнгүй хөгжилд хүрнэ хэмээн баярлаж байна. Бултаараа уурхайчин болоод баяжих мөрөөдөлдөө автаад элдвийг эргэцүүлэх завгүй байх зуур эрдэс баялгийн салбар манай ДНБ-ий 30, экспортын 85 гаруй хувийг бүрдүүлж, Монголд ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 90 орчим хувийг залгих боллоо. Чингисийн Монгол зэс, алт, нүүрсний Монгол болжээ. Дэлхийн талыг эзэгнэж байсан аугаа их түүхтэй манай орон өнөөдөр Оюутолгой, Тавантолгойгоороо бөмбөрцгийн анхаарлыг татах аж. Үүнийг дагаад манай нутагт их мөнгө урсаж ирэх болсон нь сайн л хэрэг. Гэхдээ баялгийнхаа ачаар баяжсан орнууд байхад баларсан орны жишээ ч мундахгүй бий. Тиймээс аугаа их ирээдүйг бий болгохын тулд бидэнд зөв удирдлага, зөв бодлого хэрэгтэй.

Голланд өвчин манайд байна



уу, үгүй юү хэмээн монголчууд толгойгоо гашилгах болов. Төр, засгийн эрхмүүд “Голланд өвчний эрсдэл бий, гэвч классик утгаараа яг одоо алга” хэмээн тайвшруулна. Үнэн гэж үү? Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш хэт чангарч, уул уурхайгаас бусад салбар өрсөлдөх чадвараа алдах нь Голланд өвчний шинж тэмдэг гэдэг. Тэгвэл 2010 онд манай төгрөг америк долларын эсрэг дэлхийд хамгийн ихээр өссөн валют болсныг сануулах юун. Харин уул уурхай бусад салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж эхэлсэн болов уу? Голланд өвчин жинхэнэ утгаараа аялал жуулчлалын салбарт нүүрлэсэн гэх барим тавим жишээ олон байгааг төр, засгийн эрхмүүдэд сануулах нь зүйтэй байх. Уул уурхай “утаагүй үйлдвэрлэл”-ийг заналхийлж эхэлснийг батлах дорх баримтууд байгаа юм.

Нэгдүгээрт, аялал жуулчлалын компани бүтээгдэхүүнээ жилийн өмнө худалддаг. Өөрөөр хэлбэл, жуулчид төдийд тэнд очно гэдгээ эртнээс төлөвлөж, мөнгөө

тооцоолдог. Гэтэл хагас жилийн өмнө захиалгаа хийсэн хүмүүс зун Монголд хүрээд ирэхэд долларын ханш уначихсан байх нь гадаад валютаар орлогоо олж, төгрөгөөр зарлагаа хэмждэг аялал жуулчлалын компаниудад хүндээр тусах нь ойлгомжтой. 2010 онд ам.долларын ханш төгрөгийн эсрэг 15 хувиар суларна гэдэг аялал жуулчлалын компаниудын орлогоос 15 хувийн татвар авчихсантай ялгаагүй.

Хоёрдугаарт, дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өндөр байгаагаас зузаарч буй төсвөө харж хөөрцөглөсөн эрх баригчид ард иргэдэдээ 21 мянган төгрөг тарааж, түүнийг дагаад инфляци суга өсөж байна. Гэтэл аялал жуулчлалын салбарын бараа, үйлчилгээний өртөг 15-17 салбарын өртгөөс шалтгаалдаг гэж байгаа. Зочид буудал, хоолны газар, агаарын тээврийн үнэ нэмэгдэхэд аяллын өртөг шууд өсөөд явна. Үүнийг дагаад үнэ нэмэе гэхээр болдоггүй, бусад оронтой өрсөлдөх чадвараа алдчих гээд байдаг. ▶

» Өнөөдөр монголчууд Дубай руу найман өдөр аялаад ирэхэд 1980 ам. доллар, Хайнан руу 1065 долларт багтахыг “Жуулчин” компанийн цахим хуудаснаас харж болно. Гэтэл “Монгол: Тим Копын хамт нүүдэлчний мөрөөр” 18 өдрийн аялал (Mongolia In The Footsteps Of The Nomad With Tim Cope) л гэхэд 4950 ам.доллар байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, газрын мухарт орших манай оронд хийх аяллын үнэ Азийн бусад оронтой харьцуулахад харьцангуй өндөр байгаа юм. Ийм нөхцөлд үнээ нэмээд байвал Монголыг үзэхээр ирэх хүн олдох уу?

Гуравдугаарт, эрдэс баялгийн салбар өргөжин тэлэхийн хэрээр Монгол орон моодонд орж, хурал семинарт оролцох зорилгоор манайд зочлогчид олширч байгаа нь үнэн. Тэд VIP зэрэглэлээр нисэж ирээд, таван одтой зочид буудалд хоёр хоноод буцна. Үүнийг дагаад нэгэн үе жуулчдын царай харж амьдарч байсан зочид буудлууд үнээ нэмчихэлгүй яах вэ. Хажуугаар нь борооны дараах мөөг шиг олширч буй баян уурхайнууд нисэх онгоцнуудыг чартердах явдал элбэг болсон. Оюутолгой, Ухаа худаг, Овоот-Толгой зэрэг томоохон уурхайн ажилчид хоёр долоо хоног ажиллаад, 7-14 хоног амардаг шүү дээ. Тэднийгээ хотоос Өмнөговь руу зөөхийн тулд онгоцнуудыг өндөр үнээр түрээслээд авчихна. Ингээд агаарын тээврийн компаниуд уурхайчдын хөөрөгдсөн үнэ ханшаар жуулчдад үйлчлэх жишээтэй.

Дөрөвдүгээрт, уул уурхайн компаниуд бусад салбарын мэргэжилтнүүдийг мөнгөөр зодоод авах явдал моодонд ороод байна. Хэлтэй устай, чадалтай чадвартай нь бүгд өндөр цалин хараад, уул уурхайн компаниуд руу урваад алга болно. Аялал жуулчлалын салбарынхан боловсон хүчнээ алдаад, шинээр төгсөж буй хүүхдүүдийг сургаж авахаас аргагүй байдалд ороод сууж байна. Тэд нар нь магадгүй хэлээ сайжруулчихаад л эрдэс баялгийн салбарт хайр зарлаад явахыг үгүйсгэхгүй.

Энэ мэтээр аялал жуулчлалын компаниуд уул уурхайн ханд дээрэлхүүлж, хэцүү байдалд орох шинжтэй. Гэхдээ дээрх дөрвөн жишээг нийлүүлснээс

ч илүү аймшигтай зүйл нь яах аргагүй байгаль орчинд учирч буй хор хөнөөл билээ. Ашигт малтмалын газрын мэдээлснээр бол өнөөдөр манайд уул уурхайн хайгуул, олборлолтын 5139 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр үйлчилж байна. Гэтэл эрдэс баялгийн компаниуд нөхөн сэргээлтээ зохих ёсоор хийдэг бил үү? Хэдэн мянгаар тоологдох уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн дотор олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг нь гарын арван хуруунд багтаахад цөөн.

Өмнийн говь элсээр биш, нүүрсээр шуурдаг боллоо гэж нутгийн хүмүүс нь ярьж байна. Энэ эрүүл үзэгдэл гэж үү? Үүгээр ч зогсохгүй уул уурхайн компаниуд палеонтологийн үнэт олдворууд, түүх соёлын өвийг хайр найргүй устгаж байгаа талаар ил далд ярих болсон. Соёлын өвийн тухай хуульд ашигт малтмалын хайгуул, олборлолт хийхийн өмнө тухайн газарт заавал археологийн судалгаа хайгуулын баг ажиллуулах ёстой гэж заасан байдаг ч энэхүү хуулийг хэрэгжүүлдэг нь ховор ажээ. Биднээс өөр хэнд ч байхгүй, басхүү биднээс өөр хэн ч хадгалж хамгаалахгүй түүх дурсгал, соёл, шашин, ёс заншлын “үггүй гэрч”-ийг тээсэн тал нутаг минь тэслүүлж, дэлбэлүүлж, тонуулсаар. Энэ нөхцөлд олон жилийн турш онгон дагшин байгаль, нүүдэлчин соёл гэх хоёрхон тодотголоор амь зууж ирсэн манай аялал жуулчлалын салбар яах болж байна аа? Жуулчдад ухсан нүх, овоолсон шороо, хатсан сайр үзүүлээд, нүүрсний замаар таваргах гэж үү?

2008 онд Засгийн газар аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон зарласан билээ. Гэвч эрх баригчид энэ салбарыг хаясан, мартсаныг хүн бүхэн гайхаж байна. Эдүгээ монголчууд уул уурхайгаас л мөнгө олно хэмээн төөрөлдөж байх хооронд дэлхийн олон орон жуулчдын халааснаас салгасан мөнгөөрөө төсвийн түрийвчээ түнтгийлгээд, ажлын байр бий болгоод, үндэсний брэндээ борлуулаад болоод л байна. Басхүү ашигт малтмалаар баян орнууд хэзээ нэлэн цагт үүцээ шавхаж дуусахаа мэдээд,

ирээдүйн орлогын эх үүсвэр болох аялал жуулчлалын салбартаа хөрөнгө мөнгөө харамгүй цацах бодлого баримталж байна шүү дээ. Дубайчууд яагаад Бурж Халифа барилгадаа олон тэрбумыг зарцуулж, дал модны хэлбэртэй болон дэлхийн бөмбөрцгийг илтгэх арал бий болгохын тулд хамгаа зориулаад байгаа юм бэ? Мөнгөө хийх газраа олж ядсандаа биш, сонин содон шийдлээр жуулчдыг татах зорилго агуулж байгаа нь лавтай.

Харин монголчууд ажин түжин. Дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ дандаа өндөр байх юм шиг санаж, байгаль эхийн эрдэс баялгийн нөөц шавхагдахгүй мэт сэтгэсээр сууна. Уг нь Богд уулын аманд Хүннүгийн музей цогцолбор байгуулах шийдвэр хоёр жилийн өмнө гарсан одоо хүртэл таг чиг. Энэхүү төслийг хэрэгжүүлэх хөрөнгө мөнгө 2011 оны төсөвт лав алга байгааг харахад энэ ондоо хийгдэхгүй бололтой. Үүний хажуугаар “Хархорин XIII зуун” цогцолбор төслийг хэрэгжүүлнэ гэж байгаа ч хөрөнгө оруулалтын асуудлыг нь хэрхэн шийдэх гээд байгаа нь тодорхойгүй хэвээр.

Эцэст нь, өвөг дээдсийн минь бидэнд үлдээсэн нутаг дэлхийн зах зээлд үнэд хүрэх алт, зэс, нүүрс тэргүүтэй ашигт малтмалаас гадна өв соёлын хосгүй үнэт дурсгалуудыг тээж байгааг ахин дахин анхааруулах хэрэгтэй байх. Гэтэл бид шунахай сэтгэлдээ автан байгаль эхээ сэндийчиж, эрдэс баялгаа хайр найргүй олборлолоо гэхэд хэдэн жилийн дараа Монголд юу үлдэх юм бэ? Бид үр хойчдоо юу өвлүүлэх вэ? Монгол оронд аугаа их түүх байгаа болохоор аялал жуулчлалын салбарыг төрөөс жаахан л дэмжээд өгвөл болно гэж учир мэдэх хүмүүс тайлбарлаж байгаа юм. Тэгвэл уул уурхайн орлогоороо байгалийг сүйтгэдэг биш, байгалийн сайхныг хүмүүст харуулж үзүүлээд, түүх соёлын өвөө гайхуулж сурталчлаад мөнгө олдог салбараа дэмжих цаг болсон юм биш үү? Утаагүй, хязгааргүй нөөцтэй үйлдвэрлэлээ хөгжүүлж, үр хүүхдэдээ аугаа их түүхийн дурсгал болсон тал нутгаа аугаа их ирээдүйн хамт үлдээе. ■

Та Монголын говь руу аялах гэж байна уу?



1. Улаанбаатар хотоос- Даланзадгад чиглэлд ниснэ- 580 км
2. Даланзадгад- “Ёлын ам”-руу аялал үргэлжилнэ- 56 км /Өмнөговь аймаг- Ханхонгор сум/
3. “Ёлын ам”- “Хонгорын элс” эмчилгээний зориулалттай элсэнд очно-130 км /Өмнөговь аймаг- Сэврэй сум/
4. “Хонгорын элс”- “Баянзаг” буюу жуулчдын дунд “Flaming cliffs” нэрээр алдаршсан үзэсгэлэнт байгалийг үзнэ-150 км /Өмнөговь аймаг- Булган сум/
5. Баянзаг- Даланзадгад-100 км
6. Даланзадгад- Улаанбаатар чиглэлд ниснэ.

Дээрх маршрутаар та гурав хоног аялна. Тухайн аяллын өртөг хувь хүн, албан байгууллагын аль нь захиалга өгсөн гэдгээс хамаарч янз бүр байдаг аж. Энэ аяллаар Та говийн хамгийн үзэсгэлэнт газруудаар явна. Жишээ нь: “Ёлын ам” гэх энэ хавцал нь далайн төвшнөөс дээш дунджаар 2800 метр өндөрт оршино. Хавцлын дундуур жижиг горхи урсдаг бөгөөд мөнхийн нар тусдаггүй зарим газарт нь нэг метрээс ч илүү зузаантай мөсөн давхарга

байдаг. Бороо хур ихтэй жил хавцлын дээрээс дөрвөн метр урт хүрхрээ урсан орж ирдэг байна. Нар тусахгүй мөнхийн сүүдэр бүхий сэрүүн газрууд олон байдаг учраас өвлийг санагдуулам хүйтэн агаар хавцлын дундуур нэвт урсаж байдаг туйлын үзэсгэлэнтэй газар юм. “Хонгорын элс” нь хүний дотоод таван цулыг анагаах увидастай бөгөөд аманд орохдоо хайлдаг аж. Уг элсийг барилгын материалд хэрэглэж болдоггүй байна. Баянзаг нь Өмнөговь аймгийн нутагт Арцбогд уулсын дагуух уудам хөндийд орших шаварлаг хурдас бүхий газар. Заг мод их ургадаг учраас “Баянзаг” гэж нэрлэсэн ажээ. Монголчууд улаан элсэрхэг шаварлаг хөрс хатуурч тогтсон газрыг “цав” гэдэг. Арай өндөрлөг газрыг нь “цонж” гэдэг. Баянзагийн цонжуудын өндөр нь 20-50 метрт хүрнэ. Баянзагийн улаан шаварлаг хөрс нь оройн наранд асаж буй улаан гал шиг харагддаг учраас жуулчдын дунд “асаж буй толгод” буюу “Flaming cliffs” гэж нэрлэгдэх болжээ. Мөн энэ газраас үлэг гүрвэлийн өндгийг дэлхийд анх олсон байдаг.

Сайхан аялаарай. ■

Тэд бидний тухай

“Америк миний төрсөн нутаг, харин Монгол миний зүрхний нутаг”

Ярилцсан Х. Хулан, И.Отгонжаргал

Дэлхийн 30-аад оронд хэвлэгдэн гарч, сая сая уншигчийг байлдан дагуулсан “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” номын зохиогч Жак Уэтерфордтой танилцаж, ярилцлага хийсэндээ баяртай байна. “Хас банк”-ны хувь нийлүүлэгчдийн хурлын өмнөх хүлээн авалтын үеэр анх түүнтэй танилцаж, гэрт нь очиж, тухтай ярилцага хийх зөвшөөрөл авсан юм. Их дэлгүүрийн зүүн талын “Гандирс”-т гэртэй бөгөөд тун тохилог амьдардаг юм билээ. Жак Улаанбаатар хотыг гэрээсээ тольддог гээд биднийг тагтан дээрээ гарч сонирхохыг урилаа. Том, жижиг хоёр тагттай эднийхээс Улаанбаатарын сүүлийн үеийн өндөр байшингууд алсын гэр хороололтойгоо нүдэнд илхэн. Эднийх энд амьдраад бараг гурван жил болж байгаа гэнэ. Гэрийнх нь хаалгаар ороод л монгол ахуй ханхална. Гал тогооныхоо тавилгын дээд талд дээр үеийн халуун сав /нум сум харваж буй, бөх барилдаж, морь уралдаж байгаа зурагтай хоёр литрийн/ гурвыг, айрагны ваартай өрсөн нь содон байлаа. “Ийм зурагтай халуун сав одоо манайд олдохгүй, Та үүнийг хаанаас авсан бэ” гэж сонирхоход, “Халуун сав миний амьдралд хамгийн чухал зүйл байсан. Монголд судалгааны ажлаар хөдөө хээр явж байхад ийм халуун савнаас л дандаа цай унд уудаг байсан. Тэгээд миний амьдралын нэгээхэн түүхтэй нарийн холбоотой учраас яг ийм зурагтай халуун сав олж авах хүсэлтэй байна гэдгээ найз нөхдөдөө хэлсэн. Тэгээд манай найзууд бүтэн гурван жил хайж байж олж өгсөн юм аа” хэмээн хуучлав. Мөн зочны өрөөний хойморын ханандаа хатадын гоёмсог зураг зуруулсан нь тун ч донжтой харагдаж байлаа. Нэгэн залуу уран бүтээлчээр ийнхүү хэрэг болгож зуруулсан гэнэ. За тэгээд эднийд Монголын түүхийг өгүүлэх хөрөг зураг, урт цоохор авдар гээд Монголын холбогдолтой эд зүйл цөөнгүй. Тавганд ааруул дүүргэж, өрөм тавьсан идээг амтархан зооглоход таатай байсныг хэлье.

Хоёр хүүхэд, зургаан ачтай тэрбээр 10 жилд байхаасаа найзалж, ханилан суусан эхнэртээ тун ч халамжтай хань нь юм билээ. Хэдийгээр ач нараасаа хол байгаа ч Жак Уэтерфорд Амарсанаа гэдэг



Фотог Б.Бямба-Очир бяцхан хүүг энгэртээ тэврэн “Өвөө нь” хэмээн ихэд элгэмсүү эрхлүүлэв. Шавийнхаа хүүхдийг ийнхүү эрхлүүлж хайрлаж байгаа аж. Ингээд түүнтэй хийсэн Монголын түүх, зохиолчийн авьяас чадал хийгээд түүнийг хувь хүн талаас нь гаргахыг хичээсэн сонирхолтой ярилцлагыг таалан уншина уу.

“Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” номыг бичих санаа танд анх яаж төрсөн бэ?

-Би хүүхэд байхаасаа л Монголын тухай маш их сонирхдог байсан. Дараа нь оюутан болоод Монголд ирэхийг хүссэн хэдий ч хүйтэн дайны үе байсан тул боломжгүй байв. Харин түүнээс хойш олон жилийн дараа 50-иад настай байхад Монголд ирэх боломж олдсон. Тэгээд л Монголд дурласан гэж хэлж болох юм.

Танай орон миний зүрх сэтгэлийг эзэмдсэн. Тэр үед надад ном бичих төлөвлөгөө байгаагүй. Би монголоор ярьдаггүй, Монголын түүхийг тийм сайн мэддэггүй байсан. Гэхдээ надад Монгол орон маш их таалагдсан тул он жил өнгөрөхийн хэрээр хэрэв би бичихгүй юм бол өөр хэн ч Монголын түүхийг дэлхий дахинаа тайлбарлан, мөн түүнчлэн орчин үеийн Монгол Улс хэрхэн бий болсныг бичихгүй юм байна гэдгийг ухаарсан. Монгол бол ээлүүд, алслагдсан ▶

» орон биш, харин орчин цагийн дэлхийн төв юм.

-Удахгүй наадам болно. Та монгол наадам үздэг үү?

-Урьд нь бид наадам үзэхээр байнга хөдөө явдаг байсан. Сүүлийн үед гэртээ зурагтаар морь, бөхөө үзээд, наадмын хуушуур идэж тухалдаг. Учир нь, наадмын үеэр хөл хөдөлгөөн ихтэй учраас хаа сайгүй тоос их босдог. Тиймээс бид наадамлахаар явж байгаа зон олныг цонхоороо ажигж, зурагтаа үздэг.

-Наадмын үеэр Төв цэнгэлдэхэд Есөн хөлт цагаан сүлд залах үеэр таны сэтгэл огшдог уу?

-Тийм ээ, наадмын үеэр миний сэтгэл маш их хөдөлдөг. Одоогийн энэ наадмыг мэдээжээр 1921 оноос хойш тэмдэглэж байна. Харин Чингис хаан 1206 онд Монгол Улсыг байгуулснаасаа эхлэн чухал үйл явдлуудыг тэмдэглэхийн тулд наадам хийдэг байсан. Тиймээс монгол наадам бол дэлхий дээр хамгийн эртний уламжлалт зан үйлийн нэг юм. Ертөнцийн хүмүүс 800 гаруй жилийн тэртээ Монгол Улсыг хүндлэн наадам хийдэг байсан гэж бодоод үз дээ. Тиймээс түүхч миний хувьд энэ эртний түүхийн талаар бодох нь чухал юм. Наадмыг Чингис хааны үеэс эхлэн одоо хүртэл тэмдэглэж байгаа энэ баримт байна. Тиймээс одоо бидний үзэж байгаа зүйлийг Чингис хаан ч бас үзэж байсан.

-Монголчуудын зарим нь эх түүхээ бүрэн сайн мэдэхгүй ч монгол хүн бүрт омогшил байдаг. Энэ нь юутай холбоотой гэж Та боддог вэ?

- . Учир нь, Чингис хаан бол дэлхийн түүхэнд хамгийн аугаа байлдан эзлэгч байсан юм. Тухайн үед Монгол Улс ердөө ганцхан сая хүн амтай байсан нь маш цөөн хүнд тооцогддог байж. Хэрэв одоо та нар тэрхүү 800 жилийн өмнө ганцхан сая хүн амтай байсан өөр бусад орныг хайвал тэдний ихэнх нь устан алга болсон байх вий. Эсвэл Хятад, Орос, Франц, Америк зэрэг томоохон орны нэг хэсэг болсон байгаа. Харин монгол хүмүүс одоо хүртэл байсаар байна. 805 жилийн өмнө монголчууд яг өнөөдрийн хэлээрээ ярьж, дээлээ өмсөж, монгол бичгээрээ бичиж, мөн баяр наадмаа тэмдэглэж байсан. Монгол Улс шиг олон зуун жилээр соёл, зан заншлаа хадгалсаар байгаа улс орон өөр хаа ч байхгүй. Тийм болохоор омогшил байлгүй яах вэ.

-Таны “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” ном түүхийн тухай зохиол боловч уран яруу хэллэг ихтэй уншихад хялбар байсан. Та энэ зохиолыг зориуд хөнгөн сонирхолтой байлгах талаас нь бодож найруулганд нь анхаарсан уу. Эсвэл Та бүх зохиолоо ийм сонирхолтой гоё бичдэг юм уу?

-Чингис хааны тухай ном бичихийн тулд би судалгааны ажлаар Монголын өргөн уудам нутгаар хөндлөн гулд явсан. Хөдөөгүүр явж байхдаа ихэнхдээ малчин айлдхонож, хөдөө нутгийн үзэмж төгс байгалийг бишрэн явдаг байсан. Зарим үед морь эсвэл тэмээ унана. Монголын агаараар амьсгалж, үнэрийг нь үнэрлэж, алсын барааг сэтгэл бахдам харна. Өргөн говийг туулахад эдгээр зүйл аяндаа өөрийн болно. Энэ бүхэн надад урам зориг өгдөг байсан. Тиймээс би дэлхий дээр байгаа Монголыг хэзээ ч үзэж чадахгүй, хэзээ ч Монголд ирэх боломжгүй, нэг ч монгол хүнтэй уулзах боломжгүй тэдгээр хүмүүст зориулж

эл номыг бичсэн. Тэдэнд Монголын үнэр, амт, нутаг орныг мэдрүүлэхээр бичих хүсэлтэй байсан тул би өөрийнхөө мэдрэмж, надад төрсөн сэтгэгдэл, миний амталсан амт, гар хүрч мэдэрсэн тэр бүгдийг бичсэн.

Миний бодлоор Монголын түүх бол үнэхээр гайхамшигтай сайхан. Монголын байгаль, уран зураг, хөгжим зэргийг харж сонсох хийгээд монгол хүмүүстэй уулзах энэ бүгдний лээд гайхамшигтай онцгой сэтгэгдэл төрүүлдэг учир миний хувьд энэ бүгдийг л нийлүүлэн номдоо оруулахыг хичээсэн. Монголын хөдөө нутгийн ер бусын үзэсгэлэн, гэрт амьдардаг хүмүүсийн сайхан сэтгэл, тэдний гэр бүл, сүүтэй цайгаа чанаж байгаа эзэгтэй, сониучирхан харж байгаа хүүхдүүд зэрэг бүгд өвөрмөц. Энэ бүгдийг харахад надад Чингис хааны цаг үед ирсэн юм шиг санагддаг. Тиймээс би хүмүүст энэ бүгдийг мэдрүүлэхийг хүссэн.

-Таны зохиол үргэлжилсэн үгийнх мөртлөө яруу уянгалаг байдаг. Та яруу найраг бичдэг үү?

-Үгүй, хачирхалтай шүү. Би ном бичиж байхдаа өөрийн үзэж харснаа өөрөөр хэлбэл, нүдээрээ харсан болон зүрхэндээ мэдэрсэн тэр бүх зүйлийг л тусган харуулахыг хичээсэн. Харин би уран зохиолын болон яруу найргийн ямар ч авъяасгүй. Номынхоо уншигчдад Монголын уртын дууг сонсвол Монголын хөдөө нутгийг мэдрэх болно. Уртын дуунд гол горхи жинхэнэ юм шиг мэдрэгдэнэ гэдгийг харуулахыг хүссэн.

Жишээ нь Монгол морьдын туурайд Номхон далайгаас Газар дундын тэнгис хүртэлх гол мөрөн, нуур цөөрмийн ус цалгиж байнам гэх байдлаар. Ийм сэтгэл татам уран яруу үг өгүүлбэр олон байсан.

Миний бодлоор Барууны орны ихэнх хүмүүс Чингис хааны тухай ярихдаа түүний байлдан эзэлсэн газар нутгийн талаар л ярьдаг. Харин монголчуудын хувьд ус, морьд зэрэг нь маш чухал байдаг. Тиймээс би Монголын түүхийг бодитоор нь харуулж чадахуйцаар бичихийг хичээсэн. Гэхдээ би харийн хүн учраас энэ ч гэсэн хэцүү байсан. Миний хувьд заримдаа алдаа гаргах ч явдал байсан.

-Та энэ номыг бичихэд хэдий хугацаа зарцуулсан бэ?

-1998-2004 он хүртэл бараг зургаан жилийг зарцуулсан. Гэхдээ Монголд ирэхээсээ өмнө ном уншиж, Оросын Буриад, Узбекистан, Казахстан, Киргизстан зэрэг орноор аялсан.

-Манай нэртэй эрдэмтэдтэй хамтарч ажилласан гасэн. Тэдний судалгаа хэр нэмэр болсон бэ?

-Миний номд орсон бараг ихэнх зүйлийг би Монголын эрдэмтэн, Монголын малчин, эсвэл монгол хүнээс сурч мэдсэн юм. Би эрдэмтэн доктор Лхагвасүрэн, Сүхбаатар болон бусад хүмүүстэй хамтран ажилласан. Гэхдээ Лхагвасүрэн, Сүхбаатар нартай илүү ойр дотно байсаар бараг ах дүү шиг болсон. Бид хөдөө аялан явж өглөө сэрмэгцээ, цай ундаа уух зуураа, шөнө унтахдаа гэх мэтчилэн байнга л Монголын түүхийн талаар ярилцдаг байсан. Баримт сонсох нь хангалттай биш, учир нь баримт гэдэг нь хуурай баримт л юм. Өвөг дээдэс нь энэ амьдралыг туулан гарсан, түүхийг хайрлан хүндэлдэг тэдгээр хүмүүстэй ярилцах хэрэгтэй байдаг.

-Танаас морь унаж чаддаг уу гэж асуух нь илүүц биз ээ. Та Хэнтийд явж байхдаа ааруул байнга халаасалж явах нь хэрэгтэй юм байна гэж

» **бодогдсон гэж бичсэн байсан.**

-Маш их морь унадаг байсан бөгөөд заримдаа хөл өвдөж, хөндүүрлэх зэргээр хэцүү байдаг байсан. Зуны улиралд би цагаан идээ идэх маш дуртай. Одоо ч манайх ааруул, эзэгий, өрөм зөөхийгөөр тасардаггүй. Монголын цагаан идээ нутаг нутгийн онцлогоосоо шалтгаалаад өөр өөр амт, чанартай байдаг нь сонирхолтой санагддаг. Зарим нутгийн ааруул нь тослог ихтэй байхад зарим газрынх гашуун байдаг. Тийм учраас би малчны хотонд очоод энэ бол зөвхөн энэ нутгийн онцлогийг шингээсэн морь мал, өвс ногоо гэж бодохоор маш их сэтгэл хөдөлдөг.

-Та тэгээд ямар ааруулд дуртай вэ, гашуун уу эсвэл тос даасан борд нь илүү дуртай юу?

-Үнэндээ надад бүх ааруул таалагддаг. Ховд зэрэг баруун аймгийн ааруул илүү тослог ихтэй юм шиг санагддаг. Бас ааруулны үнэр улирлаа дагаад өөрчлөгдөж байдаг нь сонин шүү.

-Айраг уух дуртай юу?

-Тийм ээ, би маш дуртай. Зуны халуун өдөр хөдөөний айлын хөхүүртэй айрагнаас уух үнэхээр сайхан. Хүмүүс надад байнга айраг авчирч өгдөг. Гэхдээ тэр нь малчны хөхүүртэй айргийг арай гүйцдэггүй.

-Энэ хугацаанд Та монгол хэл хэр сурсан бэ?

-Энэ маш хэцүү, би настай хүн. Би анх Монголд ирэхдээ 50 гаруй настай байсан. Шинэ хэл сурахад хүнд. Гэхдээ би монгол хэлэнд маш дуртай. Монгол хэл нь хүний зүрхийг тайвшруулдаг. Гэвч маш хэцүү, би хөдөө очоод, хүүхдүүдтэй ярилцахад тэд намайг хэзээ ч ойлгодоггүй. Тэд зүгээр л над руу тас ширтээд гайхан хардаг.

-Зохиолч болохыг мөрөөддөг байсан уу? Таныг антропологи судлаач гэж уншсан юм байна.

-Би сурагч байхаасаа л зохиолч болохыг хүссэн. Гэхдээ би явсаар их сургуульд суралцах болсон. Аав минь армид тогооч хийдэг, манайх олон хүүхэдтэй айл тул мөнгө төгрөг тэр бүр хүрэлцдэггүй байсан. Гэрээсээ хамгийн түрүүнд арван жилээ төгссөндөө би тэр үедээ их баяртай байлаа. Гэтэл их сургуульд ороод эхний жилдээ англи хэлэндээ унасан. Маш их ичсэн. Харин дараа нь англи хэлээ сайжруулахын тулд нууцаар бие даан хичээллэж эхэлсэн. Харин одоо энэ нь хамгийн шилдэг борлуулалттай номын зохиолч болсон хүний хувьд инээдтэй юм.

-“Монголын Их хатдын нууц товчоо: Чингис хааны эзэнт гүрнийг охидууд нь аварч хамгаалсан түүх” номыг яагаад бичих болсон бэ?

-Монголчууд Мандухай хатны тухай ихэвчлэн ярьдаг тухай анх сонссоны улмаас хатдын тухай ном гаргах болсон. Би энэ талаар тийм их сонирхоогүй боловч монголчуудын хувьд энэ маш чухал байсан тул энэ талаар илүү зүйл мэдэх хэрэгтэй юм байна гэж бодсон. Дараа нь Монголын нууц товчоог дахин дахин уншсан нь Мандухай хатнаас хамаагүй өмнөх түүх байсан. Эндээс харахад эмэгтэйчүүдийн тухай зарим хэсэг нь байхгүй байхыг ажигласан. Надад энэ нь сонирхол төрүүлсний зэрэгцээ бас уур хүрч байсан. Яагаад зарим хүмүүс бидэнд худал хэлсэн юм бэ? Яагаад хэн нэг нь энэхүү нууц товчооноос зарим хэсгийг нь хасчихав гэж бодсон. Гэвч дараа нь энэ

нь миний үүрэг болсон. Би Чингис хааны тухай номыг бичихдээ илүү сэтгэл зүрхнээсээ хайрлаж бичсэн бол харин Хатдын түүхийг бичихдээ түүхийг хүндэлж өөрийн үүрэг гэж үзсэн.

-Та зохиолоо яаж бичдэг вэ? Дэвтэр дээр үү эсвэл компьютер дээр үү?

-Компьютерээр бичдэг. Хачин сонсогдож байгаа байх. Гэхдээ би эдгээр номыг Монголоос хол Америкт байхдаа бичсэн. Учир нь Монголд байхдаа бичих гэж оролдсон боловч мэдрэмж хэт их байсан. Агаар, үнэр, гэх мэт бүгд маш хүчтэй байсан. Харин Америкт очоод компьютерийнхээ ард ганцаараа суухдаа л сая би маш нарийн нямбай бодож сэтгэж эхэлсэн. Тэгээд хөгжим, ялангуяа Жанцанноровын хөгжмийг сонсож, Монголын үнэрийг бага багаар үнэртэж, сонсож мэдрэх үедээ бичиж эхэлж чадсан. Хатдын тухай номыг бичиж байхдаа Шуранхай хамтлагийн дууг сонсдог байсан. Түүнчлэн Мандухайн тухай Жанцанноровын бичсэн хөгжмийг Чинбатын тоглож байгааг сонсож, Америкт өөртөө урам зориг өгөхийн тулд хатагтай Сувдын тоглолтыг үздэг байсан.

-Хатдын номонд гардаг эмэгтэйчүүдийн хэнийх нь дүр танд хамгийн ойр дотно байдаг вэ?

-Энэ бол өөр. Жишээлбэл оюун ухааны түвшний хувьд Алаг Бэхийг илүү хүндэлдэг. Учир нь тэр ном уншдаг, бичдэг суралцдаг байсан. Харин гэр бүлийн түвшинд Өэлүн эх. Тэр бүх зүйлийг хүүхдүүдийнхээ төлөө хийдэг байсан. Бусад хүмүүсийн талаар өөр өөр сэтгэгдэлтэй. Гэхдээ энэ хоёр зүйл маш чухал. Үүний дараа Мандухай. Эхэндээ түүний тухай тийм сайн мэддэг байгаагүй учир түүний тухай сонсоод л сонсоод л байдаг байсан бөгөөд тэрбээр миний хувьд тэс өөр хүн байсан. Гэтэл аажим аажмаар түүнд маш ихээр татагдаж болж ирсэн. Яг л эгч шиг, яг л гэр бүлийнхнээ өөр өөрөөр хайрладаг нэг гэр бүл шиг.

-Таны хайрлаж хүндэлдэг зохиолч хэн бэ?

-Миний хувьд хамгийн чухал нь Марко Поло байсан. Өөрөө Америкийн фермерүүд амьдардаг нутагт төрж өссөн тул том хотуудад, Нью-Йорк, Вашингтонд очиж байгаагүй. Тиймээс Марко Поло надад дэлхийг нээж өгсөн юм. Би 12 настай байхдаа Чингис хааны тухай ном уншсан. Энэ номыг Англи зохиолч бичсэн байсан. Түүнийг Харолд Ламб гэдэг бөгөөд үүнээс хойш л Монголд дуртай болсон доо.

-Та анх хэдэн онд Монголд ирсэн бэ?

-1998 онд ирсэн. Би Монголд хайртай. Америк бол миний төрсөн нутаг, харин Монгол бол миний сэтгэл зүрхний нутаг. (тэрбээр энэ өгүүлбэрийг монголоор хэлсэн юм).

-Чингис хааны үед худалдаа наймаа, газар тариалан аль хэдийнэ хөгжсөн байсан. Аялал жуулчлалын салбар хөгжсөн байсан болов уу?

-Өгөөдэй хааны үеийн эхэнд европчууд болон гадаадынхан Монголд ирж эхэлсэн. Заавал жуулчид ч биш л дээ, заримдаа дипломат ажилтнууд мөн тагнуул туршуулууд ч ирж байсан. Гэхдээ би тэдний бичсэн зүйлийг дахин дахин уншиж үзэхэд тэд ч мөн адил жуулчид байсан юм байна гэдгийг хэлж чадах байна.

-Аялал жуулчлалын салбарыг Монголд яаж хөгжүүлбэл зохилтой вэ?

-Миний бодлоор энэ үйл ажиллагаа хэдийнэ

» эхэлсэн. Монгол Улс өдгөө дэлхий дахинаа алдаршиж байна. Уул уурхайн салбар хөгжиж, Монголын тухай олон кино гарч, түүхэн сэдэвт номууд бичигдэж байгаагаас Монгол Улс их алдаршиж байна. Энэ бүгд нь гадаадын жуулчдын анхаарлыг татаж байна. Хүмүүс Монголд ирээд энэ бол үнэхээр онцгой газар гэдгийг олж мэднэ. Энэ ямар үлгэрийн юм шиг сайхан газар болохыг тэд үзэж бусад хүмүүст бас хэлнэ. Тэгэхээр олон хүн Чингис хааны энэ ер бусын нутгийг, морин хуурын эх орон, уртын дуу, хөөмийн эх нутгийг ирж үзэхийг хүснэ. Энэ бүхэн миний бодлоор хүмүүст Монголд ирэх хүсэл төрүүлнэ. Энэ үйл явц эхэлсэн, гэхдээ удаан явцтай.

-Та бага насны дурсамжаасаа сонирхуулахгүй юу. Таны өсөж төрсөн нутагт Монгол оронтой ижил төстэй зүйл байгаа юу?

-Бид аав ээжээсээ долуулаа. Миний төрж өссөн Өмнөд Каролин бол маш их ой, өтгөн бут ихтэй, маш халуун газар. Бас нэлээд чийглэг. Гэхдээ зарим төстэй зүйл бий. Эрчим хүч байгаагүй тул бид гал түлдэг байсан. Миний багад түлдэг байсан галын үнэр Монголын галын үнэрээс өөр. Гэхдээ л миний хувьд монгол айлд ороод, галын утаа үнэртэхэд сэтгэлийн гүнд ямар нэг гэртээ байгаа мэт сэтгэгдэл төрдөг.



Тэрбээр монгол шавийнхаа хүүг эрхлүүлэх дуртай

Мөн манайх хэдэн үнээтэй байсан учраас шинэхэн бэлтгэсэн цагаан идээ байдаг байсан. Бас усаа гүний худгаас авдаг. Ус ч бас өөрийн өвөрмөц амттай. Монголын ус миний бага насандаа ууж байсан уснаас өөр амтагддаг. Гэлээ ч гэсэн энд ирээд уснаас нь ууж, галын утаа үнэртэхэд надад төрсөн гэрийг минь санагдуулдаг.

-Монголын түүх дэлхийн түүхэнд хэр жин дарах вэ?

-Би Чингис хаан бол сүүлийн хэдэн мянган жилийн хугацаанд амьдарч байсан хамгийн чухал хүн гэж боддог. Монгол улс үүгээрээ тусгай байр суурь эзлэх учиртай. Үнэндээ ихэнх улс орны ихэнх хүмүүс монголд тийм их ач холбогдол өгөхгүй байгаа нь үнэн. Энэ бол миний засах гэж оролдож байгаа зүйл, дэлхий нийтээрээ Чингис хаан болон түүний эх орон Монголын тухай, түүний түүхийг судалж байх ёстой билээ. Хүмүүс Монголын түүх, Нууц товчоог судлан хэчнээн их зүйл суралцаж болох билээ. Мөн түүнчлэн Чингис хаан бол дэлхийн түүхэнд эсгий гэрт төрсөн мөн насан эцэслэсэн хамгийн аугаа байлдан дагуулагч гэдгийг санах нь чухал. Тэрбээр дэлхийг өөрчилж ард түмнээ баян болгосон. Гэвч эцэст нь жирийн малчны адил амьдарсан. Дэлхий дээр түүн шиг эгэл жирийн амьдралаар амьдарсан аугаа удирдагч байхгүй. Бид Чингис хаанаас суралцах хэрэгтэй.

-Гэр бүл бол нийгэмд маш чухал зүйл. Та Монголын залуучуудад хандаж юу хэлмээр байна?

-Тийм ээ, эцэг эх, ах эгч болон хүүхдүүдийн амьдралд гэр бүл хамгийн чухал зүйл гэж боддог. Хэрэв бид Монголын хуучин цаг үеийг дахин харвал энэ үндэстэн Чингис хааны гэр бүлийн хүрээнд үндэслэсэн байдаг. Өзлүн эх ба түүний хүүхдүүд, Алангуагийн гэр бүл, түүний хөвгүүд гэх мэт. Та нар хамтран ажилласнаар яг л нэг гэр бүл шиг бүгдийг хийж чадна. Алангуа өөрийн хөвгүүдэд сургасан шиг хэрэв та нар өөр хоорондоо дайтан тэмцэлдвэл юунд ч хүрч чадахгүй.

Заримдаа монголчуудыг баяжихын төлөө бие биетэйгээ тэмцэлдэж байгааг хараад түгших сэтгэл төрдөг. Гэтэл монголчуудын түүхэнд хамгийн баян байсан үе бол бүгд хамтдаа хүн бүрийг баян болгохын төлөө ажилласан тэр цаг үе. Хэрэв монголчууд Чингис хааны үе шиг хамтдаа ажиллаж эхэлбэл Монгол Улс дахин дэлхийн хамгийн баян улс орон болж чадна.

-Бидний асуугаагүй үлдээсэн зүйл байвал, мөн манай сэтгүүлээр дамжуулж нийт уншигчдад Та юу хэлмээр байна вэ?

-Бид одоо Монголын түүхийн маш чухал цаг үед амьдарч байна. Бид Монгол үндэстний IX зууны эхэн үед байгаа. Хэрэв монголчууд хамтран ажиллаж чадвал энэ зуун Монголын түүхэнд хамгийн аугаа цаг үе болох боломж байна гэж итгэдэг. Үүнийг хийхийн тулд монголчууд өөрсдийн өв уламжлал, түүхээ ямагт санаж, түүхээ хайрлах хэрэгтэй. Монголын залуус гадаад кино, хөгжим, хип хопд дурлаж болно. Гадаадын хоол хүнс идэлгүй л яахав. Гэхдээ монгол хүүхдүүд өөрсдийгөө монгол гэдгээ мэддэг байх ёстой. Тэгвэл монголчууд хамгийн аугаа зууныг бий болгоно. ■

Зочломтгой бас хамтач байхын учир

Наадмаар зурагт үзэж суухад, гудамж, талбайгаар хэсүүчлэх гадаадын жуулчдаас “Монгол орон, монгол наадам хэр таалагдаж байна вэ?” гэж асууж буй хэсэг гардаг. Ёс юм шиг давтагддаг энэхүү сурвалжлагчийн асуултын хариу нь мөн л ёс юм шиг ижил байх нь олонтаа. Тухайлбал, “танай сайхан оронд ирсэндээ үнэхээр баяртай байна, хүмүүс нь их зочломтгой юм” гэх зэрэг үгсийг эелдэг инээмсэглэл дагуулан хэлдэг. Гэвч интернэт ухаж үзвэл, Монголд аялж үзсэн зарим жуулчдын сэтгэгдэл үнэндээ зурагтаар үзүүлсэн шиг сайхан байдаггүй нь харагддаг. Монгол руу очих үнэтэй, үйлчилгээний чанар дорой, мөн зарим нь уйтгартай гэнэ. Сэтгэгдэл нь мэдээж хэн нэг хувь хүн, эсвэл аль нэг аж ахуйн нэгжийг онцлоогүй, харин Монгол Улсыг ерөнхийд нь тодорхойлсон байдаг.

Дэлхийн ихэнх орон аялал жуулчлалыг экспортын бие даасан салбар гэдэг үздэг. Учир нь гаднын жуулчид ирж бараа үйлчилгээ худалдан авдаг. Монголын ихэнх ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрүүд ч энэ замаар экспорт хийдэг. Гэвч монголын ноолууран цамц, ороолт сэлтийг яг хэн аваад байна вэ гэсэн асуулт гарч ирнэ.

Монгол Улсад жилд 500 мянга орчим жуулчин ирдэг гэсэн албан ёсны статистик үзүүлэлт бий. Эдгээр “жуулчдын” тал нь буюу 50 орчим хувь нь өмнөд хөршөөс ирдэг улирлын чанартай ажиллагаад байдаг. Харин 25 орчим хувь нь жижиг наймаа хийхээр орж ирсэн умард хөршийн “ганзагачид” аж. Харин үнэхээр Монголд амръя, байгаль, соёл уламжлалтай нь танилцъя гэсэн “жинхэнэ” жуулчид нь нийт зорчигчдын 25 хувь буюу 125 мянга орчим байх боломжтой. Эдгээр “жинхэнэ” жуулчдын ихэнх нь БНСУ, Япон, АНУ болон Европын Холбооноос ирж буй бөгөөд тэд ноолууран эдлэлийн гол худалдан авагч болно. Тэгэхээр Монгол Улс жилдээ 100-120 мянга орчим жуулчин хүлээж авдаг. Энэ тоо цаашид өсөх хандлагатай байгаа юм. Мэдээж, эдгээр жуулчдын зарцуулж буй мөнгөний хэмжээ адилгүй. Зарим нь долоо хоногт 400 орчим америк доллар зарцуулж байхад зарим нь 1000 орчим америк долларт хүргэх жишээтэй. Зочид буудал, зоогийн газар, амралт сувилал, аяллын үйлчилгээ үзүүлэгчдийн орлого зэргээр дамжуулан аялал жуулчлалын салбар Дотоодын нийт бүтээгдэхүүний 5-7 хувийг бүрдүүлдэг гэсэн тоо бий.

Эдийн засагт оруулж буй хувь нэмэр, түүнчлэн ажлын байр бий болгодог утгаараа аялал жуулчлалын салбар нь уул уурхайгаас ч дутахгүй ач холбогдолтой байх боломжтой нь харагдаж байна. Гэвч өсөх боломжтой энэ салбарт уул уурхайн салбар аюул занал учруулах болов. Түүхий эдийн экспортоос орж буй гадаад валютын урсгал нь төгрөгийн ханшийг чангаруулж, долларын ханшийг сулруулснаар, ихэвчлэн доллараар орлого олдог жуулчны компаниудын алдагдал өсч буй юм. Дээр нь сайн орчуулагч, хөтөч нараа томоохон уурхайн компаниудад алдах болжээ.

Түүнчлэн энэ салбарынхны өөрсдийн зохион байгуулалтгүй байдал бас нэрмээс болж байна. Уг нь Монгол соёлыг дэлхийд таниулж буй утгаараа аялал жуулчлалынхан даяаршиж буй өнөөгийн ертөнцөд үндэсний аюулгүй байдлыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь илт. Гэвч нэг уулын мухар сахиж аваад, бие биенээсээ өрсөн үнээ буулгаж, тэр хэрээр чанараа унагаж буй “довын



сэтгэлгээ” нь нийт салбарынхаа нэр хүндийг унагаж, өрсөлдөх чадварыг нь доройтуулж буй юм.

Олон улсын нислэг үйлдэх эрх бүхий үндэсний агаарын тээврийн ганц компани нь төрд данстай. Төрийн өмчийн энэ компаниа хамгаалах гэсэн төрийн бодлогын үр дүнд гаднын томоохон авиа компаниуд манай агаарын тээврийн зах зээлд аажмаар ноёрхлоо тогтоосоор байна. Төрд ашигтай зүйл бүр ард түмэнд ашигтай байх албагүй. Харин ард түмэнд ашигтай зүйл бүр төрд ашигтай байх учиртай. Эндээс юу хэлэх гээд байна вэ гэхээр аялал жуулчлалын салбарыг боомилж буй агаарын тээврийн үйлчилгээнд илүү өрсөлдөөн бий болгож, үнийг бууруулах замаар ирж буй урсгалын эрчийг нэмэх шаардлагатай байна.

Амь амиа бодсон аялал жуулчлалын олон компанийн амбицийн эсрэг үндэстний өрсөлдөх чадварын эрх ашгийг сөргүүлэн тавьсан төрийн бодлого ч ус агаар мэт хэрэгтэй байна. Жишээ дурдъя. Өнөөдөр Монголд банкны болон гар утасны зах зээл харьцангуй эрчтэй бас өрсөлдөөнтэй хөгжиж байна. Яагаад тэр вэ? Энэ хоёр салбарт нэгдсэн хэмжүүр болоод, нэгдсэн стандарт, шаардлага тавьдаг байгууллагууд байдаг юм. Монголбанкаар жишээ авъя. Энэ нь банкуудад ижил шаардлага тавьж, бас зөвшөөрөл олгодог. Банкны нийт зах зээлийн статистик, тоон үзүүлэлтийг цуглуулан нэгтгэж, ерөнхий хандлагыг тодорхойлж өгдөг. Нийт зээлдэгчийн тоо, зээлийн чанар, банкуудын зах зээлд эзлэх хувь, нийт секторын өсөлт гэх зэрэг үзүүлэлтийг харах боломжтой. Үүрэн холбооны зах зээл ч мөн адил харьяа хороондоо мэдээллээ хүргүүлж байдаг. Гэтэл аялал жуулчлалын салбарт иймэрхүү өсөлт, бууралт болон хандлагыг хэмжих боломж маш хомс байна. Өөрөөр хэлбэл, “хэмжиж чадахгүй зүйлээ удирдаж чадахгүй, удирдаж чадахгүй зүйлээ сайжруулж чадахгүй” хэмээх үг энд биеллээ олж буй юм.

Энэ салбарыг харьяалдаг Засгийн газрын байгууллага бол бий. Гэвч тэдэнд Монгол банк шиг эрх алга. Энэ салбарт мэргэжлийн холбоод бий. Гэвч юу хийгээд байгаа нь ойлгомжгүй, бүрхэг байдаг нь эрхзүй болон үйл ажиллагааны чадамж нь тодорхой бус байдагтай холбоотой байж болох юм.

Ямартай ч энэ салбарт хамтач сэтгэлгээг түгээсэн, Монгол Улсын нэгдсэн маркетингийн бодлогыг зангидан боловсруулж, хэрэгжүүлэх чадавх бүхий байгууллага хэрэгтэй байна. Тус байгууллагын үндсэн үүрэг нь аялал жуулчлалыг кластер маягаар хөгжүүлэхэд оршино. Тэднэгдсэн стандарт боловсруулж, дүрэм зөрчигчдийг сахилгажуулах замаар салбартаа дэг журам тогтоож, гадаад нэр хүндийг өргөх ёстой. Жуулчдаас сэтгэл ханамжийн судалгааг тунгмол авч, Монголд дахиж ирүүлэхийн тулд юу хийх ёстойг байнга тандаж байх хэрэгтэй. Интернэт сэтгэгдлүүдэд шинжилгээ хийсэн ч болохгүй зүйлгүй. Монголын компаниуд агаарын тээврийн аварга пүүсээс, хөдөөгийн замын дэргэдэх жижиг гуанз хүртэл нэг баг гэдгээ ухамсарлах шаардлагатай. Ингэж байж бид улс үндэстнээрээ далайн чанадын зах зээлд Хавайтай өрсөлдөж чадна. Өвөр хоорондоо өрсөлдсөн жалгын сэтгэлгээнээс хальж үндэстний хамтач сэтгэлгээг бий болгож чадвал Монголын аялал жуулчлалын салбарын өмнө асар том боломж нээгдэх нь тодорхой. ■



Агаарын тээвэр

Ц.Орхон: МИАТ-ийн үйлчилгээ гурван одын түвшинд явж байна

МИАТ компанийн гүйцэтгэх захирал Ц.Орхонтой ярилцлаа.

-Аялал жуулчлалын улирал эхэлж байна. МИАТ бэлэн үү?

-Аялал жуулчлал гэхээр зөвхөн гадаадаас жуулчин хүлээн авдаг гэсэн ойлголт тогтсон байна. Одоо энэ сэтгэлгээг өөрчлөх цаг болжээ. Дотоодын аялал жуулчлал нэлээд хөгжих хандлагатай боллоо. МИАТ компанийн зүгээс дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд авч байна. Өвөл, хавар, намрын улиралд гадаад зах зээл рүү захиалгат нислэг нэмэгдэж байна. Эндээс харахад манай иргэд гадаад улс орон руу аялах сонирхолтой, өөрөөр хэлбэл, дотоодоос гадагш чиглэсэн нислэгийн шинэ урсгал бий болсон. Тэгэхээр гадаадын төдийгүй, дотоодын жуулчлал ч хөгжиж байна гэж ойлгох хэрэгтэй.

Жуулчдын улирал зургадугаар сараас эхэлдэг. Зөвхөн агаарын тээвэр бус зочид буудал, жуулчны бааз, үзвэр үйлчилгээний газрууд нэлээд ачаалалтай ажилладаг. Манай компанийн зүгээс агаарын хөлгийн паркаа 2015, 2021 он хүртэл шинэчлэх тойм төлөвлөгөө гаргасан байгаа. Энэ хүрээнд ялангуяа том онгоцыг авч ашиглах зорилготой ажилласнаар Боинг767 буюу 263 суудалтай том онгоц өнгөрсөн тавдугаар сарын 25-нд ирсэн. Одоогоор шинэ онгоц маань Москва, Берлин, Сөүлийн чиглэлд түлхүү нисэж байна. Эдгээр чиглэлд суудал дүүргэлт нэлээд сайн байгаа. Парк шинэчлэлийн хувьд Монгол Улс стратегийн ач холбогдолтой салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын хэмжээнд авч үзэж, төрийн бодлогоор зохицуулж хөгжүүлэх ёстой. Бид агаарын тээврийг зүй зохистой хөгжүүлэх асуудалд төрийн хэмжээнд анхаарах ёстой талаарх байр сууриа холбогдох газруудад хатуу илэрхийлдэг.

Үүний зэрэгцээ Хонконгийн чиглэлд тогтмол нислэг шинээр нээлээ. 2002 оноос хойш манай улс гадаад талдаа шинэ урсгал нээгээгүй явж ирсэн. Аялал жуулчлалаас гадна Монголын эдийн засгийг сонирхох гаднынхны хандлагатай холбоотой бизнес урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор долоо хоногт хоёр удаа тогтмол нислэг үйлдэж байна. Нислэгийн хувьд боломжийн байгаа. Энэхүү шинэ нислэгээр Хонконг, Зүүн өмнөд



Ази руу аялах боломжийг монголчуудад олгож буй юм. Мөн Улаанбаатараас Берлин рүү хийдэг долоо хоногийн хоёр нислэгийг энэ жилээс шууд болгож байна. Москвагаар дайраад нисэхээр зорчигчдын хувьд хүндрэлтэй асуудал олон гардаг. Ачаа тээш алга болох, Шереметьево онгоцны буудлын хүнд суртлаас манай зорчигчид нэлээд чирэгддэг л дээ. Уг байдлыг халах зорилгоор Берлин рүү шууд нисэх арга хэмжээг авсан. Энэ зун Берлиний чиглэлд долоо хоногт дөрвөн удаа ниснэ. Мөн Токиогийн чиглэлд долоо хоногт тав, Осакагийн чиглэлд хоёр удаа буюу Японы чиглэлд өдөр бүр нисэхээр ийн төлөвлөж байна.

-МИАТ компани нэг онгоц аваад, нөгөөг нь худалдаж байгаа гэсэн. Ялгаа юу байна вэ?

-Онгоц түрээсэлж, ашиглах нь зардал их шаардсан бизнесийн үйл ажиллагаа. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдад аятай тухтай үйлчилгээ үзүүлэхийн тулд зардлаа бууруулах нь чухал. Энэ хүрээнд бид парк шинэчлэлийн бодлого боловсруулсан. Өөрөөр хэлбэл, нэг үйлдвэрлэгчийн онгоц ашиглаж зардлаа бууруулах зорилготой ажиллаж байна. Тиймээс хуучин ашиглаж байсан Аэробус А-310-аа борлуулах ажлыг явуулж байна. Оронд нь миний дээр ярьсан Боинг 767 онгоцыг авч байгаа юм. Намраас хоёр дахь онгоцыг мөн түрээсээр авахаар төлөвлөж байна.

-Гаднаас ялангуяа аялал жуулчлалын улиралд Монголыг чиглэх жуулчдын урсгалыг МИАТ-ийн чөдрийн хоёр морины хүчин чадал дийлдэг үү?

-Монголын аялал жуулчлалын зах зээлд манайхаас ▶

» гадна “Кореан Эйр”, “Эйр Чайна” гэсэн том компаниуд нислэг үйлддэг. Манайхыг бодвол тус компаниуд агаарын хөлгийн парк шинэчлэл, хүчин чадал илүү, том, жижиг олон онгоцтой. “Кореан Эйр” гэхэд л 280 хүний суудалтай А-330 онгоцоор өдөр бүр нисэж байна. Тэгэхээр манай аялал жуулчлалын агаарын тээврийн гадаад зах зээлд зөвхөн МИАТ-ээс гадна олон улсын чанартай баг үйлчилж байна хэмээн ойлгох нь зөв болов уу.

-МИАТ-ийн нислэгийн үнэ тарифыг нэлээд өндөр гэдэг. Үнэ бууруулах ямар нэг арга зам байдаг уу?

-Үнэ тарифын хувьд манайх харьцангуй хямд шүү дээ. Бусад улсын авиакомпанийн нислэгийн үнэ нэлээд өндөр байдаг. Зардал ч өндөр тусдаг байх. Харин манайх шатахууны зардлыг эс тооцвол харьцангуй бага зардалтай. Тэгэхээр үнэ гадаад зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд байлгахад анхаарч ажиллаж байна. 2011 оны эхний таван сарын үзүүлэлтээр манай компанийн зорчигч тээврийн урсгал 42 хувиар нэмэгджээ. Энэхүү өсөлтийн гол хувь нь Бээжингийн чиглэлд үйлдсэн нислэг эзэлж байна. Бээжин рүү өмнө нь зуны улиралд долоо хоногт 8-9 удаа нисдэг байсан бол өнөөдөр өвлийн туршид, долоо хоногт 10 удаа нисэж байна. Зах зээл ийнхүү өргөжиж буй нь манай нислэгийн үнэ боломжийн гэдгийг харуулж байгаа юм. Үнэ тарифт нөлөөлөх гол зүйл бол түлш шахатууны үнэ байдаг.

-МИАТ-ийн менежментийн хувьчлалын асуудлыг хэрхэн шийдэхийг хүлээж байна. Таны хувьд ямар бодолтой байна. Ер нь МИАТ-ийн хувьчлалын тухай 10-аад жил ярьж байна шүү дээ?

-Монгол Улс хоёр их гүрний дунд байдаг, далайд гарцгүй гэдэг утгаар ганц авиакомпани нь төрдөө байсан нь дээрээ гэж үздэг. Хуулинд ч улсын болон хувийн компанид төрөөс баримтлах бодлого адилхан байна гэж заасан байдаг. Тэр утгаар ямар ч компани улсынх уу, хувийнх уу гэдгээс үл хамаараад ашигтай л ажиллах ёстой. Тэгэхээр МИАТ компани улсынх, эсвэл хувьчлагдана гэдэг хандлагаар бус үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Гэхдээ өнөөгийн бизнес хөгжлөө дагаад хурдан өөрчлөгдөж, тэр хэрээр компаниуд шийдвэрээ хурдан өөрчилж, шинэчлээд явж байна. Харин улсын компанийн хувьд тухайн нөхцөл байдлаас шалтгаалан шийдвэрээ хурдан гаргаад үр ашгаа хүртээд явах байдал удаан гэгддэг ганц учир дутагдалтай бөгөөд энэ талаас нь харвал хувьчлагдвал илүү үр дүнтэй.

Менежментийн хувьчлал нь гаднын багаар удирдуулж компанийнхаа менежментийг сайжруулах асуудал юм. МИАТ компанийн үйл ажиллагаагаа гадаадын багаар удирдуулах талаар Төрийн өмчийн хороо ярьж байгаа. Тодорхой шийдэлд хүрээгүй байна. Гадаадын мэргэжилтнүүд дэд захирал, ерөнхий захирлын хэмжээнд ирж ажиллах байх гэсэн ойлголттой байна. Зарим америкийн зөвлөхүүд МИАТ компанид гадаадын баг шаардлага байхгүй, харин гаднын зөвлөхүүдийг урьж авчирч, үйл ажиллагаандаа дэмжлэг үзүүлэх нь илүү үр дүнтэй гэсэн зөвлөмж өгсөн байна лээ.

-МИАТ дэлхийн агаарын тээврийн хөгжлийн

хаахна явна вэ?

-Иргэний агаарын тээвэр нь бусад эдийн засгийн салбартай харьцуулахад байнга түрүүлж хөгжиж явдаг. Агаарын тээврийн бизнес бол зөвхөн тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг гэсэн ойлголт байж болохгүй. Тухайлбал, МИАТ олон улсын зах зээл дээр жижиг компани ч Хятад, Солонгос, ОХУ, Герман, Япон, АНУ-д хүртэл өөрөөр хэлбэл. Транснационалийн үйл ажиллагаа явуулдаг дотоодын бизнесийн аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахын аргагүй өндөр түвшинд хөгжиж яваа гэж ойлгож болно. Жишээ нь олон улсын агаарын тээврийн холбооноос манай компанийн үйл ажиллагаа аюулгүй байдалд хоёр жил тутамд аудит хийж, гэрчилгээ өгдөг. Энэ гэрчилгээг бид 2009 онд авсан. Өнөө жилийн шалгалт энэ оны намар болно. Мөн авиакомпани гэхээсээ илүүтэй Монгол Улсын иргэний нисэхийн бүтэц, аюулгүй байдал, үйл ажиллагаа ямар түвшинд байгаа талаар НҮБ-ын төрөлжсөн иргэний нисэхийн ИКАО байгууллагаас өнгөрсөн оны намар хоёр ч удаа аудит хийж, Монголын агаарын тээврийн салбар олон улсын түвшин, зэрэглэлд хүрсэн байна гэж дүгнэсэн. Мэргэжлийн байгууллага ийм дүгнэлт хийчихээд байхад зарим сонин хэвлэлээр МИАТ, Монголын агаарын тээврийн салбар болохгүй бүтэхгүй байгаа юм шиг бичдэг нь харамсалтай санагддаг.

-МИАТ-ийн үйлчилгээ сайнтай муутай яригддаг. Үйлчилгээг сайжруулах талд хэр анхаарч байна вэ?

-Үйлчилгээг сайжруулах нь манай компанийн хувьд шийдвэрлэх асуудлуудын нэг. Дэлхийн авиакомпаниудыг үйлчилгээ, чанар, стандартаар тодорхой түвшинд авч үздэг. МИАТ-ийн үйлчилгээний түвшин таван одын зэрэглэлээр гурван одын түвшинд явж байна. Үйлчилгээг сайжруулах, стандартыг мөрдөх чиглэлээр дэлхийн таван одтой авиакомпаниудын үйлчилгээний түвшинд очих зорилго тавьсан. Тухайлбал, ажилтнуудынхаа зан харилцааны соёл, хувцсыг шинэчлэх, өөрчлөх, хоол ундыг чанаржуулах гээд жижиг ажлууд хийж байгаа.

-Тэгвэл нисгэгч бэлтгэх асуудал иргэний агаарын тээврийн хамгийн том зүйлийн нэг байдаг. Нисгэгчийг хэрхэн яаж бэлтгэж байна вэ?

-Иргэний агаарын тээврийн салбар цаашид эрчимтэй хөгжих төлөв харагдаж байгаа. Ер нь зөвхөн манайд бус дэлхий дахинаа нисгэгчийн хүрэлцээ хүнд шүү дээ. Монгол Улс өмнө нь нисгэгч нарыг тодорхой хэмжээнд бэлтгэж байсан. Цаашид манай компани ИНЕГ-тай ярилцаад жил бүр тодорхой хүрээнд нисгэгчийг бэлтгэх чиглэлээр хамтарч ажиллахаар төлөвлөсөн. Нисгэгч болох хүсэл эрмэлзлэлтэй хүүхдүүд өөрсдийн зардлаар суралцаад ирэх боломжгүй байдаг. Нэг нисгэгчийг бэлтгэхэд 100 мянган долларын зардал гардаг. Сургуулиа дөнгөж төгсөөд ирсэн нисгэгч маань дадлага хийх ёстой. Манай нисгэгч нар жилд хоёр удаа АНУ-д очиж, байнгын дадлага хийдэг. Нисгэгч нарыг бэлтгэх асуудлыг төрийн оролцоотой бодлоготой авч үзэх ёстой. Агаарын хөлгийн парк шинэчлэлээс илүүтэй нисгэгч нарыг бэлтгэн сургах нь иргэний агаарын тээврийн компаниудын хувьд хамгийн том асуудал байдаг. ■

“Амжилт хүсье”

Улаанбаатараас Дархан-Уул аймаг орох замд “Хурд-Үхэл” гэсэн анхааруулгатай сампирсан автомашины сэг тааралддаг даа. Энэ нь хурд хэтрүүлэн давхих нь юунд ч хүргэж мэдэхийг анхааруулсан хэрэг биз. Тэгвэл Монгол Улсын төр, засаг тэр аяараа сагсуу жолооч болж хувирсныг анзаарах хүн байгаа болов уу?

“Эдийн засаг түүхэнд байгаагүй өндөр хурдаар өсөж байгааг тэмдэглүүштэй. Энэ оны эхний улиралд 9.7 хувиар өссөн байна” хэмээн Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун Хөгжлийн банкны нээлтийн үеэр онцолж байв. Гэвч энэ хугацаанд иргэдийн амьжиргаа 9.7 хувиар дээшилж чадсан гэж үү? Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд нэгдүгээр улиралд монгол өрхийн сарын дундаж мөнгөн орлого 453.5 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар нэмэгджээ. Гэтэл мөн хугацаанд өрхийн сарын дундаж зарлага 28.9 хувиар өсөж, 487.2 мянган төгрөгт хүрсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл, эдийн засаг хурдтай өссөн ч иргэдийн амьжиргаа улам доройтжээ. Долоон буудлын Доржийн гэр бүл хоногийн хоолоо аргацаахын тулд ах дүү, төрөл төрөгсдөө царай алдаж, бүр болохгүй бол байдгаа ломбардаж, урд хормойгоороо хойд хормойгоо нөхөн амь зуусан хэвээр.

“Би 1958 онд төрсөн. Намайг сургуульд орох үед долоо хоногт ганц удаа халуун усанд орохын тулд гэр бүлийнхэн маань нэг л банн руу цувардаг байсан юм. Тэр үетэй харьцуулахад Нидерландад амьжиргааны түвшин өнөөдөр асар сайжирсан. Гэхдээ манай эдийн засаг хэзээ ч 10 хувиар өсөж байгаагүй юм шүү” хэмээн Дэлхийн банкны тэргүүлэх эдийн засагч Рожер ван дэн Бринк ярьж байна. Нидерланд улсын эдийн засаг жилдээ 3-4 хувиар өсдөг бөгөөд таван хувийн өсөлт тохиоход “бүүм” болж байна гэж иргэд нь гайхширдаг ажээ. Гэсэн ч энэхүү

тогтвортой өсөлт нь хүмүүсийн амьдралд бодит өөрчлөлт авчирч чадсаныг Рожер тайлбарлав. Голландөвчнийг дэлхийд таниулсан хэдий ч түүнийгээ эмчилж чадсан Нидерланд улсад төрж, өссөн тэрбээр монголчууд энэ зовлонг дайрч биш, тойрч гараасай гэсэндээ зөвлөгөө өгч, туршлагаасаа хуваалцсаныг уншигчдадаа хүргэх гэсэн юм. Яагаад манай эдийн засгийн байдал түүний санааг зовоох болов?

Нидерландчууд 1959 онд байгалийн хийн асар их нөөцтэй болохоо мэдэж, 60-70-аад онд түүнийгээ олборлон экспортолсноос төсвийн орлого нь үлэмж ихээр нэмэгджээ. Тэр үеэс Засгийн газар нь яг л монголчуудын адил хүүхдийн мөнгө, ажилгүйдлийн тэтгэмж, цалин, тэтгэврийн хэмжээг өсгөж, боловсрол эрүүл мэндийн салбарт татаас өгч эхэлсэн байна. Гэтэл үүнээс болж Нидерландын экспортод томоохон байр суурь эзэлж байсан усан онгоц болон автомашины үйлдвэрлэл, нүүрсний уурхайнууд хүнд байдалд орж, олон ажлын байраа алдсан юм билээ.

“Бодит эдийн засагт ийм өөрчлөлт гарч байхад Засгийн газар орлого ихтэй хэвээр л байв. Хүнийг төрсөн цагаас нь авсанд орох хүртэл нь төрөөс бүхнийг дааж байсан болохоор манайх халамжийн улс болсон байлаа” хэмээн Рожер тэмдэглээд, энэ бүхнийг санхүүжүүлэхийн тулд Засгийн газар нь бэлэн мөнгөө зараад зогсохгүй газрын хэвлийд байгалийн хий байгаа юм чинь ирээдүйд орлого олох нь гарцаагүй гээд зээл авч байсан тухай ярилаа. Нидерланд улсын төсвийн хэмжээ тэлж, инфляци гаарч, тэр хэрээр өр нь ч талийсан байна. Энэ замаар 20 жил явсны эцэст 1980-аад онд гэнэт уналтад орж баларчээ. Тэгээд Нидерландын хүн бүхэн бодит байдлаа харсан бөгөөд ийм замаар үргэлжлүүлэн давхиж болохгүйгээ ойлгосон байна. Ингээд 1982 онд Нидерландын Засгийн газар, хувийн хэвшлийн төлөөлөл, үйлдвэрчний эвлэлтэйгээ хамтарч ажиллахаар

шийдээд, ширээний ард сууж гурван талт түүхэн пакт байгуулсан байдаг. Энэхүү бичиг баримтын гол зорилго нь инфляцийг бууруулах, халамжийн хөтөлбөрүүдийг багасгах, хүмүүсийн ажил хийх хүсэл эрмэлзлэлийг дэвэргэх чиглэлийг дэмжихэд анхаарах явдал болой.

“Би тэр үед оюутан байсан. Үнэ төлбөргүй сураад л, тэтгэлэг аваад л, зах дээр очоод цагийн ажил хийлээ гэхэд өндөр цалин авчихна. Ажил хийх шаардлагагүй, хүн бүхэн энэ байдалдаа дуртай байсан нь мэдээж. Гэтэл Засгийн газар зардлаа бууруулж эхлэх үед маш их хэмжээний улстөржилттэй тулгарч билээ” гэж Рожер дурсаж байна. Гэхдээ ингэснээрээ нидерландчууд алдаагүй ажээ. Эдүгээ тус улс Европын нөлөө бүхий эдийн засагтай орнуудын нэг бөгөөд 2008 оны хямралыг ч ажралгүй давсан билээ. Монголчуудын өнгөрсөн онд баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол Нидерландын 1982 оны пакттай утга нэгтэй болохыг Рожер тэмдэглэсэн юм.

Уг нь 2005 он хүртэл Монгол Улсын төсөв нэлээд тогтвортой байж ирсэн. Үүнээс хойш дэлхийн зах зээл дэх эрдэс баялгийн үнэ өсөж, манай төсөвт орох орлого ч нэмэгдсэн. Энэ хэрээр эрх баригчид зарлагаа нэмж, 2007 онд бэлэн мөнгө эрчимтэй тарааж эхэлснийг Та санаж байгаа байх. Гэтэл хямралын үед яалаа даа? Хуримтлуулсан юмгүй цөхөрч, тив дамнан бадар барьж явсан нь саяхан даа, манай эрх баригчид. Дахиад ийм байдалд орохгүйн тулд УИХ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлаад бүтэн жилийн нүүр үзэж байна. Гэтэл нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох, тухайн жилийн төсвийн зарлагын өсөлтийн хэмжээ ДНБ-ий хоёр хувиас хэтрэхгүй байх, улсын өрийн үлдэгдэл ДНБ-ий 40 хувиас бага байх зэрэг уг хуулийн амин судас болсон шаардлага 2013 оноос л үйлчилж эхлэхээр байгаа юм. 2012 оны сонгууль өнгөртөл

► назгайрч, бэлэн мөнгө тарааж, ахиад төрийн эрхэнд гарч ирчихээд лажил хэрэг болгоё хэмээн бодлого боловсруулагчид сэтгэл шулуудсан бололтой.

“Яагаад энэ хуулийн хэрэгжилтийг 2013 он хүртэл хүлээх ёстой гэж? Яагаад өнөөдрөөс хэрэгжүүлж болохгүй гэж? 2010 онд төсөв таван хувийн алдагдалтай гарсан бол энэ онд 9.9 хувийн алдагдалтай байхаар баталсан. Энэ хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу 2013 оноос хоёр хувь болгох боломжгүй шүү дээ” хэмээн Рожер анхааруулаад, энэ нь яг л архи, тамхинд донтсон хүн маргаашнаас гарчих юм шиг ярьж явдагтай ижил хуурамч сонсогдож байгааг тэмдэглэсэн юм. “Иргэнийхээ хувьд би энэ хуульд маш дуртай байна, улстөрчийнхээ хувьд бол үзэн ядаж байна” гэж Монголын нэгэн улстөрч хэлж байсныг Рожер санагалзав. Эрх баригчид олсныхоо хэрээр зарцуулж, өрөнд баригдан, өтөнд идэгдэх нь байдаг л зүйл мэт болсон. Сонгуульд нэр дэвшигчид эдийн засаг, санхүү, төсвийн бодит боломжоос хэтэрсэн мөнгийг хүн бүрт амлаж, оноо цуглуулан, төрийн эрхэнд гарах нь хэвийн үзэгдэл болчихсон цагт бид амьдарч байна шүү дээ.


“Монголчууд зэс, нүүрсний үнэ өндөр байгаа дээр бэлэн мөнгө тараах биш, хуримтлал үүсгэх хэрэгтэй” хэмээн Рожер зөвлөж байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаар Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө ДНБ-ий таваас доошгүй хувьтай дүйхүйц байх ёстой. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлогыг дээрх санд төвлөрүүлэх учиртай. Гэтэл энэ шаардлагыг 2018 оноос өмнө л биелүүлнэ гэж зөөлрүүлжээ. Товчхондоо, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль жинхэнэ утгаараа хэрэгжиж эхэлтэл зай ч байна, лай ч байна. Тэр хооронд харин дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өндөр хэвээр байгаасай гэж залбирах л үлджээ. Яагаад гэвэл Монголын өнөөгийн эдийн засгийн нөхцөл 2008 оны хямралын өмнөх үетэй яг ижил байгааг Дэлхийн банкны улирлын тоймоос харж болно. Төсвийн орлого, зарлага асар ихээр

нэмэгдсэн, бэлэн мөнгө тараасан, банкуудын олгосон зээлийн хэмжээ үлэмж өссөн, инфляци гаарсан гээд л... Яг энэ үед зэс, нүүрсний үнэ унах юм бол манай эдийн засаг 2008 оных шигээ хямраад өнгөрөх биш, жинхэнэ сүйрэлд орж мэдэхээр байгааг сануулах юун.

Инфляци бага л байгаа шүү дээ хэмээн Та гайхаж магадгүй. Хэрэглээний үнийн улсын индекс буурч байгаа гэх статистик мэдээлэл дуулдаж байгаа ч махны үнийг салгаад үзэхээр суурь инфляци 10 хувьд хүрсэн бөгөөд цаашдаа 20 хувьд ч хүрч мэдэхийг Олон улсын валютын сангийн Ажлын хэсгийн ахлагч Стивен Барнетт онцолсон билээ. “Инфляци доогуур, ханш тогтвортой байсан тохиолдолд л хувийн хэвшлийнхэнд тусах ашиг өндөр байна. Гэтэл сүүлийн хоёр жилд төгрөгийн бодит ханш 35 хувиар чангарчээ. Энэ нь экспортын бараанд 35 хувийн татвар ногдуулчихаж байгаагаас

өөрцгүй дарамт шүү дээ” хэмээн Рожер анхааруулав. Эрх баригчид орлогоо хадгалах бус, олсныхоо хэрээр зарцуулж байгаагаас л энэ бүх савлагаа үүдэлтэй билээ. Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд энэ оны эхний таван сарын байдлаар улсын нэгдсэн төсвийн тэнцэл 89 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Гэсэн ч энэ нь зэс, нүүрс тэргүүтэй ашигт малтмалын үнэ өндөр байгаатай холбоотой зуурдын үзэгдэл буюу. Дэлхийн зах зээл дэх үнэ өсдөг шигээ буурдгийг 2008 оны зун тонн нь 9000 ам.долларт дөхөж оччихоод, хагас жилийн дотор 2770 ам.доллар болтлоо шалдаа буусан зэсийн ханш гэрчлэх билээ. Монголын эрх баригчид бэлэн мөнгө тараахаа зогсоохгүй бол горьгүйг Рожер сануулаад, “Эрсдэлтэй гэхээс өөр тодотгол алга. Маргааш юу болохыг хэн ч мэдэхгүй шүү дээ” хэмээн онцлов. Хүний хөгжил сангаас иргэдэд

Ирээдүйг харахад?



Эх сурвалж: Монгол Улсын эдийн засгийн улирлын тойм, Дэлхийн банк

► бэлэн мөнгө тараахад 805.2 тэрбум төгрөг төсөвлөсөн байгааг сануулах юун. Тэгсэн атлаа улс орны хөгжилд чухал хувь нэмэртэй төслүүдийг санхүүжүүлэхийн тулд Хөгжлийн банк байгуулж, бонд гаргах нь манай засгийн жижигхэн заль юм уу даа. Өнөөдөр монголчуудын хувьд ус агаар шиг хэрэгтэй байгаа газрын тосны үйлдвэр, Их бүтээн байгуулалт хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэх мөнгөө иргэдэд 21 мянган төгрөг тараахын тулд үрчихсэн юм болохоороо эрх баригчид Хөгжлийн банкны нэрээр зээл авч, түүнийгээ батлан даах төлөвлөгөө боловсруулсан нь энэ ажгуу. “Нүглийн нүдийг гурилаар хуурна” аа гэж...

Гэвч Хөгжлийн банк 800 тэрбум төгрөгийн бонд гаргаж, томоохон төслүүдийг хэрэгжүүлж чадна гэдэгт итгэхгүй байгаагаа Рожер нуусангүй. “Хөгжлийн банкны хувьд санхүүжүүлж болох төслүүдээ

эхлээд ялгах хэрэгтэй. Гэхдээ би үүгээрээ зүгээр л төслийн санааг хэлээгүй юм шүү. Ашгаа өгнө гэдгийг нь тогтоосон, ТЭЗҮ нь бэлэн болсон төслүүдийг ярьж байна. Шинээр байгуулагдсан Хөгжлийн банк нэг төслийг зохих ёсоор нь үнэлж, дүгнэж гаргахад хэр хугацаа шаардагдахыг мэдэхгүй. Олон жилийн туршлагатай, чадварлаг ажилтнууд бүхий Дэлхийн банкаар жишээ авахад нэг төслийг хэрэгжүүлэхэд бэлэн болгоход дор хаяж нэг жил шаардлагатай байдаг юм. Хөгжлийн банк өнөөдөр бонд гаргаад, мөнгөтэй болчихлоо гэж бодъё. Тэрүүгээрээ юу хийх гэж? Тооцоог нь хийчихсэн, бэлэн төсөл алга байна шүү дээ” хэмээн тэрбээр тайлбарласан юм. Төсвийн зарлага хэт тэлсэн, зах зээл дэх мөнгө илүүдээд инфляци гаарах нөхцөл бүрдсэн энэ үед Хөгжлийн банк хэдэн зуун тэрбум төгрөг нэмж асгах юм бол өргөн хэрэглээний

бараа, бүтээгдэхүүний үнэ тэнгэрт хадаад, эргэж буухаа байж ч мэдэх ажээ.

Нидерландчууд алдаанаасаа суралцаж, зөв замаар хөгжилд хүрч чадсан ард түмэн. Харин Монголын эрх баригчид 2008 оны алдаанаасаа огтхон ч суралцаагүйгээр үл барам улам л гүн ангал руу орохоор тэмүүлээд байх шиг. Одоо бүр оюутнуудад хавтгайрсан тэтгэлэг өгөх талаар ч яриад эхэлчихлээ. Бэлэн мөнгө тараалаа гээд иргэдийн амьдрал дээрдэх биш, дордоод байгааг харсан ч хараагүй юм шиг суух уу? Энэ бодлогоо буруу гэдгийг мэдсээр байж хэтэрхий хурдтай зүтгүүлсээр байгаа нь биднийг юунд хүргэх бол оо? Үнэхээр маргааш юу болохыг хэн ч тааж мэдэхгүй шүү дээ. “Амжилт хүсье гэхээс өөр хэлэх үг алга даа” хэмээн Рожер эцэст нь тэмдэглэсэн юм. ■

Эрчим хүч

Хөрөнгө оруулагчид ТЭЦ-5 төслийг сонирхож байна

Эрчим хүчний салбарынхан ирээдүйн бодлого, зорилтынхоо талаар хөрөнгө оруулагчдад танилцуулж, салбарт тулгарч буй бэрхшээл хүндрэл, түүнийг даван гарах арга замынхаа талаар “Монголын эрчим хүч-2011” уулзалтын үеэр ярилцсан юм. Монгол Улсын гал голомтыг сахиж буй энэ салбарынхны хувьд анх удаа хөрөнгө оруулагчдыг урьсан ийм арга хэмжээг зохион байгуулж байгаа аж. Өнөөдрийн улс орны эрчимтэй хөгжлийн гараа эрчим хүчний салбарын бодлогыг шинэ шатанд гаргах, бодлого шийдвэрийг шинэчлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм. Тиймээс ЭБЭХЯ-наас шинэ бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч, улс орны хөгжлийн чанартай томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүний нэг жишээ нь эрчим хүчний шинэ эх үүсвэрийг барьж байгуулах асуудлыг үндсэндээ шийдэж, тендер зарлах

л үлдээд байна. Дээрх чуулга уулзалтын гол үндсэн зорилго ч шинэ эх үүсвэрийн талаар хөрөнгө оруулагчдад танилцуулахад чиглэж байлаа. Уул уурхайн хөгжлөөс улсын халаасанд ихээхэн мөнгө орж ирэх ирээдүйн хандлагатай уялдан, мөн эрчим хүчний шинэ бодлого, эрх зүйн орчин гадна, дотнын хөрөнгө оруулагчдыг татах эхлэлийг тавьж байгааг энэхүү хурал харуулсан юм. 820 МВт-ын хүчин чадалтай шинэхэн станцын асуудал олон хөрөнгө оруулагчийн сонирхлыг төрүүлж байгаа нь лав. Тухайлбал, Францын “Далика” групп манай улсын ирээдүйн хөгжлийн гол түлхүүр болсон тавдугаар станцыг ихэд сонирхож, асуудалд нухацтай хандаж байлаа. Ер нь хөрөнгө оруулагчид орж ирэх эрх зүйн орчин хэр бүрдсэн юм, эрчим хүчний үнэ тариф ямар байгаа вэ гэсэн хоёр асуудалд л гол анхаарлаа төвлөрүүлж байгаа нь илт харагдана лээ. Тэгвэл төрөөс

PPP-гийн зарчмаар эрчим хүчний томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн, нөгөө нь үнэ тарифыг зах зээлийн бодит өртөгт ойртуулахад чиглэсэн алхмууд хийж байгаагаа салбарын удирдлагууд тайлбарласан. Мөн хурлын төлөөлөгчид нүүрсээ ухаж эрчим хүч гаргахаас гадна сэргээгдэх эрчим хүчийг түлхүү хөгжүүлэхэд анхаарал хандуулсан. Ялангуяа импортын эрчим хүчийг халахад гол нөлөө үзүүлэхүйц томоохон хэмжээний усан цахилгаан станц барих цаг болсон тухайд, энэ асуудлыг ажил хэрэг болгох талаар авууштай үнэтэй саналууд хэлж байсан.

Эцэст нь ЭБЭХ-ний сайд Д.Зоригт эрчим хүчний бодит байдал, асуудал, бодлого шийдвэр, хэрэгжүүлэх төслийнхөө талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулсан ийм уулзалтыг салбарын холбоодоос жил бүр зохион байгуулж байхыг уриалсан юм. ■

Судалгаа


Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн зарим асуудал

С.Байгалмаа, /ХААИС-ийн докторант/

Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) нь улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад ашигладаг стратегийн арга хэрэгсэл гэж үздэг.

Орлогын түвшингээс хамааран ЖДҮ-ийн эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол нэлээд ялгаатай байна.

Зураг 1. ЖДҮ-ийн ажил эрхлэлт ба ДНБ-д эзэлж буй хувь



Зураг 2. Албан бус хэвшлийн ажил эрхлэлт ба



ДНБ-д эзэлж буй хувь


Нэг хүнд ногдох орлого өндөртэй улс орнуудын ДНБ-ий 60 гаруй хувь, ажил эрхлэлтийн 50 орчим хувийг ЖДҮ бий болгодог бол орлогын хэмжээ бага улс орнуудын ДНБ-ий 50 гаруй хувь, ажил эрхлэлтийн 50 орчим хувийг албан бус сектор бий болгож байгаагаас үзэхэд ЖДҮ-ийн гүйцэтгэх үүрэг эдийн засгийн хөгжлийн түвшнээс хамааран өөр өөр байна.

Монгол Улсад 2010 оны байдлаар 40.9 мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба үүний 99 хувь нь 49 хүртэл ажиллагсадтай. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн 14.9 хувь нь үйлдвэрлэлийн, 85.1 хувь нь худалдаа, үйлчилгээ, зөөлөн дэд бүтцийн салбарт ажиллаж байна.

2010 онд жижиг, дунд үйлдвэрийн салбар дотоодын

нийт бүтээгдэхүүний 54 хувийг, нийт ажиллагсдын 25.6 хувийг эзэлж байна (Ц.Ням-Осор, 2011). Дунджаас доогуур орлоготой улс орны үзүүлэлттэй харьцуулбал Монгол Улсын ЖДҮ-ийн эдийн засгийн хувь нэмэр өндөр байгаа боловч ажил эрхлэлтэд эзлэх хувь бага байна. Энэ нь, манай улсын цөөн аж ахуйн нэгж ажлын байрыг хамгийн ихээр бий болгох үйлдвэрийн салбарт ажиллаж байгаатай холбоотой байж болно.

ЖДҮ-ийн хөгжилд бизнесийн орчин ихээхэн чухал ач холбогдолтой. Дэлхийн банкнаас хийсэн судалгаанд ЖДҮ-ийн өсөлтөд санхүүжилт, улс төрийн тогтворгүй байдал, гэмт хэрэг шууд нөлөөлдөг бол манай орны хувьд зээл авах, бизнес эхлүүлэх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл зэрэг хүчин зүйл хүчтэй нөлөө үзүүлж байна. Энэ нь бизнесийн орчныг сайжруулах гэсэн төр засгаас тавьж буй зорилттой нийцэж байна. Монгол Улсын ЖДҮ-ийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлс дэлхийн улс орнуудынхтай адил байна.



Эх үүсвэр: Эх үүсвэр: Агуагари М, Demircuc-Kunt, A, V. Maksimovic (2008) хуудас-38

Иймээс, ЖДҮ-ийн өсөлтийг хангахыг хүсвэл улс төрийн тогтвортой байдлыг хангаж, санхүүжилтийг хялбар болгоход чиглэсэн санхүүгийн салбарын шинэчлэлийг хийх нь хамгийн үр дүнтэй арга юм.

ЖДҮ-ийн өсөлтөд санхүүжилтийн үзүүлж буй нөлөө

Манай улсын ЖДҮ-ийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн регресс болон корреляцийн шинжилгээг хийж үзэхэд зээл нь үйлдвэрүүдийн хөрөнгө, тогтмол зардал, хувьсах зардал ажиллагсдын тоо, орлого, ашигт (0.5680,07081,04892, 06423, 05716,0.6431) эерэг хамааралтай байна. Тэгэхлээр санхүүжилтийг нэг төгрөгөөр нэмэгдүүлэхэд үйлдвэрийн ашиг 0.64

► төгрөгөөр, орлого 0.57 төгрөгөөр тус тус нэмэгдэнэ гэсэн үг. Мөн регресс шинжилгээгээр ашиг нь зээл, хувьсах зардал, ажилчдын тооноос хамаарах мэдрэмж (01642, 06224, 02189) байгаа нь эдгээр хүчин зүйлсийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд ашгийн нэмэгдэх хувийг илэрхийлнэ. Дээрх судалгаануудаас үзэхэд санхүүжилтийг нэмэгдүүлэхэд үйлдвэрлэгчдийн үр ашиг өсөх нь дамжиггүй байна.

Өмнө хийсэн эрдэмтдийн судалгаанаас үзэхэд санхүүжилтийг нэг хувиар өөрчлөхөд үйлдвэрлэлийн өсөлт 3.2 хувь өөрчлөгдөнө гэж дүгнэсэн байдагтай харьцуулахад манай ЖДҮ-ийн хөгжилд санхүүжилтийн үзүүлэх нөлөө адил байна. Манай жижиг дунд үйлдвэрүүдийн 4.7 хувь нь арилжааны банк болон төрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан санхүүжилтийг авдаг аж.

Санхүүжилтийн хүртээмжийн онол: Бэрхшээл ба шийдлүүд

Хүн амын зарим нэг бүлэг нь санхүүгийн үйлчилгээг ашиглахгүй байгаа нь санхүүжилтийн хүртээмжийн бэрхшээл үүссэн гэсэн утгыг заавал илэрхийлэхгүй. Бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад өөрийн хөрөнгө дутагдаж байгаа тохиолдолд гаднын санхүүжилтийн эх үүсвэр олдохгүй байгааг санхүүжилтийн хүртээмжийн асуудал үүссэн гэнэ. Санхүүжилтийн хүртээмжийн асуудал яагаад үүсэж байна вэ? Бизнес эрхлэгч санхүүжүүлэгч хоёр тухайн бизнесийн эцсийн үр ашгийн талаар өөр өөр хүлээлттэй байгаад учир оршиж байна. Бизнес эрхлэгчийн хүлээж буй өгөөж өндөр байхад санхүүжүүлэгчийн тооцоолж буй өгөөж бага байх ба тооцоолсон үр ашиг санхүүжилтийг эргэн төлөхөд саад болно гэж үзсэнтэй холбоотой.

ЖДҮ-ийн санхүүжилтийн



хүртээмж хязгаарлагдмал байгаагийн үндсэн шалтгаан

Эх үүсвэр: Өөрийн судалгаа

• Мэдээлэл хомс

Арилжааны банкны зээлийн эдийн засагчдын 80 хувь нь жижиг, дунд үйлдвэрийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн тооцоо, баримт банкны шаардлагыг хангадаггүй, 53 хувь нь бизнесийн туршлагагүй тул тэдэнд зээл олгох боломжгүй, 20 хувь нь тэдний зээлийн түүхийг шалгах боломжгүй гэж хариулжээ. Мөн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зээлийн түүхийг шалгах боломжгүй гэж тэдний 20 хувь хариулсан байна. Банкны зээлийн мэргэжилтэнд олгож буй шагнал урамшуулал нь тэдний зээлийн багцын чанартай шууд холбоотой тул зээлийн хүсэлтэд ямар нэгэн эргэлзээ байгаа бол зээлийн мэргэжилтэн зээлийг батлахгүй.

• Гүйлгээний зардал өндөр

Зээлийн хэмжээнээс үл хамааран банкны ажилтан зээлийн хүсэлт, баримт бичгүүдэд үнэлгээ өгч дүгнэлт гаргахад адил цаг зарцуулна. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид ихэнхдээ бага хэмжээний зээл хүсдэг тул банкны хувьд уг зээлд ногдох зардал өндөр гардаг. Зээлийн хэрэгцээ, шаардлага өндөр байгаа нь банкуудад сорчлон сонгох нөхцөлийг бүрдүүлж эрсдэл болон захиргааны зардал ихтэй ЖДҮ-ийн санхүүжилтаважболомжбагабайна. Банкны зээлийн эдийн засагч нар барьцаа хөрөнгө зээлийн шийдвэр гаргахад их чухал болохыг дурдсан бөгөөд судалгаанд хамрагдсан эдийн засагчдын 73 хувь нь жижиг, дунд үйлдвэрийн барьцаа хөрөнгө банкны шалгуурыг хангадаггүй гэжээ. Эдийн засгийн институтын бүтэц нь мэдээлэл солилцоо, гүйлгээний өртөг, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд нөлөөлдөг. Төрийн байгууллагын хөгжил сул байгаа нөхцөлд, гэрээ хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэх, мэдээллийг олж авах маш хүндрэлтэй байдаг. Үүнээс болж, Монгол Улсад банкууд эрсдэлээ бууруулахын тулд дараах гурван зүйлд түшиглэж байна. Үүнд: 1) хувь

хүмүүсийн хоорондын харилцаа, 2) барьцаа (боломжтой бол байр, орон сууц) хөрөнгө, 3) хамтын, бүлгийн хяналт зэрэг болно. Харилцааны санхүүжилт, барьцаа хөрөнгө, бүлгийн хяналт зэрэг нь санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлдэг ч, зөвхөн тухайн бүлгийн эсвэл, хөрөнгөтэй эсвэл танилтай хүнд боломжийг бий болгож байна.

Санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн оролцоо

Зарим тохиолдолд санхүүгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд төрийн оролцоо хэрэгтэй болдгийг ихэнх эдийн засагч зөвшөөрдөг ч төр яаж оролцох вэ гэдэгт нэг хариулт алга. Энэ асуудалд судлаачид хоёр туйлын эсрэг үзлийг баримталж байгаа нь: шууд оролцох эсвэл огт оролцохгүй байх үзэл баримтлал.

Зах зээл санхүүжилтийн хүртээмжийн асуудлыг өөрөө шийдэж чадахгүй байгаа тул санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж ЖДҮ-д хуваарилахад төрийн идэвхтэй оролцоо чухал гэж шууд оролцооны үзэл баримтлалыг дэмжигчид үзэж байна. Харин “битгий оролц” үзэл баримтлалыг дэмжигчид Засгийн газар санхүүгийн зуучлалд шууд оролцсоноор сайн зүйл хийхээс илүү муу уршгийг бий болгоно иймээс орчныг бүрдүүлж банк, санхүүгийн байгууллагад тулгарч байгаа бэрхшээлийг шийдэхэд туслах хэрэгтэй гэж үзэж байна.

Энэ хоёр үзэл баримтлалын дунд төрийн оролцоог уламжлалт бус байдлаар хэрэгжүүлэх санааг дэмжсэн шинэ гурав дахь үзэл баримтлал (зах зээлийн баримжаатай оролцооны үзэл баримтлал) саяхнаас гарчээ. Гурав дахь үзэл баримтлалын санаа нь “битгий оролц” үзэлтэй ижил боловч санхүүгийн зах зээлд төрийн оролцоо хязгаарлагдмал хүрээнд байж болохыг хүлээн зөвшөөрчээ. Санхүүгийн хөгжлийн хувьд хамгийн чухал нь институцийн хөгжил гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ч богино хугацаанд институци хөгжиж байх үед төр зах зээлийн оролцогчидтой хамтран зарим нэг үүргийг хүлээж болно гэдэг саналыг энэ үзэл баримтлал дэвшүүлж байна. ■

Глобал эдийн засаг

Грек улс
мөхлийн
ирмэгт
ирлээ

Олон улсын “Standard & Poor’s” агентлаг зургадугаар сарын 14-нд Грекийн зээлжих зэрэглэлийг “CCC” түвшинд очтол бууруулснаа мэдэгдсэн нь дэлхийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн дунд шуугиан дэгдээв. Учир нь, ийм муу зэрэглэлтэй орон хаа ч үгүй билээ. Ер нь Грекийн асуудал Европын төдийгүй дэлхийн эдийн засгийн “шүдний өвчин” болоод удаж байгааг бид мэднэ. Тус улсын гадаад өрийн хэмжээ ДНБ-ээсээ давсны зэрэгцээ төсвийн алдагдал нь талийсан бөгөөд санхүүгийн асуудал нь улам лавширч байх зуур улс төрийн тогтворгүй байдал ч түгшээж эхлээд байгаа юм.

Ердөө жил гаруйн өмнө “Standard & Poor’s” Грекийн зээлжих зэрэглэлийг “BBB+” буюу дажгүй өндөр түвшинд үнэлж байсныг сануулах юун. Гэтэл энэ хугацаанд тус улсын эдийн засгийн хувьд Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн алдагдлаа харьцангуй бууруулснаас өөр ямар ч өөрчлөлт гараагүй атал хамгийн муу зэрэглэлээр сюрприз барьсан нь юуных вэ? Зээлийн чансаа тогтоогч агентлагууд хямралыг урьдчилан таамаглаж чадаагүй, улс орнуудын чадварыг хэт дээгүүр үнэлсэн байсан зэргээр шүүмжлэгчдээс жавтий хүртсэнийхээ хариу үйлдлийг ийнхүү гаргаж байгаа ажээ.

Ямартай ч S&P агентлагийн шинжээчид Грекийн авсан зээлээ эргүүлэн төлөх чадварыг Пакистан, Эквадоруос ч доогуур үнэлчихээд байна. Эдүгээ Грек улс хүнд байгааг тус агентлагийн мэргэжилтнүүд хэлсэн хэлээгүй дэлхий тэр аяараа мэдэж байгаа учир “оройтсон борооны хойноос цув нөмөрлөө” хэмээн олон хүн үзэж байгаа билээ. Ер нь тус улс цаашид оршин тогтнох уу, үгүй юу

гэдэг асуулт олны анхаарлыг татаж байгаа юм.

Өнөөдөр Грекийн Засгийн газрын өрийн бичиг дэлхийд хамгийн өндөр үнэтэйд орж байгаа нь хөрөнгө оруулагчид энэхүү санхүүгийн хэрэгслийг илүү эрсдэлтэй хэмээн үзэж байгаагийнх биз ээ. Хэрвээ тус улс дампуурах юм бол энэ нь евро бүсийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх нь гарцаагүй. Дэлхийн нөөцийн валютын нэг еврогийн байр суурь болоод Грекийн араас орох магадлал тун ч өндөртэй Португал, Испани болон Италийн нөхцөл байдалд ч хүнд цохилт үзүүлэхээр байгаа ажгуу.

Тиймээс Грекийн асуудлыг шийдэж өгөхгүй бол горьгүй гэдгийг Европын эрх баригчид эртнээс ухамсарлаж, Европын холбоо Олон улсын валютын сантай хамтран 110 тэрбум еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр баталж, санхүүгийн тусламж үзүүлэх болсон ч грекчүүдийг хямралаас татаад гаргаад ирж чадсангүй. Тус улсын байдал бодож байснаас хамаагүй ээдрээтэй гэдэг нь нэгэнт тодорхой болсон бөгөөд илүү далайцтай арга хэмжээ шаардлагатай байгаа аж.

Европын эрх баригчид Грекийг дампууруулчихыг хүсэхгүй, яаж ийгээд аргалах арга зам эрэлхийлж байгаа ч тэдний хүссэнээр болдоггүй нь түвэгтэй. Мөнгө гаргах эсэхийг Европын холбооны удирдагчид мэддэг юм биш, харин Европын тодорхой орнууд шийддэг бөлгөө. Гэвч тэд грекчүүдэд туслах гэж нэг их яарахгүй байгааг сануулах хэрэгтэй болов уу. “The Financial Times”-ын тооцоолсноор 2014 оны сүүлч гэхэд Грек улсад 172 тэрбум евро хэрэгтэй болох юм билээ. Үүний 57 тэрбумыг Европын холбоо болон ОУВС-гийн нээлттэй зээлийн шугамаар, 30 тэрбумыг төрийн өмчийг хувьчлах

хөтөлбөрийн дагуу олчихлоо гэхэд цаана нь 85 тэрбум евро сох дутаад байгаа юм.

Грекийн Ерөнхий сайд Йоргос Папандреу шинэ Засгийн газар байгуулж, “улайссан” төсвөө хэвийн байдалд оруулах төлөвлөгөөгөө ахин дахин боловсруулж байх зуур төсвөө танах төрийн бодлогыг эсэргүүцсэн жагсаал, цуглаан ахиад л Афиныг амраасангүй. Олон улсын валютын сан, Европын холбооноос зээл авсынхаа хариуд Грекийн эрх баригчид бүсээ чангалах шаардлагатай болсон билээ.

Төсвийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд тус улсын Засгийн газар төрийн албан хаагчдынхаа цалинг хасаж, татварын хэмжээг нэмсний зэрэгцээ тэтгэврийн насыг дээшлүүлсэн. Үүнийхээ ачаар Грекийн эрх баригчид төсвийн алдагдлаа мэдэгдэхүйц багасгаж чадсан ч үйлдвэрчний эвлэлүүд, хувийн хэвшлийнхэндээ дарамтлуулсаар жил тойрч байгаа билээ.

Төрийн албан хаагчид нь ажил хаяж, жагсаал цуглаан зохион байгуулах нь Афины хувьд бараг л хэвийн үзэгдэл болоод буй. Харин сөрөг хүчнийхэн нь Ерөнхий сайдаа албан тушаалаас нь огцруулж, Олон улсын валютын сангийн нөхцөлийг өөрчлөх шаардлага тавьж байгаа нь шинэ Засгийн газрын рейтингийг шалдаа буулгаад байгаа аж. Ийнхүү их өр улс төрийн тогтворгүй байдлыг даллаж эхэлжээ.

ХБНГУ-ын канцлер Ангела Меркель, Францын Ерөнхийлөгч Николя Саркози нарын уулзалтын нэгэн чухал сэдэв Грекийн санхүүгийн хямрал болсныг “Reuters” мэдээлсэн. Афинчуудын хувь заяаг гагцхүү Европын бусад орны ард түмэн шийдэхдээ тулаад байна хэмээн ажиглагчид үзэж байна. ■



Шог зургийг А.Амарсайхан

Ногоон хөгжил

Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих хөтөлбөр цаасан дээр...

Д.Бэхээ

Сүүлийн үед монголчууд ногоон өнгийн талаар ярьдаг, бичдэг, сонгодог болоод байна. Тоо нь улам л нэмэгдээд буй телевизүүд ч ногоон хөгжлийн сэдвээр шоу нэвтрүүлгүүд хийж, ач холбогдол талаас харуулахыг хичээх боллоо. Энэ бол сайн зүйл. Ахиц дэвшил авчрахын дохио. Байгаль дэлхийгээ бодитойгоор хайрлан хамгаалах, ногоон эдийн засгийг хөгжүүлэх тухай асуудал гадаад ертөнцөд бүр газар авсан, жинхэнэ бодитой ажил хэрэг болоод явж байна. Улс орон бүр өөрийн онцлог хөгжилдөө тохирсон ногоон бодлогыг эн тэргүүнд тавиад, хэрэгжүүлэхийг төрийн тэргүүнээсээ эхлэн ард иргэдээ уриалан дуудаж ажиллаж байна.

Ер нь энэ л эгэлхэн цэнхэр гаригаа бид л хайрлаж хамгаалахгүй юм бол хэн хайрлах вэ? Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг

дэлхийн бүх хүн, улс орноороо нэгдэн нийлж тэмцэхгүй юм бол өөр хэн тэмцэх вэ. Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч ногоон улс, муж, дүүрэг, бүр ногоон иргэд болохын төлөө ард иргэдээ уриалан дуудаж буй сайн мэдээ Та үзсэн үү. Энэ улс чинь өөрөө ногоон ой төгөлөөр хүрээлэгдсэн ногоон байгууламж бүхий орон шүү дээ. Дэлхийн дээд хэмжээний уулзалтууд ч ногоон эдийн засгийн тухай л ярьж асуудлыг хэлэлцэж байна. Өөрөөр хэлбэл, ногоон эдийн засгийг хөгжүүлэх, байгаль эхийг хайрлан хамгаалахыг л уриалж байна. Төрийн бодлого шийдвэр ч ийм л хөгжилтэй холбоотой асуудлыг хамгийн түрүүнд авч хэлэлцэж байна. Харин манайд ямар байна гэж Та асуух биз ээ.

Сэтгүүлч хүний хувьд энэ асуултад үнэхээрийн учир дутагдалтай байна аа л гэж

хариулъя. Энэ тухай ярьж, асуудлыг хөндөж байгаа хүн ч ховор байна. Яахав өөрсдийнхөө, салбарынхаа, байгууллагынхаа, мэргэжлийнхээ хүрээнд ярьдаг хүмүүс байгаа л даа. Гэхдээ энэ асуудал өөрөө том учраас том л шатанд ярьж, төрийн шийдвэр, хууль дүрмийг шаардаж байна. Яг өнөөгийн байдлаар иргэдийн, төрийн түшээдийн сэтгэлгээ ногоорохыг хүлээвэл бид дэлхийгээс хэдийнэ хожимдчихсон байх вий. Харин хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих тухайд эртнээс ярьж хэлж, сануулж яваа хүн бол Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэл гэдгийг мэдэх юм. Тэрбээр асуудлын учир начир, ач холбогдол, сөрөг талын талаар хангалттай ярьж, төрийн түшээдэд ойлгуулж, төрийн шийдвэр гаргуулахын төлөө шаргуу зүтгэж

► буйг одоо хүмүүс мэддэг болсон биз ээ. Түүний энэ зүтгэлийн хүчинд Танхим, Засгийн газрын хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Ерөнхий сайд С.Батболд ч ихээхэн дэмжиж байсан билээ. Төр, хувийн хэвшлийн тэргүүнүүд санаа сэтгэл, шийдвэрүүдээ нийлүүлж байгаад энэхүү хөтөлбөрийг баталж, улс орон төдийгүй, ард иргэд, үр хойчдоо хамгийн том буян үйлдэх нь хэмээн баярлаж байсан олон хүн бий. Гэвч мөнөөх үндэсний хөтөлбөр цаасан дээр л дурайсаар жил хагас гаруйн хугацааг авлаа. Энэхүү хөтөлбөрийг Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд буюу 2010 оны эхний хагас жилд боловсруулаад Засгийн газраар батлуулах төлөвлөгөө явж байсан. Холбогдох бүх төрийн болон төрийн бус байгууллагын саналыг авч боловсруулсан гэгддэг энэ хөтөлбөр хэдий хэр хугацаанд тоосонд дарагдаж хэвтэх бол.

Уг тус хөтөлбөрийн гол зорилго нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нэгдэж, байгаль орчноо хамгаалж, ногоон сэтгэлгээ бүхий цэвэр орчинд амар тайван сэтгэл тэнүүн амьдрах, үр хойчдоо үймээн сандаачаагүй сайхан байгаль, эх орноо үлдээх л юм шүү дээ. Үүний тулд төр, засгаас ямар шийдвэр, хууль дүрэм гаргах ёстой, албан газар, үйлдвэр, компаниуд түүнийг нь үйл ажиллагаандаа хэрхэн мөрдөх, тэгээд ард иргэд хэрхэн дэмжиж ажиллах юм гэдгийг л нарийн тусгасан хөтөлбөр юм билээ. Гэхдээ алдаа онооны зүйл бий л байх. Засаад залруулаад, ойлгуулаад таниулаад явж болох л.

Гэтэл төрийн түшмэдүүд энэ хөтөлбөрийн тухай ярих нь бүү хэл сонирхох ч үгүй байна. Уул уурхай, орд газар, эрдэс баялаг, эдийн засгийн өсөлт, их мөнгө, баяжих тухай л амаа чилтэл ярьж байна шүү дээ. Зарим гишүүн мөнөөх урт нэртэй хууль буюу ой мод, гол мөрнийг хамгаалах эцсийн зорилготой хуулийг хүртэл цуцлах тухай яриад явж байна. УИХ-ын гишүүд нь ийм сэтгэлгээтэй байхаар ногоон эдийн засгийн хөгжил манайд хэр явах бол. Гэхдээ өнгө мөнгө, авлига хээл хахууль, хүнд

суртал, албан тушаалд идэгдсэн төрийн эрхмүүдээс илүүтэй ард иргэдийн байгаль эхийг хайрлан хамгаалах сэтгэлгээ бүхнээс чухал юм. 2012 оны УИХ-ын сонгуульд уул уурхай, алт мөнгө ярьсан нь ард иргэдээс “0” үнэлгээ авч, ногоон дэлхий, байгаль орчин, дээрх хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх талд санаачилгатай ажиллаж, ногоон эдийн засгийн талаар ярьсан, хэлсэн, санаа зовсон нэр дэвшигч, нам, хувь хүмүүс ялалт байгуулаасай.

2012 оны сонгуулийн өмнө намуудын хөтөлбөрт суулгаж өгнө

Ингээд энэхүү хөтөлбөрийг засаг төрөөс яагаад авч хэлэлцэхгүй байгаа талаар МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлээс тодруулга авсан юм.

-Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөр цаасан дээр л байсаар байна. Та ямар бодолтой явна вэ?

-Уг хөтөлбөрийг батлах хэрэгжүүлэх талаар хүнд суртал энээ тэрээг олж харахгүй байна. Энэ нь нэлээд хэдэн зүйлтэй холбоотой. Тухайлбал, иргэдийн сэтгэлгээ ногоон болоогүй байна. Бүтцийн асуудал бий. Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг нэртэй тус хөтөлбөрт холбогдох бүх яамнаас санал авч оруулсан. Доторх зорилт нь олон яамны үйл ажиллагааг хамарч байгаа. БОАЖЯ байгаль орчныг хамгаалах талаас ажиллах байх. Ногоон эдийн засгийн номлол, үзэл баримтлал, түүн дээр суурилсан хөтөлбөр гэдэг талаас ажиллах газар нь Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо.

Хөтөлбөрийн төслийг УИХ-ын хэд хэдэн гишүүнд явуулсан. Ер нь ямар ч тохиолдолд Монгол Улс ногоон эдийн засгийн үзэл баримтлалтай байхын тулд хөтөлбөрийг маргааш биш, өнөөдөр батлаад явах ёстой. Тэгэхгүй бол дэлхийн хандлагаас, өөрсдөөсөө хожимдоно. Өнөөдрийн манай төрийн боловсруулж буй бодлого, шийдвэр, хөтөлбөрт байгаль орчноо хамгаална, хайрлана

гэж ярьж байгаа ч асар их нүүрс баялгийг ашиглаж, дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсгөх л ерөнхий концепц яваад байна.

Үнэхээр л улс орон, байгаль эхдээ санаа зовж буй бол ДНБ-ий жилийн тооцоог гаргаад түүн дотроос ногоон өнгөтэй нь хэдэн хувьтай байна гэдэгт анализ хийгээд ногоон бүтээгдэхүүнийг өсгөхөд анхаарч ажиллах шаардлагатай. Засгийн газрын ногоон худалдан авалтыг 2020 он гэхэд 20 хувьд хүргэх зорилт тавих ёстой. Энэ ойлголт байхгүй байна.

Тэгвэл ийм ногоон сэтгэлгээг чухалчилж, яам агентлаг бүрийн төлөвлөгөөнд суулгаж, хяналт тавьж шаарддаг байх ёстой. Тендерийн хуулиндаа ч тусгаад өгөх хэрэгтэй. Танай яамны энэ жилийн төлөвлөгөөний төдөнхувийг ногоон худалдан авалт эзлэх ёстой шүү гэж шаарддаг байх. Гэтэл төрд ногоон бодлогын сэтгэлгээ алга. Яахав энэ зүгээр санаа шүү гээд л өнгөрөхөөс хэрэгжүүлэх жинхэнэ ажил хэрэг болгох орчин бүрдээгүй байна.

Бид чинь дэлхийн шинэ хандлагаас нэлээд хоцорчихсон яваа шүү дээ. Бүр алсад хоцорчихгүйн тулд одооноос хөдлөх хэрэгтэй байна. Ногоон гэхээр гүн гүнзгий, айхавтар зүйл биш л дээ. Улс орны хөгжлөө, ирээдүйгээ арай өөр өнцгөөс харж төлөвлөх л энгийн зүйл юм шүү дээ.

-Цаасан дээрх энэ хөтөлбөр амьдралд хэзээ буух бол?

-2012 оны УИХ-ын сонгуулийн өмнө намуудын хөтөлбөрт энэ хөтөлбөрийн хэрэгжүүлэх талаар суулгаж өгнө. Саяхан Иргэний зориг-Ногоон намтай энэ чиглэлээр хамтран ажиллахаар гарын үсэг зурсан. Одоо удахгүй бусад намтай энэ чиглэлээр ажиллана. Монголын нөхцөлд сонгуулийн амлалтыг ашиглаж ажиллах нь хурдан юм шиг байна.

-Хөтөлбөрийн таван 20-ын зарчим гэж юуг хэлээд байна вэ? Товч тайлбарлана уу?

-Зарим нэг томоохон зорилтыг, асуудлыг хүмүүсийн тархи толгойд ойлгуулахын тулд энгийн бөгөөд өвөрмөц үг хэрэглэх хэрэгтэй байдаг. Европын холбоонд дөрвөн 20-ын зарчим гэж бий. Татварын

» реформыг хэрэгжүүлэхдээ дөрвөн 10-ын зарчим нэрийг ашиглаж байсан. Түүн шиг л таван 20-ын зарчим гэдгийг гаргаж ирсэн. 2020 он гэхэд Засгийн газрын худалдан авалтыг 20 хувьд хүргэх, сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 20 хувьд хүргэх, эрчим хүчний үр ашгийг 20 хувиар дээшлүүлэх,

байгаль руу оруулах хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх гэх мэт зорилт тавьсан. Уг нь ногоон эдийн засаг нь захиргааны болон ухуулан сурталчлах замаар бус сэдэл санаан дээр тулгуурладаг. Өнөөдөр манайд усны, ой модны төлбөр гэж тус тусад нь авч үзээд байгаа. Тэгвэл Европт экосистемийн үйлчилгээний

төлбөр гээд л иж бүрнээр нь авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл экосистем бидэнд үйлчилгээ үзүүлж байна гэдэг утгаар хандсан байх жишээтэй. Европыг холбооны экосистемд хандсан зөвлөмжийг хүртэл орчуулах гэх мэтчилэн шинэ өнцгөөс хандахыг хичээсэн хөтөлбөр байгаа юмаа. ■

Хөтөлбөрийн агуулгаас товчлон хүргэж байна.

“ХҮРЭН” ЭДИЙН ЗАСГААС “НОГООН” ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго:

Хөтөлбөр нь Монгол орны хөгжлийн бодлогыг “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого /2008-2021”, дэлхийн нийтээр баримталж буй “тогтвортой/ногоон” хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн томъёолох, хууль эрхзүйн орчныг шинэчлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн цогц арга хэмжээ авахад чиглэж байна.

Хөтөлбөрийн үндсэн зорилт:

“Таван 20”- 20/20/20/20/20/ буюу 2020 он дуустал хугацаанд

1. Эрчим хүчний үр ашгийг 20% -иар нэмэгдүүлэх,
2. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг суурилагдсан чадлын 20%-д хүргэх,
3. Хүлэмжийн хийн ялгарлыг 20%-иар бууруулах,
4. Байгальд оруулах хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх,
5. Ногоон худалдан авалт"-ыг Засгийн газар,

орон нутгийн төсвийн нийт худалдан авалтын 20%-д хүргэхэд оршино.

Хөтөлбөрийн ач холбогдол:

- Хөгжлийн бодлогыг дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлнэ,
 - Ногоон ДНБ, бодит хадгаламж зэрэг ногоон эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, бодлогыг тодорхойлдог болно,
 - Байгалийн нөөц баялгийн хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлнэ,
 - Байгаль орчны доройтол, бохирдлыг бууруулна,
 - Хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийн үндсийг тавина,
- Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа,**
3.1. Хөтөлбөрийг 2011-2020 оны хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:
а/эхний буюу үндсэн үе шат: 2011-2015 он;
б/хоёрдугаар буюу зорилтот үе шат: 2016-2020 он.

Мэдээ

Эко төслүүдийг уралдууллаа

“Зуунымэдээ” сонин, Монголын энтерпренерүүдийн холбооноос санаачлан Монгол Улсад анх удаа зохиосон байгальд ээлтэй бизнесийн шилдэг төсөл шалгаруулах олон улсын уралдаан өнгөрсөн зургадугаар сарын 6-10-нд болж өндөрлөлөө. Өнгөрсөн мягмар гаригт төрийн ордонд нээлтээ хийсэн “Ногоон бизнес-тогтвортой хөгжил 2011” уралдааныг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд нээж үг хэлсэн юм.

Дэлхийн 17 орноос хүрэлцэн ирсэн 16-35 насны залуус байгальд ээлтэй бизнесийн төслүүдээ сойсон бөгөөд 33 багаас найм нь шилдгээр шалгарч, 1000-3000 ам.долларын шагналаа гардан авчээ. Нарны эрчим хүчийг ашиглаж гэртээ зөөврийн зай цэнэглээд, хэрэгцээт газраа ашиглаж болох өвөрмөц шийдэл,

хогийг ангилж ялгах ажлыг хөнгөвчлөх арга зам гээд олон сайхан “ногоон” санаа энэхүү тэмцээний үеэр урган гарсан байна.

Төслөө уралдуулж, үзэсгэлэнгээ гаргасан олон орны эко залуус Монголын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж амжжээ. Манай оронд анх удаа зохион байгуулагдсан энэхүү эко төслийн уралдааныг санаачилсан Монголын энтерпренерүүдийн холбооны тэргүүн Б.Гармаасүрэн, “Зууны мэдээ” сонины Эдийн засгийн албаны дарга Ж.Цогзолмаа нарт зохион байгуулагчид хийгээд оролцогчид талархсанаа илэрхийлсэн юм. Залууст байгаль орчинд ээлтэй бизнес санаачилж, санхүүжилт олох урам зориг өгөх үг тэмцээн цаашдаа уламжлал болон зохиогдох биз ээ. ■



Байгальд ээлтэй хөгжил

Зээпарк (Seer park) дахь хиймэл нуур

Дэлхийд алдартай ногоон хот

Х.Хулан

“Ногоон” нэрээрээ дэлхийд алдаршсан энэ л хотод би таван жилийн туршид сурч, ажиллаж амьдарсан билээ. Гүн ногоон өнгөөр хучигдсан цэвэр агаарын жинхэнэ эх уурхай болсон Герман улсын Брайсгау дахь Фрайбург хот бусдаас нэг л онцгой. 850 жилийн түүхтэй, улсынхаа хамгийн дулаан, нарлагт тооцогддог, мөн оюутны хот хэмээн нэрлэдэг Фрайбургт оюутан насаа өнгөрүүлжээ. Гайхалтай, сонирхолтой, дурсамжаар дүүрэн он жилүүд минь энэ л хоттой салшгүй холбоотой билээ. Ногоон тодотголтой хотын хөгжил цэцэглэлт, ард иргэдийн амьдрал ахуй, сэтгэлгээ, боловсрол мэдлэгийг нь хараад өөрийн эрхгүй бахархах сэтгэл төрдөг сөн. Ялангуяа сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын төрийн удирдлагуудын ярих болсон ногоон хөгжлөөр тэргүүлэгч Фрайбург

хотын хөгжилд манай Улаанбаатар маань хэзээ хүрэх бол гэсэн бодол байсхийгээд төрдөг байснаа нуух юун. Харин өнөөдөр сэтгэлд дотно тэр л хотынхоо тухай сэтгүүлийнхээ уншигчидтай хуваалцах гэж байгаадаа баяртай байна. Гэхдээ тэр өндөр гоё байшин, барилга, гудамж талбай гэхээсээ илүүтэй яагаад ногоон нэрээр алдартай болсон түүхээс эн тэргүүнд сонирхуулж байна.

Фрайбург “ногоон” болсон нь

Одоогоос гучаад жилийн өмнө буюу 1975-1977 оны хооронд тус хотын болон тойрон орших бүс нутгийн иргэд Германы түүхэнд анх удаа Вийль (Wyhl) дүүрэгт цөмийн цахилгаан станц барихыг хүчтэй эсэргүүцэл өрнүүлсний үр дүнд амжилт олж чаджээ. Орон нутгийн эрчим хүчний бодлогыг шинэчлэх шаардлага тэр үеэс цоо шинээр төрсөн гэж хэлж

болох юм. Чернобылийн атомын цахилгаан станцад томоохон осол гарсны дараахан 1986 оны зун хотын зөвлөлөөс “Дотоодын эрчим хүчний хангамжийн концепц”-ийг боловсруулсан байна. Энэхүү концепцид тусгасан гурван гол зорилгыг германчууд өнөөг хүртэл чандлан биелүүлсээр иржээ.

Нэгдүгээрт, Эрчим хүч хэмнэх. Хоёрдугаарт, Сэргээгдэх эрчим хүч, юуны өмнө нарны энергийг ашиглах. Гуравдугаарт, Дулаан цахилгааныг хослуулсан эрчим хүчийг үр ашигтайгаар гаргаж авах явдал юм. Фрайбург хотын засаг, захиргаа нь байгаль орчноо хамгаалах асуудлыг “дээрээс” зарлиг болгосон тушаалын дагуу бус, харин “доороос” буюу ард иргэдийнхээ дуу хоолой, санал хүсэлтийг хүлээж авсны үндсэн дээр бодлогоо боловсруулж хэрэгжүүлдгийг дээрх жишээ тодоор харуулсан юм.

» Швейцарь, Франц улсын хилийн дээстэй залгаа шахам орших үзэсгэлэнт Фрайбург нь чухам юугаараа олны анхаарлыг ингэтэл их татаж, гадаадын төдийгүй дотоодын жуулчдын цувааг жилийн дөрвөн улирлийн турш дагуулдаг болсон бэ? Зөөлөн дулаан уур амьсгалтай, нов ногоон орчинтой энэхүү хотын гуравны нэг орчим буюу 6.424 гектар газар нутаг нь ой мод, 700-гаад гектар нь усан үзмийн талбайгаас бүрдсэн аж. Мөн 500 гектар газрыг ногоон байгууламж, цэнгэлдэх хүрээлэнд зориулж гаргасан нь агаарыг “ногоон уушги” мэт шүүн цэвэрлэж, иргэд ч гэрийнхээ хаалгаа нээхэд л сэтгэл сэргээсэн “ногоон” байгаль угтдаг байна.

Нарлаг Фрайбург ба сэргээгдэх эрчим хүч

Европын ихэнх оронд хур элбэгтэйг бид мэднэ. Герман улсад ч мөн адил. Фрайбург хотод харин жилд 1.800 гаруй цаг нартай байдаг гэсэн тооцооллын дагуу улсынхаа хамгийн нарлаг хотоор шалгарсан билээ. Түүнчлэн анагаах ухаан, биотехнологи, ногоон эдийн засаг болон бусад шинжлэх ухааны салбарын судалгаа шинжилгээ, туршилтыг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн байна. Нийт ажил эрхлэгчдийн гурван хувь буюу 10.000 хүн байгаль орчны чиглэлийн 1.500 байгууллагад ажилладаг байна.

Фрайбургийн ийнхүү дэлхийд алдартай ногоон хот болоход нөлөөлсөн нэг чухал зүйл бол сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжил маргаангүй мөн. Сэргээгдэх эрчим хүчний судалгааны ажлыг нэр хүнд бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд гүйцэтгэж байна. Жишээлбэл,



“Solarfabrik Freiburg” аж ахуйн нэгж

Фраунхоф Институтын Нарны энергийн тогтолцооны төв, Сэргээгдэх эрчим хүчний төв, “Solarfabrik Freiburg” аж ахуйн нэгж гэх мэт олон байгууллагыг дурдаж болно.

Эдгээр нь нарны эрчим хүчийг судлахын зэрэгцээгээр хамгийн сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг ч дотоодын болон олон улсын зах зээлд нийлүүлдэг байна. Дээр дурдсан байгаль орчны чиглэлийн нийт ажиллагсдын 1.000 гаруй нь 80-аад нарны эрчим хүчний үйлдвэрт ажилладаг байна. Нар, салхины эрчим хүчний эрэлт хэрэгцээ энэхүү ногоон хотод дээд зэргийн дэвшилттэй хөгжиж буй сургууль, сүм хийд, айл өрхийн орон сууц, хотын захиргааны байр, тэр ч байтугай хөл бөмбөгийн талбайн асрын дээвэр дээр хүртэл суурилуулсан нарны эрчим хүч хуримтлуулагч, Шварцвальд ойд байрлуулсан том салхин хөдөлгүүрийг харсан хэн бүхэнд ойлгомжтой аж.

Дэлхийд анхдагч “Нарны байшин”-г анх 1988 онд Фрайбург хотноо барьсан бөгөөд ямар ч цахилгаан, хийн яндангүй тус байшингийн гадаргууг бүрсэн материалаар нь дамжуулж эрчим хүч, дулаанаар хангагдах тогтолцоотой хийжээ. Удаах өвөрмөц төслийг уран барилгач Рольф Дийш “Heliotrop” нэртэй, нарны байрлалын дагуу эргэлддэг байгаль орчинд ээлтэй технологийн дагуудугуй хэлбэртэй байшинг 1994 онд туршилтын журмаар бариулсан



Дугуй байшин “Heliotrop”



байна. Мөн 5.000 оршин суугчтай, хотын загвар дүүрэг болох Вобон (Vauban) сэргээгдэх эрчим хүчийг үр өгөөжтэй ашиглахын сацуу 1.000 хүн тутамд 85 суудлын машин хэрэглэж байгаа билээ. Драйзам гол дээрх жижиг усан цахилгаан станц нь 160-аад өрхийн эрчим хүчний хэрэгцээг хангах жишээтэй. Анх 1954 онд үүсгэн байгуулагдсан Олон улсын нарны эрчим хүчний нийгэмлэг хүртэл ТУЗ-ийн гишүүдийнхээ саналын дагуу 1995 онд Австралийн Мельборн хот дахь төвөө нарлаг Фрайбург уруу нүүлгэн шилжүүлсэн нь хотын олон улсын тавцанд эзлэх байр суурийг зүй ёсоор илтгэж байна.

Хог хаягдлыг дахин боловсруулах нь

Фрайбург хотын иргэд хогоо цаас, шил, биологийн гаралтай хаягдал, баглаа боодол болон үлдэгдэл хог хаягдал гэж таван хэсэг болгож хаядаг. Өөрөөр хэлбэл, бүх төрлийн хогоо нэг газар овоолчихдог манай улс шиг биш, харин эдгээр хог тус бүрт зориулж тусгай уут сав гаргадаг. Шар шуудай гэж нэрлэгддэг, хотын захиргаанаас үнэгүй тараадаг зузаан шар уутанд лаазалсан бүтээгдэхүүний лааз, бүх төрлийн гялгар уутны хог хаягдлыг хийж тогтсон хуваарьтай өдрөө байрныхаа гадаа гаргаж тавьдаг. Шилийг шил гэсэн бичигтэй төмөр чингэлэгт, цаасыг мөн адил цаасны хаягдлын чингэлэгт тус бүр хийнэ. Шилний чингэлэг дотроо 3-4



тасалгаатай бөгөөд шилээ цагаан, бор, ногоон өнгөөр нь хүртэл ялгаж хийх зориулалттай гээч. Биологийн гаралтай үлдэгдлийг Kompost гэдэг. Үүнд жимс ногоо, навч, мөчир, цай кофений үлдэгдлийг нэг дор цуглуулж сайн чанарын хөрсний бордоо болгодог байна. Харин үлдэгдэл (Restmuell) нэртэй хогийг дахин боловсруулахгүйгээр шатааж, эрчим хүчийг нь нийтийн хэрэгцээнд ашигладаг. Хог шатаах байгууламж нь нэг жилд 15МВт-ын цахилгаан үйлдвэрлэх чадалтай бөгөөд, энэ нь 25.000 айл өрхийн хэрэгцээг хангах хэмжээний эрчим хүч юм. Хог хаягдлаас сэргийлэх ухуулан таниулах арга хэмжээний ач тусаар Фрайбург хотын иргэд сүүлийн 15 жилийн дотор нэг хүн тутмын жилд хаядаг 190 кг хогийн хэмжээг 109 кг болгож бууруулж чадсан байна. Мөн хогны дахин боловсруулах хувь хэмжээ 25-60 хувь болж өссөн нь ногоон хотын иргэдийн байгаль орчноо хайрлах сэтгэл санаачилгатай шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл, тус хотын төр, засаг захиргааны зүгээс гарч буй ихэнх бодлого шийдвэрт ногоон хөгжлийн үзэл баримтлал байнга буухын зэрэгцээ хотын бүх оршин суугч ногоон сэтгэлгээтэй, алхам бүртээ ногоон хөгжлийг шүтэж, үр хүүхдүүддээ ч тайлбарлан сургаж хүмүүжүүлдэг нь эцсийн эцэст өөрсдөө цэвэр цэнгэг сайхан агаарт, цээж дүүрэн амьсгалж, ногоон орчинд сэтгэл тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг нь энэ хотын бусдаас ялгарах онцлог юм.

Бүр аль болох л гялгар уут хэрэглэхгүй дэлгүүр хоршоонд байнга даавуун уутаа цүнхлэн авч явдаг, хаяж байгаа хогоо дахин боловсруулах төрлөөр нь нямбай гэгч ангилж байгаа Фрайбург хотын иргэдийг харсан шинэхэн оюутан би өөрийн эрхгүй алмайрч байсан удаатай. Анхандаа хог хаягдлаа ингэж ангилахын ач тусыг сайн ойлгоогүй байсан миний бие нэг л мэдэхэд уусан цайныхаа дүрдэг ааг, хуруу зай, хуванцар, цаас болон картон, тэр ч байтугай шуудангийн зөөлөвчтэй дугтуйг хүртэл цаас болон гялгар уут гэж хоёр хэсэг салгаж хаядаг болсон байсан. Харин манай иргэд хэзээ ийм сэтгэлгээнд суралцах бол? Байгаль орчны хамгаалалт гэж ам хуурайгүй яригдах болсон өнөө үед өдөр тутам тохиох энгийн зүйлээс л бид байгаль орчноо хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж эхэлбэл иргэн бидний жинтэй хувь нэмэр мөн бус уу. Тэгвэл бидний нэг нүдээр хардаггүй амьдралын эрхээр хог түүж, цуглуулсан шил хуван саваа “Түүхий эд авах” чингэлэгт тушааж хэдэн бор төгрөг олж, хорвоогийн хоногийг аргацаадаг хог түүгчид маань харин ч байгаль дэлхийдээ томоохон хувь нэмэр оруулж явааг хэлмээр байна. Бид хаягдал шил, бүх төрлийн гялгар уут гэх мэтийн түүхий эдээ өөрсдөө аваачиж тушаадаггүй юм гэхэд хогоо ил задгай хаядаггүй болж ногоон сэтгэлгээнд суралцах юмсан даа.

Хотын нийтийн тээврийн хэрэгсэл

Фрайбург хот болон хавь ойрын дүүргийн зорчигчид Региокартэ (Regiokarte) нэртэй бүс дотроо хөнгөлөлттэй үнээр зорчих билетийг сараар нь худалдаж авдаг. Билет эзэмшигч нь заагдсан бүс дотроо галт тэрэг, автобус, трамвай гээд дуртай унаагаа сонгож үйлчлүүлнэ. Сурагч, оюутан, ажил эрхлэгч гэсэн ангиллаас шалтгаалж билетний үнэ ялгавартай байна. Мөн эдгээр тээврийн хэрэгсэл дотор кондуктор гэж байдаггүй боловч, энгийн иргэний хувцастай хянан шалгагчид үе үе орж ирэн ганц нэг “туулайчилж” байгаа зорчигчдыг илрүүлэн торгодог. Тав гаруй жил Фрайбургт амьдарсан миний нүдэн дээр 3, 4-хөн удаа л торгуулийн хуудас авсан иргэдтэй таарч байв.

Ногоон хотын иргэд нь дугуйгаар их аялдаг бөгөөд, галт тэрэгний нэг хэсэгт тэдэнд зориулсан урт талбай хүртэл гаргаж өгсөн байдаг. Хамгаалалтын малгай өмссөн хүүхдийн дугуйтай өхөөрдөм хөөрхөн багачууд ээж аавыгаа даган ногоон хотын иргэнийхээ үүргийг дугуй унаж биелүүлж эхэлдэг гэж хэлж болно. Түгжрэл гэдэг аюултай гамшигт нэрвэгдсэн нийслэлчүүд дугуйн замтай болчихвол хэчнээн сайхан бэ? Эрүүл мэндэд ч байгаль орчинд ч эергээр нөлөөлөх дугуйн спортыг өргөнөөр хөгжүүлж болохгүй гэж үү. Гурван сая хүрэхгүй хүн амтай, Герман улсаас дөрөв дахин том газар нутагтай Монгол оронд дугуйн зам барих талбай олдох нь л лавтай.

Ногоон хотын хэтийн төлөв

Уур амьсгалын өөрчлөлт асар хурдацтай явагдаж буй орчин цагт, Фрайбург хотын зүгээс 2030 он хүртэлх хугацаанд нүүрстөрөгчийн давхар ислийг 40 хувиар бууруулах томоохон зорилтыг өмнөө тавьсан байна. Фрайбург хотын байгаль орчинд оруулж буй хувь нэмрийг ХБНГУ-ын төр засгаас өндрөөр үнэлж, “Байгаль орчны нийслэл”-ээр 1992 онд, “Уур амьсгалд ээлтэй улсын нийслэл”-ээр 2010 онд тус тус шалгаруулсан байна. Түүнээс гадна утаа-болон озоны байдлийг урьдчилж сануулга өгдөг тогтолцоо, газар тариаланд пестицид ашиглахыг хорьсон хориг, тогтвортой хөгжлөөрөө дэлхийд танигдсан хот юм.

Сонирхуулж хэлэхэд, ногоон хотын захирагчаар Ногоон намаас нэр дэвшсэн Дийтер Саломон 2002 оноос хойш ажиллаж байна. Найман жил тутам хотын захирагчаа сонгодог Фрайбург хотын иргэд 2010 оны дөрөвдүгээр сард болсон сонгуулиар Дийтер Саломоныг дахин хотын захирагчаар сонгожээ. Ер нь ногоон хот гэдэг нэр бол зөвхөн маркетинг сурталчилгааны төдий бус, харин эрчим хүч, байгаль хамгаалал, зам тээврийн төлөвлөлт, хотын хөгжил, цэвэр бохир усны асуудлыг цогцоор нь шийдэх концепц болон стратегийг агуулсан төр, иргэдийн оролцоотойгоор хэрэгждэг ойлголт мөн. ■

Улаанбаатарыг “Ногоон баатар” болгоё

Тоолж барамгүй олон төрлийн, янз бүрийн мод, бут Сингапурт очиход минь “хүлээж авч” билээ. Алга дарам газар нутагтай энэхүү хот-улсын багтаж, шингэж ядаж байгаа байшин, барилгуудын дундуур цэцэрлэгт хүрээлэн, цэцгийн мандал цэвэрхэн сүлжээд байрласан нь цэгцтэй, бас тансаг харагдуулна. Тэнгэр баганадсан өндөр барилгуудынх нь дээвэр дээр хүртэл дал модод байхыг хараад гайхаш тасарч байв. Тэнд долоо хоноход л дөрвөн өдөр дараалан бороо орж билээ. Ингэж их бороо орж байгаа юм чинь зүлэг, мод ч сайхан ургахаас яах билээ гэж бодсон юм сан. Гэтэл үгүй шүү! Байгаль эх Сингапурт Шинэ Зеланд юм уу Ирланд шиг битүү ногоон хүрэм хайрлаагүй байжээ. Тиймээс хот-улсын Засгийн газар Австрали, Шинэ Зеландаас мэргэжилтэн урьж авчирч, ногоожуулалтыг хэрхэн хийх талаар зөвлөгөө авч байсан юм билээ. Энэ орон эквадор орчмын халуун ойн бүсэд оршдог болохоор бүтэн жилийн турш ширүүн бороо хур орж, хурц нар шардаг газар. Хүчтэй бороонд хөрс шороо нь угаагдаж, үржил шимт давхрагагүй болдог учраас мод, зүлэг ургахад харин ч бэрх байжээ. Тэгвэл Сингапур улс яаж “ногоорсон” юм бол оо?

“Гаднынхан манайд ирэхдээ мод, цэцэгсээр дүүрэн тансаг, цэвэрхэн гудамж, гольфийн талбай зэргийг харах хэрэгтэй байлаа. Энэ нь хотын оршин суугчдын ёс зүйд ч сайнаар нөлөөлж, аялал жуулчлалын хөгжлөөс эхлээд хөрөнгө оруулагчдыг татахад хүртэл хэрэгтэй байсан юм” гэж Сингапурын Ерөнхий сайд асан Ли Гуан Ю “Буурай орноос бусдын манлайд хүрсэн замнал” номдоо тэмдэглэсэн байдгийг “Mongolian Economy” сэтгүүл өмнөх дугаартаа бичсэн билээ.



Нийслэлд тарьсан мод нүүрсхүчлийн хийг шингээж, хүчилтөрөгч үйлдвэрлэдэг. Эдүгээ Улаанбаатарт 1.2 сая хүн амьдарч байна. Тэгвэл нэг хүний бүтэн өдрийн амьсгалах хүчилтөрөгчийг дөрвөн мод ялгаруулдаг тухай Ойн газрын Ойжуулалт ногоон хэрэм хэлтсийн дарга С.Дашдаваа учирлажээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өнгөрсөн тавдугаар сард “Ногоон хот аян-2011” бүх нийтийн өдөрлөгийг зохион байгуулсан. Түүнчлэн Ерөнхийлөгчийн 2010 оны дөрөвдүгээр сард зарлиг болгосны дагуу жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгосон шүү дээ. Үүнтэй холбоотойгоор модыг ч мянга мянгаар нь тарих боллоо. Гэхдээ энэ ажлыг нүх ухаад, модоо суулгаад, шороо устай нь холиод орхих хэмжээнд хийж болно гэж үү?

Мод тарих санаачилга дээр дөрөөлөн сайн, муу бизнес ч газар авлаа. Тэр ч бүү хэл уулнаас авчирсан том модыг зам дээр зардаг болжээ. Дөнгөж тарьсан нялх зүлгэн дээгүүр зоргоороо туучиж, ургаж ядаж байгаа модыг гэмтээх, хулгайлах тохиолдол ч

мэр сэр гарч байна. Энэ бүхнийг яаж зохицуулах вэ? Бид “будaa идэж” болох бэлээхэн туршлага Сингапурт бий.

Азийн ихэнх орон хот орчноо зүлэгжүүлэх, ногооруулахад анхаардаггүй байсан үед Ли Гуан Ю Сингапурыг моджуулах аянд мордсон байдаг. “Сингапурын тусгаар тогтнолыг зарласны дараа би гуравдагч ертөнцийн бусад орноос ялгарах арга зам хайх болсон. Тэгж тэгж дэг журам, ойр орчноо ногооруулах дээр тогтож билээ” хэмээн тэрбээр дурссан нь бий. Дэлхийн тэргүүний улсын хэмжээнд хүрэхийн тулд эхлээд Сингапурыг мөнх ногоон хот-цэцэрлэг болгохыг Ли Гуан Ю хичээсэн юм. Ингээд мод, бутыг сая саяар нь тарьсан нь хүмүүсийн ёс суртахуунд нөлөөлж, сингапурчууд оршин суугаа хотоороо бахархах болсон аж. 1971 оны арваннэгдүгээр сарын эхний бүтэн сайн өдөр анх мод тарих өдрийг зохион байгуулсан нь Сингапурын хувьд уламжлал болон тогтжээ.

Гэхдээ үүнийг хийхэд амар байсангүй. Хүмүүс сурснаараа зүлгэн дээгүүр туучиж, өвс ногоо талхалж, цэцгийн мандал сүйтгэж, тарьсан бут хулгайлах явдал ч гарч ▶

► байжээ. Энэ үед хот-улсын Засгийн газар тарьсан ургамлыг харж хандах байгууллага хэрэгтэйг ойлгож, энэ ажлыг Үндэсний хөгжлийн яамандаа даатгасан байдаг. Үүний хажуугаар зүлэг ногоог дээдлэхийн учрыг тайлбарлаж, тарьснаа хэрхэн арчлахыг сургуулийн хүхдүүдэд зааж эхэлжээ. Хүүхдүүд эцэг эхдээ ярихад илүү үр дүн гарна гэж Сингапурын эрх баригчид тооцсон хэрэг л дээ.

1819 онд 120 загасчин амьдарч байсан жижигхэн тосгон өнөөдөр нэг хүнд ногдох орлогоор дээдлэхийд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж,

жуулчдыг сая саяар нь татаж буйн нэг нууц мод, зүлэг ажээ. Энэхүү хот-улс хүмүүсийн нүдэн дээр хэрхэн “ногоорч” байгааг харсан Азийн бусад орон үлгэр дуурайл авсан байдаг. Монголчууд ч өнөөдөр энэ тал дээр анхаарч эхэлж байгаа нь сайшаалтай. Гэвч энэ нь нэг өдөр олуулаа гарч ирээд, шороо ухаад, дуртай модоо суулгачих ажил биш. Ул суурьтай, судалгаа шинжилгээтэй хандах хэрэгтэй юм байна. Сингапурын хувьд Ази, Африк, Карибын тэнгисийн ижил төстэй уур амьсгалтай орнууд руу судлаачдын баг явуулж байжээ.

Гаднаас авчирсан 8000 төрлийн ургамлаас 2000 нь л Сингапурт нутагшиж ургасан бөгөөд тэр бүхнийг цаашид олшруулан тарьж, хот-улсынхаа ургамлын тоог нэмсэн байдаг. Үүний хажуугаар монголчууд бид ёс суртахуунаа дээшлүүлж, тарьсан модоо арчлах ухамсартай болох хэрэгтэйг Сингапурын жишээ харуулах буюу. Улаанбаатарыг “Ногоон баатар” болгож чадвал хотын оршин суугчид эрүүл, цэвэрхэн гудамжаар алхалж, тоос шороог мартаж, Монголыг зорьж ирэх жуулчдын тоо ч өсөх биз ээ. ■

Дэлхийн салхины өдөр

50 МВт-ын Салхин паркийн барилгын нээлт энэ өдөр тохиолоо

Дэлхийн салхины өдөрийг сэргээгдэх эрчим хүч, тэр дундаа салхины эрчим хүчний тухай иргэдийн сэтгэлгээг өөрчилж, мэдлэг олгох, салхины эрчим хүчийг ашиглан агаарын бохирдлыг багасгах, цаг уурын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад олон нийтийн анхаарлыг хандуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор 2009 оноос хойш дэлхий даяар тэмдэглэн ирлээ. Дэлхийн салхины эрчим хүчний зөвлөл болон Европын салхины эрчим хүчний ассоциаци хамтран санаачилсан Дэлхийн салхины өдөр буюу жил бүрийн зургадугаар сарын 15-нд улс орон бүр өөрийн онцлогоор тодорхой хэмжээнд тэмдэглэж, төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг байна.

Монгол Улсын хувьд Төв аймгийн Салхит ууланд барих 50 МВт-ын Салхин паркийн барилгын нээлтийн үйл ажиллагаа энэ өдөр тохиолоо. Энэхүү “Салхин парк”-ийг барихын тулд Налайх дүүргээс “Салхин парк” хүртэл 110 кв-ийн өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах шугам, “салхин парк” хүртэл сайжруулсан шороон зам тавих, төмөр замын түр гарам, салаа зам барих зэрэг ажлыг



хийхээр төлөвлөж байна. “Ньюком”-ын охин компани “Клин Энержи” ХХК нь тус “Салхин парк”-ийг 2012 онд бүрэн хэмжээгээр барьж ашиглалтад оруулснаар жилдээ 160 сая кВт гаруй цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд нийлүүлэхээр төлөвлөж буй аж.

Салхитын “салхин парк” нь цэвэр эрчим хүч үйлдвэрлэснээр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг жилд 3-5 хувиар, цахилгаан станцуудын жилд хэрэглэдэг нүүрсний хэрэглээг 160-190 мянган тонноор бууруулж, цахилгаан үйлдвэрлэхэд зарцуулж буй усны хэрэглээг 1,40-1,90 сая

тонноор хэмнэж, нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂)-ийг 180-200 мянган тонноор багасгах юм байна.

Угаргахэмжээнд УИХ-ын гишүүн Д.Энхбат, Ц.Цэнгэл, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Эрчим хүчний газрын орлогч дарга П.Ганхүү болон “Ньюком” группийн гүйцэтгэх захирал Б.Болд тэргүүтэй төлөөлөгчид оролцсон.

Манай улсын салхины эрчим хүчний нийт нөөц 550,000 МВт бөгөөд салхины эрчим хүчээр дотоодын хэрэгцээг хангаад зогсохгүй цахилгаан экспортлох боломжтой гэнэ. ■

Ногоон сэтгэхүй

Үнсэн дээр ургуулсан бургас



Нэг мод таривал нэг насны буян
Хоёр мод таривал хойд насны буян

Гурван мод таривал гурван үеийн буян болно гэсэн өвөг дээдсийн сургаалийг дээдэлсэн Дулааны гуравдугаар цахилгаан станцын ажилтан бүр гурван мод таван жилийн өмнө тарьсан билээ. Гэхдээ станцын үнсээ хаядаг талбайд экологийн нөхөн сэргээлт хийж, улмаар 3000 мод ургамлыг тарьж ургуулсан нь өнөөдөр 12 га газрыг хамарсан ногоон төгөл байгууламж болжээ. “Суулгацуудын ургалт одоо бие даан ургах чадвартай болсон” гэж тус станцын экологийн инженер С.Болдсайхан ярьсан. Эдгээр модыг бие даах чадвартай болтол станцын 1000 орчим ажилтан үнэхээрийн сэтгэлээ зориулж, арчилж тордож байсан юм. 4-5 жилийн туршид хувингаар ус зөөж усалж хайралж хамгаалж ирсний дүнд модод байгалийнхаа жамаар ургахтайгаа болжээ.

Гэхдээ хуучин хаягдал труба хоолойг ашиглан ургамжуулсан талбайд усалгааны систем хийж Туул голд хаядаг байсан илүүдэл усаа усалгааны системд ашиглаж байгаад станцын хамт олонд талархаж байна. Энэхүү ногоон шийдвэр нь станцаас гарах хаягдал

усыг Туул гол руу урсгахаа бүрэн зогсоож, тарьсан бургас модыг арчлан услахад ашиглаж байна.

Станцуудын хувьд үнсээ хаана хаяхав, яаж экологийн нөхөн сэргээлт хийхэв гэсэн том асуудлууд тулгардаг. Энэ тухайд С.Болдсайхан “Дүүрсэн үнсэн санг дээр нь 25-30 см зузаантайгаар уулын хайрга, шороогоор дарж хөрсжүүлэх замаар техникийн нөхөн сэргээлт хийдэг. Тэгээд тухайн хөрсийг орчиндоо зохицон бүрэлдсэний дараа өвс, ургамалын үр цацан зүлэгжүүлж, олон наст бутлаг ургамал суулган ургуулснаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд олон жил ашигласан хөрсний байгалийн онгон төрх сэргэх боломжтой болдог. Бургас модны үндэс нь газрын хөрсөнд гүн орохгүй хөрсийг хавж ургадаг тул хуучин үнсэн сангуудад байгалийн нөхөн сэргээлт хийхэд ихээхэн тохиромжтой ургамал болох нь туршилтаар батлагдаж

байна. Мөн хөрсжүүлсэн талбайг зүлэгжүүлэн спортын төрлүүдэд зориулсан тухайлбал, хөл бөмбөг, гольф, бейсбол, мотоспорт гэх мэт талбайг байгуулж болох юм” гэж ярьсан юм.

Тус цахилгаан станц нь 1968 онд ашиглалтад орсноос хойших хугацаанд нийтдээ 43.3 га талбайг хамрах дөрвөн үнсэн санг дүүргэж, техникийн нөхөн сэргээлт хийх замаар дээд талбайг нь хөрсжүүлсэн байна. Тэгэхээр станцуудын үнсэн сангийн талбайд ийнхүү ногоон байгууламж байгуулахаас гадна спортын талбай болгон ашиглаж болох нь. Туул голын ойролцоо зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүйгээр барьж байгуулж байгаа гольфийн талбайн эзэд болон цаашид спортын талбай хайж буй хүмүүс энэ мэдээллийг анхааралдаа аваасай. Харин ийм талбайд барилга байгууламж барих нь бүрэн хориотой гэсэн шүү. ■



Хариуцлагатай уул уурхай

Уул уурхайн нөхөн сэргээлтийн стандартыг сайжруулъя

Х.Хулан



1908 онд анх үйл ажиллагаа явуулж эхэлсэн Невада мужийн ээс олборлож байсан ордын талбайд 1989 онд нөхөн сэргээлт хийж, бэлчээрийн газар болгосон жишээ

Монгол орон юугаараа баялаг вэ? Энэ асуултад мэдээж хүн бүр өөр өөр хариулт хэлэх байх. Гэхдээ ихэнх нь газар нутаг, унаган байгаль гэж хэлэх нь гарцаагүй. Тийм ээ, гурван сая хүрэхгүй хүн амтай Монголын ард түмэнд Ази тивд орших асар том газар нутаг дээр амьдрах аз завшаан тохиожээ. Энэхүү уудам өргөн тал нутгийн маань газрын гүнд чамлахааргүй их хэмжээний төрөл бүрийн эрдэнэс баялаг байгааг судалж тогтоосон билээ.

Засгийн газрын 304 дүгээр тогтоолын дагуу “Алт” хөтөлбөр анх 1991 оноос хэрэгжиж эхэлснээс хойш уул уурхайн салбар өнөөг хүртэл эрчимтэй хөгжиж, Монгол Улс дэлхийн анхаарлын төвд зүй ёсоор ордог болов. Шилжилтийн үеийн эдийн засгийн цар хүрээг тэлэхэд 1990-ээд оны үед байнгын төсвийн алдагдлын улмаас хүндрэлтэй байсан. Иймээс ажлын байр бий болгоод, татвараа төлж л байвал аж ахуйн нэгжийн хариуцлага, хяналтын асуудалд улс төдийлэн анхаарал хандуулдаггүй байсан нь үнэн. Одоо бол харин байдал өөр болжээ. “ДНБ-ий 23 хувь, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 60-аас дээш хувь, төсвийн орлогын 20-иос дээш хувь, экспортын 80-аас дээш хувийг уул уурхай эзэлж байгаа” гэж УИХ-ын гишүүн С.Оюун ярилаа. Өөрөөр хэлбэл, таван төгрөгийн нэг нь уул уурхайн салбараас орж ирж байна гэсэн үг. Үүнээс харахад, уул уурхайгаас

бодитой ашиг олох бүрэн боломж бүрджээ. Гэтэл үүний зэрэгцээ ямар ч ашиг орлогоос илүү амин чухал нөхөн сэргээлтийн асуудлыг хөндөхгүй байхын аргагүй.

Арван таван аймгийн хэмжээнд энэ оны байдлаар уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдэрсэн газрын талбай нь 17000 га хүрсэн бөгөөд үүний талд нь ч хүрэхгүй хувьд буюу 5000 орчим га-д нөхөн сэргээлт хийжээ. Энэхүү эвдрэлд орсон нийт талбайн ойролцоогоор 1000 га нь “нинжа” нар буюу хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байна. Нөхөн сэргээлт хийгдээгүй үлдсэн 16000 га талбай социализмын үед хаягдсан ба уул уурхайн компаниудын орхисон орд газрууд эзлэх аж. Эзэнгүй орхигдсон эдгээр ордын ихэнх нь нүүрс, төмрийн хүдрийн үндсэн орд байдаг аж. Тухайлбал, Дорноговийн хайлуур жоншны орд, Хэнтийн цөөнгүй орд эдгээрийн тоонд багтана.

С.Оюун, Д.Энхбат, Г.Баярсайхан УИХ-ын гишүүд “Газрын тос болон ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэрхэн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай” нэртэй хуулийн төсөл санаачлаад энэ оны зургадугаар сард багтаан өргөн барих гэж байна. Уул уурхайн нөөц ашигласны төлбөрөөс тав хүртэлх хувийг тусгай санд төвлөрүүлээд, тэрнийгээ уурхайн нөхөн сэргээлт, байгаль орчны төсөл хөтөлбөрүүдэд зарцуулах энэхүү хууль батлагдвал эзэнгүй орхигдсон үй олон газрын нөхөн сэргээх ажилд бодитой бөгөөд жинтэй хувь нэмэр болох нь дамжиггүй.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх явц хангалтгүй, “халтар царайтай” байгааг холбогдох байгууллагын мэргэжилтнүүд бүгд хүлээн зөвшөөрч байна. Уул уурхайн нөхөн сэргээлтэд ерөнхийдөө 2003 оноос хойш л анхаарал хандуулж, шаардлага тавьж эхэлсэн гэж хэлж болно. Энэ асуудлыг гардан авч, хариуцан хийлгэх төрийн байгууллагууд гэвэл Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамаарна. Холбогдох байгууллагууд нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжтэй хариуцлага тооцож, тухайн аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажлын хэм хэмжээг тодруулж, оны эцэст нөхөн сэргээлтийн үйл явцыг дүгнэдэг байна. Дүгнэлтэд хамрагдаагүй аж ахуйн нэгжийн ажлыг эхлүүлэхгүй байх зэргээр хариуцлагын арга хэмжээг чангатгасны үр дүнд нэг талаасаа компаниуд хариуцлага хүлээдэг болсон гэж хэлж болно. 2010 оноос уурхай нээхээс өмнө бүх эрсдэлээ тооцоолж, хаалтын үед ямар байдалтай

►үлдээхийг тодорхой болгосон, түүнчлэн уурхайн хаалтаас өмнө нөхөн сэргээх ажлыг хийх ёстой байх гэсэн хатуу шаардлага тавьж, илүү мэргэжлийн тал руу нь хандуулж өгч байгаа гэнэ.

Мөн түүнчлэн мэргэжилтнүүдийн ярианаас үзэхэд сүүлийн үед томоохон компаниуд байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны алба хэлтэстэй, орон нутгийн иргэдтэй зөвлөдөг болж байгаа нь нөхөн сэргээлтэд тодорхой хэмжээний ахиц гарсан гэж үзэж болохоор байна. 2006 оноос нөхөн сэргээлтийн 70 орчим мэргэжлийн байгууллага бий болж, 2008 онд уул уурхайн нөхөн сэргээлтийн стандартыг таван стандарттайгаар тогтоож баталсан билээ.

Үүнээс өмнө зөвхөн алтны шороон орд дээр мөрддөг журамтай байсан ба 2008 оноос эхэлж уурхайг ил, далд хэлбэр төрлөөр нь ангилж авч үзэх болжээ. Цаашид техник технологийн өндөр стандартыг нэвтрүүлж, орон нутагтайгаа зөв зохистой харьцаж чадах, аюулгүй ажиллагааны стандартыг, мөн тухайн уул уурхайн онцлогт тохируулсан нарийвчилсан стандартыг бий болгох нь нэн тэргүүний чухал асуудал болоод буй ажээ. Учир нь, аливаа хяналт, шаардлага стандартын дагуу тавигдах тул стандартыг сайжруулж, мэргэжлийн төвшинд дэлгэрүүлэн нарийвчилсаны үндсэн дээр хариуцлагатай уул уурхай болж хөгжих жамтай.

Мөн 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн уурхайг хаах үед тавигдах шаардлагыг заасан 45-р зүйлийг харахад ердөө л тавхан заалттай байна. Энэхүү таван заалт нь хөгжиж байгаа бүхэл бүтэн уул уурхайн салбарт хаанаа ч хүрэлцэж зохицуулж чадахгүй нь хэн бүхэнд ойлгомжтой. “Австралийн нэгэн том эрдэмтний Уулуурхай ямар тохиолдолд хаагддаг вэсэдвээрхийсэн судалгаанд нэгдүгээрт нөөц дуусахад, хоёрдугаарт, үнэ буурахад, гуравдугаарт, байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдоход, эцэст нь Засгийн газрын гэнэтийн шийдвэрийн улмаас гэсэн дөрвөн шалтгаан нэрлэсэн байдаг. Гэтэл манайд зөвхөн нөөц дууссан гэж ярьдаг” гэж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, Геологи, уул уурхайн хяналтын газрын дарга Н.Батбаяр өгүүлэв. Тэрбээр



Нөхөн сэргээгдээгүй уул уурхайн ордын дүр зураг нэг иймэрхүү

ойрын хугацаанд зайлшгүй шийдэл олох ёстой бас нэг тулгамдсан жишээг дурдав. Их гүнтэй ил уурхайн орон зайг эргүүлээд нөхөн дүүргэх, уурхайн хаалтын үед ямар байдлаар хүлээж авах асуудал тодорхой бус байна. 40 метрийн гүнтэй байдаг алтны шороон ордыг буулж, тэгшилж болдог. Харин 200, 350 метрийн газрын гүн рүү ашигласан уурхайн хувьд нөхөн сэргээлтээ хэрхэн хийх вэ? гэдэг асуудал бий аж. Одоогийн эрх зүйн зохицуулалт энэ харилцааг зохицуулж чадахгүй байгааг дээрх жишээ харуулж байна.

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл явц нь тухайн газар зүйн онцлогоос шалтгаалж ялгаатай байна. Энэ талаар БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэргэжилтэн С.Эрдэнэцэцэгээс тодруулахад, “Нөхөн сэргээлтийн таатай орчин бүрдсэн Хангай, Хэнтий, Сэлэнгэ, Заамар гэсэн газарт хөрсөө хуулаад, техникийн дагуу нөхөн сэргээлт хийвэл ургамалжилт 2-3 жилийн дотор бүрдэнэ. Харин Баянхонгор, Өвөрхөнгөй, Говийн бүсэд нөхөн сэргээлт хийхэд хэцүү байдаг” гэсэн мэдээлэл өгөв.

БОАЖЯ-наас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулагдах хөрөнгийг баталжээ. Түүнийгээ хэрэгжүүлэх баталгаа болгож ашигт малтмал олборлож байгаа аливаа аж ахуйн нэгж тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтэд зарцуулах мөнгөнийхөө 50 хувийг нь Төрийн сангийн нөхөн сэргээлтийн тусгай дансанд 2006 оноос эхэлж байршуулах болжээ. Тус санд одоогийн байдлаар 190-ээд аж ахуйн нэгж хамрагдаж, гурван тэрбум орчим төгрөг хуримтлагдсан байна. Хэрэв тухайн жилдээ энэ арга хэмжээгээ хэрэгжүүлээгүй бол зардал нь сандаа үлдэж, нөхөн сэргээлтийг өөр байгууллагаар хийлгэх тохиолдолд ашиглахаар зохицуулагдсан байна. Түүнчлэн 2006 оны Ашигт малтмалын хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг мэргэжлийн байгууллагууд дэвшүүлж байгаа бөгөөд жишээ нь Монголын уул уурхайн үндэсний ассоциациас гэхэд л Байгаль орчны нөхөн сэргээлтийн даатгал ба эрсдэлийн сан бий болгох тухай санал оруулсан байгааг гүйцэтгэх захирал Н.Алгаа дурдлаа.

Уул уурхайн хэдэн зуун жилийн түүхтэй гаднын орнуудын туршлагаас харахад, уурхайн хаалтын үйл ажиллагааг янз бүр хийсэн байх бөгөөд жишээлбэл зарим нь аялал жуулчлалын чиглэлээр ашиглаж байхад нөгөө хэсэг нь усан спорт, наран шарлагын газар, цанын бааз, сургалтын полигон, цэцэрлэгт хүрээлэн, тэр ч байтугай казино болгож ашиглаж байгаа туршлага бий. Манай орны хувьд аялал жуулчлалд ашиглахаар биш юм аа гэхэд ядаж бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээх нь илүү дөхөм байх юм гэж зарим мэргэжилтэн үзэж байна.

Нөхөн сэргээлтийг үлгэр жишээ хийсэн аж ахуйн нэгж манайд бараг байхгүй ч нөхөн сэргээлтийн ажлаа тодорхой хэмжээнд гүйцэтгэж байгаа компаниудад Багануур ХХК, “Гацуурт”, “Бороо Гоулд”, “Монполимет”, “Пибоди” зэргийг дурдаж болох аж. Ашигт малтмал, уул уурхайгаас олох ашиг хонжоо улс орны эдийн засгийн хувьд хэдий чухал ч эвдэрч сүйтгэгдэж байгаа газар нутгаа монголчууд бид хайрлахгүй бол нэгэн цагт байгаль биднээс нүүрээ буруулж, ямар ч гамшиг ирж болзошгүйг бодох цаг иржээ. ■



Институционал хөрөнгө оруулагч

Даатгуулагчдын мөнгөөр хөрөнгийн биржээ дархлаажуулья

Д.Мөнхчимэг

“Монголын төмөр зам” компанийн 49 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан худалдаалах гэж байгаа тухай мэдээлэл өнгөрсөн тавдугаар сард цацагдсан билээ. Энэ нь манай хөрөнгийн зах зээлийн хувьд урьд хожид үзэгдээгүй сонин тохиолдол болсон юм. 1990 онд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, хөрөнгийн бирж үүссэн. Одоо бол Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын

ихэнх нь 1990-ээд оны хувьчлалаас төрсөн “бүтээгдэхүүн” юм. “Багануур”, “Шивээ овоо”, АПУ, “Шарын гол”, “Монголын цахилгаан холбоо”, “Улсын их дэлгүүр” гээд зах зээлийн үнэлгээгээрээ тэргүүлэгч компаниуд бүгд л эртний танилууд билээ. Гэтэл сүүлийн 10-15 жилд бий болсон “Моннис”, MCS, “Петровис”, “Номин” зэрэг томоохон компани хувьцаа гаргаагүй л байгаа шүү дээ. Харин Тавантолгойн нүүрсийг дэлхийн зах зээлд хүргэх төмөр замын амин

судсыг атгаж буй “Монголын төмөр зам” компани дотоодын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох болсон нь түүхийн шинэ хуудас нээж байх шиг. Үүний араас үндэсний компаниудын IPO хөвөрч мэднэ. Гол нь тэдгээр компанид хэн хөрөнгө оруулж чадах вэ? Монголчууд уу, эсвэл...

Гаднынхны тоглолт эрчимжлээ

“Market Vectors”-ын толгой компани буюу Америкийн зургаа дахь том Биржийн сангийн хувьцаа гаргагч “Van Eck” Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх ETF-ийг байгуулахаар төлөвлөж байна. Эрчим хүч, аж үйлдвэр, түүхий эдийн чиглэлийн компаниудын хувьцаанд уг ETF сангийн хөрөнгө оруулалтыг голчлон зориулах талаар “International Business Times” сэтгүүлд онцолсон байв. Энэ нь Төв Азийн бяцхан хөрөнгийн зах зээл аль хэдийнэ дэлхийн “акулууд”-ын овоо хараанд өртөж эхэлснийг гэрчлэх биз ээ.

Гэхдээ гаднынхан Сүхбаатарын талбайн зэргэлдээ орших жижигхэн ягаан байшинг аль эртнээс анзаарч эхэлснийг гэрчлэх баримт цөөнгүй. 2010 онд шинээр нээлгэсэн иргэдийн дансыг ажиглавал монгол иргэдийнх 1.9 хувиар, гадаад иргэдийн данс 34 хувиар өссөн үзүүлэлттэй байсан юм. Тэгвэл хуулийн этгээдийн дансны хувьд дотоодын хуулийн этгээдийн данс 7.5 хувиар нэмэгдсэн бол гадаадынх даруй 28.4 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь Монголын хөрөнгийн зах зээлийг гаднын байгууллага, иргэд сонирхож эхэлснийг харуулна хэмээн Үнэт цаасны газрын 2010 оны ажлын тайланд тэмдэглэжээ.

Монголын Топ 20 өнгөрсөн онд дэлхийн хамгийн өндөр өсөлттэй индексээр шалгарсныг сануулах юун. Гэвч хувьцааны ханшийн өсөлтөөрөө дэлхийг алмайруулж байсан манай уул уурхайн компаниудын үнэлгээ хаврын эхэн сараас навс унасныг та бид мэднэ. Энэхүү ханшийн хэлбэлзэл зүгээр ч нэг тохиолдол байсангүй. Хаана ашиг их гарч болохыг отоод сууж байсан гаднынхан манай зах зээлд “халуун мөнгө” цутгаж, ашиг олчихоод эргээд гарч явсан байх магадлалтайг зарим эх сурвалж өгүүлж байгаа юм.

Эдүгээ 200 жилийн түүхтэй Лондоны хөрөнгийн бирж Монголын хөрөнгийн биржийг дэлхийн жишигт хүргэнэ гэж байгаа. Гэвч монгол худалдан авагчдаа бэлдээгүй байж

» Монголын хөрөнгийн биржийг мянга сайжруулаад яах билээ? Манай ихэнх компанийн хувьцааг гаднынхан аваад дуусах бус уу? Одоо ч “Шарын гол”, “Багануур”, АПУ гээд Top 20 индекст багтдаг компаниудын ихэнх нь гадаадын сангуудын нөмөр нөөлгөнд их бага хэмжээгээр орчихоод явж байгаа шүү дээ.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн “түлхүүр”

Яагаад манай компаниуд дахь гаднын нөлөө нэмэгдээд байна вэ? Бид мөнгөгүй, чадалгүй учраас тэр гэж л битгий хэлээрэй. “Монголчуудад боломж байгаа ч түүнийгээ ашигладаггүй нь харамсалтай. Тэтгэврийн сангийн мөнгийг арвижуулах үүднээс хөрөнгийн зах зээлд оруулах нь зөв. Ер нь төрөл бүрийн сангууд санхүүгийн зах зээлийн тоглогчид болох учиртай. Ингэж байж үндэсний институционал хөрөнгө оруулагчид бий болно” хэмээн Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг тэмдэглэсэн юм. Институционал хөрөнгө оруулагч гэж хэнийг хэлээд байгааг Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болд “Mongolian Economy” сэтгүүлийн өмнөх дугаарт дэлгэрэнгүй тайлбарласан учир нурушаад яах билээ.

Ер нь санхүүгийн зах зээлийн урт хугацааны эх үүсвэр гол төлөв даатгалын компаниуд, тэтгэврийн сангуудаас бий болох нь элбэг аж. Эднийг л институционал хөрөнгө оруулагч гэж хэлээд байгаа юм. “Даатгал, тэтгэврийн сангууд гадаадад бол хөрөнгийн зах зээлийн хамгийн том тоглогчид байдаг шүү дээ” хэмээн Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Д.Болдбаатар тайлбарласан. Тийм ч болохоор 2011 онд мөнгөний талаар төрөөс баримтлах үндсэн чиглэлд “Урт хугацааны санхүүгийн эх үсвэрийг бий болгох арга хэмжээ авна” хэмээн заажээ. Урт хугацааны санхүүгийн эх үүсвэр нь хөрөнгийн зах зээл, тэтгэврийн сангуудаас бий болдог. Энэ хоёр нь бие биетэйгээ нягт уялдаа холбоотой байж гэмээнэ аль аль талдаа ашигтай байж чаддаг аж.

Тодруулбал, хөрөнгө оруулалт хийдэг санхүүгийн менежерүүд тэтгэврийн сангийн хөрөнгийг өсгөдөг байна. Яаж тэр вэ? Мэдээж

Засгийн газрын бонд, эсвэл хувьцаа худалдаж авна. Ингэснээр нэг талдаа сангийн хөрөнгө арвижиж, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүмүүсийн мөнгө өснө. Нөгөө талаас хөрөнгийн зах зээл хөгжинө. Гэхдээ ингэж нэг сумаар хоёр туулай харвахын тулд мэдээж маш сайн менежмент хэрэгтэй.

Бусад орны туршлагаас судлавал...

“Чилийн компаниуд Хонконг, Лондонд хувьцаагаа гаргах хэрэггүй байдаг. Яагаад гэвэл нутгаасаа мөнгө босгох бүрэн боломжтой. Тус улсын хөрөнгийн бирж маш сайн хөгжсөн. Үүнийгээ гадаадын тусламжаар биш, өөрийнхөө хүчээр хийсэн. Учир нь тэдний институционал хөрөнгө оруулагчид чадалтай. Энэ бүхнээс эцсийн дүндээ ард иргэд нь хождог юм” хэмээн “Eurasia capital” группийн захирал Алишер Али тайлбарлав. Чилийн тэтгэврийн систем эдүгээ 140 тэрбум ам.долларын хөрөнгө эзэмшиж байна. Хоёр жилийн дотор гадаад дахь хөрөнгөө 19.3 тэрбумаас 66.5 тэрбум ам.долларт хүртэл өгцөм өсгөжээ. Ази, Латин Америк зэрэг улс дахь Чилийн нийт хөрөнгө оруулалтын талаас илүү хувийг нь тус улсын тэтгэврийн систем дангаараа хийдэг ажээ.

Энд мөн Канад улсаар жишээ авч болно. “Ontario Teachers' Pension Plan” сан Онтарио хотын сургуулийн багш нарын тэтгэврийн сангийн мөнгийг санхүүгийн зах зээлд эргэлдүүлэх замаар өсгөдөг байна. 1989 оны арванхоёрдугаар сарын 31-нийг хүртэл Онтариогийн эрх баригчид уг санг удирддаг байсан агаад хөрөнгийн хэмжээг шалтай өсгөж чаддаггүй байж. Харин одоо хувийн компани менежментийг нь атгах болсноор Онтариогийн багш нарын тэтгэврийн хуримтлалыг өсгөж, баярлуулж байгаа гэнэ. Энэ мэтээр тоочоод байвал Норвеги, Япон, Голланд, БНСУ, Канад, АНУ гээд жагсаалт цааш хөвөрнө. “Towers Watson” компанийн хийсэн судалгаанаас үзэхэд дэлхийн томоохон 300 тэтгэврийн сан 2009 онд 11.3 их наяд ам.доллар эзэмшиж байсан аж.

Харин монголчуудын хувьд хамгийн ойрын хийгээд “будда идэх” боломжийн жишээ гэвэл Казахстан байна. Тус улсын эрх баригчид 1990-ээд онд залуучуудын тэтгэврийн санг улсаас тусгаарлаад,

хөгшчүүдийнхийг төрдөө авч үлдсэн юм. Ингээд Казахстанд хувийн тэтгэврийн, хөрөнгө оруулалтын болон хөдже сангууд мэндэлжээ. Жилээс жилд эдгээр нь өсөж томорсноор эдүгээ 90 тэрбум ам.долларын дотоодын хөрөнгө оруулагчийн чадавх бүрдсэн тухай Б.Болд ярьж байв.

Төсвийн цоорхой нөхөх Тэтгэврийн сан

Сар бүр Таны цалингийн 10 хувийг, ажил олгогчоос тань ахиад 10 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд авдаг. Гэхдээ энэ мөнгө хаана ямар хүүтэй хадгалагдаж, ямаршуу хэмжээгээр өсөж, яг хэдэн төгрөг болж байгааг бид мэдэх боломжгүй. Үүнийг бидний өмнөөс төр засгийн эрх баригчид зарцуулна. Та энэ мөнгөө банкинд хадгалсан бол 30 жилийн хугацаанд хэдэн зуун сая төгрөг болтол нь өсгөх бололцоотой юм. Харамсалтай нь Таны энэ их мөнгийг төр луйвардаж байна гэж хэлэх үндэслэл даанч олон бий.

Та насан туршдаа нийгмийн даатгалын шимтгэл төлчихөөд, 55 хүрэлгүй нас барчих юм бол “хохь чинь”. Таны бүхий л амьдралынхаа турш хуримтлуулсан мөнгөний жаахан ч болов хэсэг гэр бүл, үр хүүхдэд тань очдог байсан бол өөр хэрэг л дээ. Үүний хажуугаар Та 20 жилийн турш шимтгэл төлж байж цалингийнхаа 45 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэвэр авна. 30 жил бол 60 хувь, 40 жил бол 75 хувьтай дүйцнэ. Тэр хугацаанд инфляци хэрхэн өсөх, таны авах тэтгэвэр амьдралд тань хүрэлцэх эсэх хэнд ч падлийгүй. Аймшигтай бус гэж үү?

“Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх хэрэгтэй. Тэтгэврийн санг биеэ даасан болгож, туршлагатай багаар удирдуулах нь зүйтэй. Ер нь хувийн тэтгэврийн сангууд байгуулагдах боломжийг ч хангаж өгөх хэрэгтэй. Ингэвэл дотоодын институционал хөрөнгө оруулагчид бий болохын хажуугаар нийгмийн даатгалын тогтолцоо ч сайжирна” хэмээн МИСС-ийн ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ тэмдэглэв.

Харамсалтай нь манай Тэтгэврийн сан төсвийн цоорхой нөхөхөөс цаашгүй. Нэгдсэн төсвийн тооцооны “Татварын орлого” гэсэн хэсэгт нийгмийн даатгалын шимтгэл, хураамж орчихсон тууж явах нь энгийн үзэгдэл болоод удаж байна. Засгийн газар энэ

► маягаар Тэтгэврийн сангаас 2.1 их наяд төгрөгийг та бидэнд мэдэгдэлгүйгээр “хүүгүй зээл” болгон ашиглаж, төсвийн цоорхойгоо нөхөж ирснийг МҮЭХ хоёр жилийн өмнө илрүүлсэн билээ. Зүй нь гэвэл уг санд хуримтлагдсан мөнгө сайд, дарга нарын халаасанд шингээд алга болох биш, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх урт хугацааны эх үүсвэр болох ёстойг мэргэжилтнүүд дахин дахин анхааруулсаар. Ингэж байж та бидний төлсөн нийгмийн даатгалын шимтгэл хүү төрүүлэн өсөж, хэцүү цагт бидэнд буцаад ирж байх учиртай.

Яаравчлахгүй бол горьгүй нь!

Яагаад Монголын томоохон компаниуд хувьцаа гаргахдаа хойрго байна вэ? Худалдаж авах хүн байхгүйгээс тэр. Монголд институционал хөрөнгө оруулагч алга. Эрэлт үгүй байхад нийлүүлэлт хийх “маанаг” олох уу? Ийм үед Монголын хөрөнгийн биржийг Лондоны хөрөнгийн биржээр удирдууллаа ч дорвитой үр дүн гарна гэж үү? гэх мэтийн олон асуулт толгой гашилгах аж. За яах вэ, техник технологи, дэд бүтэц нь сайжраад олон улсын түвшинд хүрлээ гэж бодъё. Тэр үед Монголын компаниудын хувьцааг хэн авах вэ? Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж “татварын орлого” болоод явдаг, хувийн тэтгэврийн систем бүрдээгүй, даатгалын компаниуд нь хөрөнгийн зах зээлд хөл тавих боломж, бололцоо нь тааруухан өнөө үед монголчууд лав их хэмжээний хөрөнгө оруулалт хийж чадахгүй нь тодорхой. Тэгвэл мөнгө ихтэй, менежмент сайтай гадаадын хөрөнгө оруулагчид л Монголын хөрөнгийн биржийн гол “тоглогчид” болох нь гарцаагүй ээ.

Өнөөдөр монгол хүн бүр нэрийн данстай, дансандаа 536 ширхэг “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаатай болсон. Гэхдээ гурван монгол хүний нэг нь нэн ядуугийн ангилалд багтаж байгаа өнөө үед үнэгүй авсан хувьцаагаа хүмүүс хамгийн анхны боломжоор зарж, хоногийн хоолоо залгуулах магадал тун ч өндөр байгааг учир мэдэх хүмүүс тайлбарлаж буй. “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд гаргаж, зах зээлийн үнэ цэнэ нь тогтох үед арилжаа нээлттэй болно гээд байгаа шүү дээ. Тэр үед манай хөрөнгийн бирж дэх гадаадын хөрөнгө

оруулагчдын тоо улам л өссөн байх нь дамжиггүй. Ингээд хувьцааны урсгал гадагш чиглэх аюултайг Б.Болд тэргүүтэй олон мэргэжилтэн сануулж байгаа юм.

Энэ бүхний эцэст гаднынхныг нүд үзүүлж, дэмий сүржигнэх гэсэнгүй. Харин ч гадаадын институционал хөрөнгө оруулагчид манайд орж ирэхдээ “ноухау”-гаанутагшуулахаас эхлээд олон сайн талтай. Гэхдээ л харийнхнаас хэт хамааралтай болж яавч болохгүй ээ. Гадаадын хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн бирж дэх бүх хувьцааг авлаа гэж бодъё. Гэтэл гэнэт дэлхийн зах зээл дэх нүүрс, зэсийн үнэ навс унадаг ч юм уу, ямар нэгэн байдлаар Монгол Улс моодноос гарвал гаднынхан “Bye bye” гээд л бууцна. Манай бирж үхмэл байдалдаа эргээд л орно. Тиймээс л дотоодын институционал хөрөнгө оруулагчдыг бий болгох ёстойг мэргэжилтнүүд тайлбарлаж байгаа юм.

“Дугуйг цоо шинээр зохион

бүтээх гэж дэмий хийрхэхийн оронд дугуйтай болсон амжилтыг нь хууль” хэмээн Ерөнхий сайд хэлж байв. Тэгвэл үндэсний институционал хөрөнгө оруулагчдыг бий болгохын тулд шинэ зүйл зохиох шаардлагагүй, зүгээр л Казахстаны туршлагыг нэвтрүүлж болох ажээ. Ийнхүү нийгмийн даатгалын системд насны эрэмбээр зохицуулалт хийж чадвал хувийн тэтгэврийн сангууд хөгжиж, шимтгэл төлөгч залуучуудын мөнгийг хөрөнгийн зах зээлд эргэлдүүлж болох буюу. Товчхондоо, даатгуулагчдын мөнгөөр хөрөнгийн биржээ дархлаажуулж болох нь. “Эхэндээ жаахан мөнгө байх ч жилээс жилд залуучуудын тэтгэврийн мөнгө нэмэгдээд л явна. Тэгээд 10 жилийн дараа Монголын залуучууд дотоодын төдийгүй олон улсын арилжаанд оролцох чадвартай болохыг үгүйсгэхгүй” хэмээн Б.Болд тэмдэглэсэн билээ. ■

News

Компанийн засаглалыг сайжруулах туршлага солилцов

Монголын компанийн засаглалын IV форумыг өнгөрсөн зургадугаар сарын 13-нд Компанийн засаглалын хөгжлийн төв Монголын хөрөнгийн биржтэй хамтран зохион байгуулав. Энэхүү чуулга уулзалтын үеэр Хонконг, Лондон, Шанхайн хөрөнгийн биржийн төлөөлөл оролцож, тухайн биржид бүртгүүлэхэд компанийн засаглалд ямар шаардлага тавьдаг тухайгаа танилцуулсан бол олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтэрч чадсан “Энержи ресурс”, “Петро Матад”-ын захирлууд IPO хийсэн туршлагаасаа хуваалцсан юм.

Мэдээж манай оронд компанийн засаглалыг хэрхэн хөгжүүлэх, захирлуудын энэ талаарх мэдлэгийг яаж сайжруулах талаар оролцогчид саналбодлоосолилцсон. “Монголын хөрөнгийн бирж мэдээллийн цахим хуудастай болж, компаниуд холбогдох мэдээллээ өгөхгүй бол

хувьцааг нь блоклох хүртэлх арга хэмжээ авах гэж байгаа” хэмээн Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болд уулзалтын үеэр тэмдэглэв. Түүнчлэн монголчууд Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрөө баталсан бөгөөд цаашдаа Ажлын алба байгуулж, төлөвлөгөө гаргах гэж байгааг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан зочдодоо танилцуулсан юм. Мөн энэхүү форумын үеэр компаниудын ТУЗ-д тавих шаардлага, хараат бус захирлуудын талаар хэлэлцүүлэг өрнөсөн бөгөөд Компанийн тухай хуулийн шинэчлэгдсэн найруулга энэхүү чиглэлийг сайжруулах тал дээр ихээхэн найдлага төрүүлж байгааг мэргэжилтнүүд онцолж байлаа. Дашрамд сонирхуулахад, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн ТУЗ-ийн есөн гишүүний найм нь хараат бус ажээ.

Хөрөнгө оруулагч

Пиетро Доран: Солонгосын институционал хөрөнгө оруулагчдыг Монголд татах сонирхол их байна

Д.Бэхбаяр

“Кorea Mongolia resources” сангийн гүйцэтгэх захирал Пиетро Дорантай ярилцлаа. Тэрбээр Солонгос улсад хөрөнгө оруулалтын томоохонд тооцогддог “Doran Capital Partners” группийн эзэн бөгөөд манай “Eurasia Capital” компанитай хамтран “Korea Mongolia resources” санг байгуулаад байгаа билээ. Түүнийг Монгол Солонгосын бизнесийн форумын үеэр ирээд байхад нь уулзаж ярилцсан юм.

-Юуны түрүүнд Таны Монголд ирсэн зорилго юу вэ?

-Би Монголыг илүү ихээр таньж, мэдэх зорилготойгоор ирсэн. Дөрвөн жилийн турш “Eurasia Capital” компанийн дэргэдэх зөвлөлийн гишүүнээр ажилласан. Энэ хугацаандаа тус компанийн захирлын ажил явуулж буй арга барил, олон улсын хөрөнгө оруулагчдын дунд танигдсан байдал, ярих чадвар зэрэг олон чанарыг өндрөөр үнэлсэн. Тиймээс “Eurasia Capital” компанийн захирал Алишер Алитай хамтран хөрөнгө оруулалтын сан байгуулаад байна.

Ер нь бусад улс оронд ховорхон тохиолддог боломж Монгол Улсад өнөөдөр нээгдсэнээр томоохон хүлээлт бий болоод байна гэж үзэж байгаа. Миний хувьд сүүлийн 20 жилд яг танай орон шиг үсрэнгүй хөгжлийг дагасан орнуудад ажиллаж байсан. Тухайлбал, Өмнөд Солонгос улсад байсан тэр эдийн засгийн үсрэнгүй хөгжил танайд мөн хүлээгдэж байгааг харлаа. Үүнийг би мэдэрч байна. Улс орон бүрийн хөрөнгийн зах зээлийн салбарт нь надтай адилхан хашир туршлагатай мэргэжилтнүүд ажиллаж байдаг. “Eurasia Capital” компанийн захирал Алишер Алигийн хувьд мөн энэ талын нэлээд туршлага, мэдлэгтэй



хүн. Тиймээс бид хамтраад ажиллахад Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах байх аа гэж бодож байна. Ер нь бол БНСУ-ын хөрөнгийн зах зээлд хуримтлуулсан арвин туршлагыг танай орны боломж бололцоотой нэгтгэн ажиллаж чадвал амжилтад хүрч чадна гэдэгт итгэлтэй байна.

Манай Солонгос дахь компанийн хувьд хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалт хийх талд дэс дараалалтай нэлээдгүй олон шаардлагыг тавьж ажилладаг. Ингэснээрээ бид томоохон хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс зайлсхийхэд нь тусалдаг. Зарим тохиолдолд хөрөнгө оруулагчдын хийсэн хөрөнгө оруулалт амжилтгүй болоход тухайн улс болон хөрөнгө оруулагчдын нэр хүнд олон улсын зах зээлд буурдаг. Энэ мэт эрсдэлээс Монгол Улсыг төдийгүй хөрөнгө оруулагчдыг зайлсхийхэд нь манай сан туслах зорилготой юм. Бид хамтарч ажилласнаар гадаадын тэр дундаа Солонгосын мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт Монголд хөрөнгө оруулах ямар боломж бололцоо байна гэдгийг таниулах, ямар эрсдэлүүд гарч болзошгүй талаар зөвлөгөө өгч, хууль эрх зүйн талаас нь дэмжих зэрэг үйл ажиллагаа явуулна. Монгол орны хувьд хууль эрх зүйн тогтворгүй байдал нь багагүй эрсдэлийг дагуулж болзошгүй. Хөгжиж буй орнуудад улстөрийн болон хууль эрх зүйн орчин нь тогтворгүй байх зэрэг тодорхой эрсдэлийг дагуулж байдгийг мэднэ л дээ. Иймэрхүү эрсдэлээс хөрөнгө оруулагчдыг хол байлгахыг хүсэж байна.

-Тэдгээр эрсдэлээс зайлсхийхийн тулд ямар арга хэмжээ авах ёстой вэ?

» -Нэгдүгээрт, тухайн улсад ажилладаг томоохон түнштэй байх шаардлагатай. Мөн дотоодын эдийн засгийг сайн мэддэг, тогтвортой ажилладаг сайн баг бүрдүүлэх ёстой. Дотоодын зах зээлийг сайтар судалж мэдсэн тохиолдолд эрсдэлээс зайлсхийх боломжтой. Төрийн тогтвортой бодлого, зохицуулалт зэрэг нь чухал асуудлын нэг. Төрөөс шинээр санаачилж байгаа хууль, дүрмүүд нь хуулийн цоорхойгүй байх шаардлагатай. Хуулийн хэрэгжилт ч мөн сайн байх нь хамгийн гол юм. Монгол Улс уул уурхайн салбартаа түшиглэн хөгжиж байна. Уул уурхай өөрөө нэлээд хөрөнгө шаарддаг салбар. Энэ утгаараа Монгол олон улсын хөрөнгө оруулалт, томоохон капиталуудыг татах хэрэгтэй. Бидний хувьд Солонгос улсын институционал хөрөнгө оруулагчдыг Монголд оруулж ирэх сонирхол их байна. Учир нь, Монгол орны хөрөнгийн зах зээл дэх өнөөгийн дүр зураг 20 жилийн өмнөх Солонгос улсынхтай адилхан байгаа юм. 20 жилийн өмнө тус улсад хөрөнгө оруулахад саад бэрхшээл үзүүлэхээр хуультай байсан гэж ярилцдаг байв. Ийм учраас солонгосчууд Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдлыг ойлгож, энэ бүхэн ирээдүйд өөрчлөгдөнө гэдгийг мэдэж байгаа учраас тэд Монгол орныг сонирхож хөрөнгө оруулна гэж бодож байна. Энэ нь танай орны хувьд бас нэг томоохон давуу тал гэж ойлгож байгаа.

-Солонгосын хөрөнгийн зах зээлд ажиллаж байгаа туршлагаасаа хуваалцана уу?

-1990-ээд оны үед Солонгосын хөрөнгийн биржийн индекс нь 700 гэсэн үзүүлэлтээс дээшээ гарч байгаагүй. Учир нь, тус улсын зах зээлийг тухайн үед ойлгодог хүн ховор, бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчны мэдээлэл маш дутмаг, компаниуд нь ч ямар үйл ажиллагаа явуулдаг нь тодорхой бус байсан л даа. Хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалсан хуульгүй байлаа. Компаниуд нь хувьцаа эзэмшигчдээ өөрсдөд нь хэрэгтэй хүмүүс гэж боддоггүй, нэр төдий л хүлээн авна. Харин энэ бүхэн арвахан жилийн дотор бүрэн өөрчлөгдсөн. Аж ахуйн нэгжүүд нь ил тод нээлттэй болсон. Санхүүжилт олохын тулд гаднын туршлага, мэдлэгийг судалж эхэлсэн. Тэгээд гаднын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгоод ирэхээр хуулиараа дотоодод хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, компаниудыг ил тод нээлттэй байхыг шаардаж байсан. Үүнийг дагаад дотоодын зах зээл нь нээлттэй болж, улмаар Солонгосын нэр хүнд олон улсын хөрөнгө оруулагчдын дунд өсөж эхэлсэн гэж хэлж болно. Өнөөдөр Солонгосын хөрөнгийн биржийн индексийн үзүүлэлт 2200 болжээ. Миний хувьд тус орны хөрөнгийн зах зээлийн өсөлтөд 1998 оны Азийн санхүүгийн хямрал томоохон нөлөө үзүүлсэн гэж боддог. Тухайн үед томоохон компаниуд зээл авах замаар үйл ажиллагаагаа явуулдаг байгаад хямралын дараа хувьцааны зах зээл рүү шилжин орсон. Энэ нь илүү хямд, ашигтай орчинг бий болгосон бөгөөд компаниудыг илүү нээлттэй байхыг шаардсан юм. Эндээс нэг сонирхолтой зүйл харагдаж байна. Хорин жилийн өмнө хөрөнгө оруулагч нарт халгаатай байсан улс өнөөдөр гадагш хөрөнгө оруулахдаа хорин жилийн өмнө өөрсдөөс нь шаардаж байсантай яг ижил зүйлийг шаардаж байна. Гаднын хөрөнгө оруулалт нь солонгос компаниудыг илүү нээлттэй ил тод болгосон

гэдгийг дахин хэлмээр байна. Энэ нь тэдний үнэ цэнийг өсгөсөн. Харин одоо солонгосчууд, Монголын компаниудаас илүү ил тод байхыг шаардаж байна. Энэ бүгдээс харахад компаниудын ил тод нээлттэй байдал, хувьцааны зах зээл, хөрөнгө оруулагчдыг хүндэтгэх зэрэг нь ашигтай ажиллах гол хүчин зүйл гэж би дүгнэдэг. Өнөөдөр Солонгос улс зах зээлийн ил тод, хөрөнгө оруулагчдын эрхийг хүндэтгэдэг байдлаар нэлээд сайн гэж бодож байна. Хувьцааны, үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь сайн зохицуулалттай бөгөөд би эдгээр зах зээлд нэлээд туршлагатай гэж хэлж болно.

Би Солонгос оронд 40 мянган монгол иргэн ажиллаж амьдарч байна гэж дуулсан. Тэдний нэлээд хэсэг нь оюутнууд байгаа нь мэдээж. 20 жилийн өмнө яг үүнтэй адил солонгосчууд Америк улс руу оюутан залуусыг суралцуулахаар явуулж, тэдгээр оюутан нь Америкийн туршлага зах зээлийн сайн талуудыг эх орондоо авчирсан. Түүн шиг монгол оюутнууд Солонгосоос хөрөнгийн зах зээл дээр ажиллах мэдлэг туршлага хуримтлуулаад эх орондоо ирэх болно.

Солонгос хүмүүс өөрсдийгөө эртний монголчуудаас үүсэлтэй, төрөхдөө хөх толботой төрдөг гэж ихэд бэлгэшээдэг. Энэ утгаараа Монголд хөрөнгө оруулахдаа өвөг дээдсийнхээ эх орныг хөгжүүлж байна хэмээн баяртай байх болно. Бидний ажилд ийм сэтгэлгээ нь ихээхэн тус болно гэж бодож байгаа. Нэг зүйл хэлэхэд, монголчууд хөгжлийн загварыг Европ, Америк зэрэг улсаас хайх биш, харин Солонгосоос үлгэр дууриалал авах нь зүй.

-Та Солонгос улсад ажиллахдаа хүндрэлтэй байсан асуудлуудыг хэрхэн шийдэж байсан бэ?

-Сайхан асуулт байна. Тухайн үед гаднын хүмүүс Солонгос руу томиллолтоор явах дургүй байсан. Анх намайг тохиолдлоор энэ улсад ирэхэд америк цэргүүдээс өөр гадаад хүн бараг байдаггүй байж билээ. Мэдээж ажиллахад хүндрэлтэй асуудлууд их гарна. Энэ үед надад гурван том давуу тал байсан юм. Нэгдүгээрт, залуу, хоёрдугаарт, тэнэг, гуравдугаарт, адал явдал хайгч. Залуу байна гэдэг эрч хүч, итгэл зориг дүүрэн байна гэсэн үг шүү дээ. Туршлага ч багатай, юмны учир начрыг сайн ойлгодоггүй байсан тул ямар нэг зүйлийг ийм л хүнд хэцүү байдаг юм болов уу гэж төсөөлж хүлээж авдаг байсан. Хялбар бөгөөд амархан гарах гарцыг олж хардаггүй байж. Солонгос оронд анхлан очиход оюутан залуус нь сургуулиа төгсөөд сайн ажиллах ёстой гэсэн зорилготой ажиллаж, сурдаг, иргэд нь барагтай бол инээмсэглэдэггүй ч их энергитэй байлаа. Энэ бүгдийг хараад би бас ийм байх ёстой юм байна гэж бодож билээ. Харин сая Монголд ирэхэд бас яг ийм сэтгэгдэл төрлөө. Монгол орон хөгжих хандлага байна, иргэд нь инээмсэглэдэггүй ч тэднээс их энерги мэдрэгдэж байна. Солонгос оронд ирсний дараа хүмүүс чи зургаан сарын дараа гэртээ харина гэж хэлж байсан. Тэгвэл би өнөөдөр тус оронд томоохон үл хөдлөх хөрөнгийн компани, бас бус жижиг компаниудыг босгосон. Өөрөөр хэлбэл, өөрийн гэсэн "хотыг" байгуулчихаад байна.

Тиймээс Солонгос оронд тусалж чадсан шигээ Монголд бас туслахыг хүсэж байна. Одоо миний давуу тал гэвэл илүү туршлагатай, ухаантай болсон. Ийм учраас л би Монголд ирэхээр шийдсэн юм. Монголд »

ажиллахад бидэнд нэг нууц байгаа. Бид энэ удаа саад бэрхшээл биш цоо шинэ боломжуудыг харж байна. Мөн энэ нь бидний хувьд ч ховорхон тохиох боломж. Хэрвээ ямар нэг бэрхшээл тулгарвал түүнд нь тохирсон зөв шийдлийг гаргаж чадна. Шийдвэр гэдэг маань ямар нэг хууль, дүрэм, нэр, томъёонд баригдсан зүйл огт биш. Харин хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн зөв шийдвэрийг гаргаж чадна. Энэ бол бидний хамтын ажиллагааны нууц гэж ойлгож болно.

-Танай сангийн Монголд үйл ажиллагаа явуулах эхний алхам чухам юу байх вэ?

-Эхний алхам бол хамгийн гол зорилгоо нэн түрүүнд тодорхойлох. Мөн хамгийн их ашиг өгч болох салбарыг тодорхойлж, солонгос хөрөнгө оруулагчдыг татах. Аль нь, ямар салбарын бизнес Монголын нөхцөлд тохирох таарах зэргийг сонгох гээд олон ажил байна. Энэ бүгдээс өмнө хаашаа хөрөнгө оруулах вэ гэдгийг л маш сайн мэдэх хэрэгтэй юм даа.

Хөрөнгө оруулахдаа бид тухайн компанийн засаглалыг ихээхэн анхаарна. Компанийн удирдлага өөрсдийн хийж байгаа, хийх гэж байгаа зүйлдээ хэр итгэлтэй байна гэдгийг харна. Хэрэв тэд өөртөө итгэж чадахгүй байх юм бол бид хөрөнгө оруулахгүй. Мэдээж тухайн компани ямар үйл ажиллагаа явуулахаас хамаараад хаашаа хөрөнгө оруулахаа, дараа нь тухайн хөрөнгө оруулалтаас хэрхэн ашиг хүртэх вэ гэдгээ тодорхойлно. Бидний анхны хөрөнгө оруулалт тухайн компанийн цаашдын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх нь дамжиггүй. Хэрвээ алдаа гаргах юм бол олон улсын хөрөнгө оруулагчдын дунд Монгол Улсын нэр хүнд унах эрсдэлтэй. Тийм болохоор бид ямар ч алдаа мадаггүй үйл ажиллагаа явуулна гэдгээ хэлмээр байна.

-Таны Солонгос улсад хийсэн анхны хөрөнгө оруулалт ямар амжилт бас ямар эрсдэлийг дагуулсан бэ?

-Би анхлан ганцаараа ажлаа хийж байлаа. Дөрвөн жилийн дараа гэхэд арван дөрвөн хүнийг удирдан ажиллаж байсан. Гэхдээ ажлаа эхэлснээс хоёрхон жилийн дараа нь дэлхийн хөрөнгө оруулалтын хамгийн том "Морган Стэнли" компани миний жижигхэн компанийг худалдаж авсан. Бид тус компанийн нэрийн өмнөөс хоёр тэрбум ам.долларын гаднын хөрөнгө оруулалтыг Солонгос улсад татсан.

Миний бодлоор амжилтыг гэнэтийн үсрэлт гэх мэт томоохон байдлаар дүрслэхэд хэцүү байна. Харин шат шатаар нь үнэлэх хэрэгтэй байх. Анх би ямарч туршлагагүй байсан хэдий ч арван жилийн дараа гэхэд Солонгос улсын хамгийн том хөрөнгө оруулагч компанийг удирдаад явж байсан. Өнөөдрийн байдлаар манай компани Сөүл, Хонконг, Лондон, Дели гэх мэт дэлхий даяар салбартай болжээ. Одоо Монголд салбараа нээхээр ирээд байгаа минь энэ.

Та амжилт болоод эрсдэлийн талаар асуусан. Тухайн үед миний хувьд багахан амжилт ч том мэт санагддаг байсан. Эрсдэл бол хаа ч адилхан байдаг. Тухайлбал, 20 жилийн өмнөх Солонгост гарч байсан эрсдэлийг өнөөдөр бид Монголд хүлээж байх жишээтэй. Гэхдээ хамгийн том эрсдэл бол бидний нэр хүнд юм. ■

News

"Global Alliance Partners" Монголд анх удаа хурал хийв

Манай улсад гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөх хандлагатай байна. Үүнийг энэ оны тав, зургадугаар сард Улаанбаатар хотод болж өнгөрсөн ач холбогдол бүхий цөөнгүй хурал уулзалт нотлох аж. Тухайлбал, Хонконгд бүртгэлтэй олон улсын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын сүлжээ "Global Alliance Partners" (GAP) нь манайд анх удаа гишүүдийн ээлжит чуулга уулзалтаа хийсэн. Хөрөнгө оруулалтын тэргүүлэх банк "Euroasia Capital" нь GAP-д шинээр гишүүн болсон бөгөөд өнгөрөгч тавдугаар сарын 25-нд Хөрөнгө оруулалтын олон улсын чуулганыг зохион байгууллаа. Монголын төр, хувийн хэвшлийнхэн, Япон, Солонгос, Сингапур, Хонконг, Швед, Англи, Герман, Америк, Хятад, Казахстан зэрэг дэлхийн 20-иод орны хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөгч оролцсон.

Уг хурлаар Засгийн газрын байр суурь болон бодлого, томоохон бизнесийн байгууллагуудын илтгэлийг танилцуулснаар оролцогчдод манай оронд хөрөнгө оруулалт хийх боломжийг илүү сайн ойлгуулан таниулж, мэдээлэл өгсөн юм. Гадаадын хөрөнгө оруулалт хийх салбарт зөвхөн уул уурхай төдийгүй, мөн хөрөнгийн зах зээл, банк, хөдөө аж ахуй, харилцаа холбоо, тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгө зэрэг орж байгааг "Euroasia Capital"-ын захирал Алишер Али дурдлаа.

Монголын хөрөнгийн зах зээлийн анхдугаар форум боллоо

Сүүлийн үед манай хөрөнгийн зах зээл олны анхаарлын төвд орох болсонтой холбоотойгоор Монголын хөрөнгийн зах зээлийн анхдугаар форум зургадугаар сарын 3-нд боллоо. Хөрөнгийн зах зээл нь манай оронд 1990-ээд оноос эхэлж хөгжсөн бөгөөд 2011 оны зургадугаар сарын 2-ны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй нийт 79 мэргэжлийн зуучлагч брокер дилерийн компани үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү форумд Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд төрийн бодлогын хэмжээнд ямар арга хэмжээ авах, түүнчлэн гадаадын биржид бүртгүүлэхэд ямар шаардлага шалгууртай байдаг, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг аж ахуйн нэгжид хэрхэн хуваарилах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тухай танилцуулсан байна.



Хууль

Ус усаа санхүүжүүлдэг болно

“Хууль” буландаа шинээр гарахаар зэхэж буй Ус бохирдуулагчийн тухай хуулийн талаар сонирхлоо. Ус хэрэглэдэггүй хүн, амьтан байхгүй учраас энэ хууль батлагдан гарах аваас олон байгууллага, иргэдэд хамаатай. Тийм ч учраас зөвхөн үйлдвэрлэгчид, уул уурхайнхан гэлтгүй хүн бүрийн сонирхлыг хөндсөн асуудал юм.

Усыг бид чандмань эрдэнэ гэж дээдлэн, магтдаг хэрнээ үнэ цэнийг нь өдий болтол сайн мэддэггүй. Дэлхий нийтэд усны нөөц ховордож, бөмбөрцгийн хүмүүсийн багагүй хэсэг нь ундны усны гачигдалд ороод буйг дуулж, мэдээд байгаа хэрнээ усаа хайрлаж, гамнахаа тэр бүр мэддэггүй билээ, монголчууд. Бидний нэг хэсэг нь Туулын усанд хирээ угааж байгаа дүр зургийг зуны зугаатай өдрүүдэд олонтаа харна. Түүнчлэн арьс ширний үйлдвэрийнхэн хорт бодистой бохир усаа Туул руу урсгаж нийлүүлэх нь ч энүүхэнд. Орон сууцны оршин суугчид ч бохирын шугамаар дэндүү бохир зүйл явуулах нь бий. Ус гэдэг чандмань эрдэнийг өвөг дээдэс зүрх сэтгэлээсээ шүтэн дээдэлж, бидний аав ээж урсгал ус руу хир битгий хэл, сүү цагаа оруулахыг ч хориглодог билээ. Тэгвэл гол мөрөн олноороо ширгэж, усны нөөц эрс багасаж буй өнөө үед ус бохирдуулагчтай хуулиар тэмцэхгүй бол болохгүй болжээ. Тиймээс Ус бохирдуулагчийн тухай хууль гаргуулахаар холбогдох байгууллагууд ажиллаж буй юм. Сонин, содон нэртэй уг хуулийн агуулга ямар байх, хуулийг боловсруулах болсон шаардлага нь юу болох, барим тавим ус бохирдуулаад буй этгээдүүдэд ямар хариуцлага тооцох вэ зэрэг асуудлаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын орлогч

дарга З.Батбаяртай уулзлаа.

Өнөөдөр манайд ус үнэтэй ч юм шиг үнэгүй ч юм шиг санагдах нь бий. Яагаад тэр юм бол оо. Монголчууд одоогоор ус ашигласны төлбөр, усны үйлчилгээний төлбөр гэж өгдөг байна. Ус ашигласны төлбөр гэдэг нь хэдий хэмжээний ус ашиглаж байгаагаас нь хамаараад шоо метр тутамд тооцдог төлбөр аж. Энэхүү төлбөрт бид хамгийн багадаа 10 төгрөг, ихдээ 150 төгрөг өгдөг байна. Сархад, шар айраг үйлдвэрлэж, ус ахиу хэрэглэдэг хүнсний үйлдвэрүүдийн хувьд гадаргын ус хэрэглэж байгаа бол 10 төгрөг, газар дорх ус хэрэглэдэг бол 30 төгрөгийн төлбөр төлөх жишээтэй. Гэхдээ энэ нь шоо метр тутамд буюу 1000 литр тутамд шүү дээ. Гэтэл гэр хорооллынхны хувьд ус үнэтэй. Учир нь, ус хамгийн бага хэрэглэдэг тэд нэг литр усыг 1-2 төгрөгийн үнээр авдаг юм. Долоон буудлын Дулмаа эмээ амралтын өдрөөр ач, зээ нараараа усаа базаалгаж 100 литр ус авлаа гэхэд 100-200 төгрөг шаардлагатай. Ус арвин хэрэглэдэг том аж ахуйн нэгжтэй харьцуулахад гэр хорооллынхон усыг өндөр үнээр ууж байгаа хэрэг. Дээрх ус ашигласны харилцан адилгүй үнийн тариф нь 1995 оны Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулагддаг байна. Монголын 10 гаруй жилийн өмнөх усны нөөц хийгээд мөнгөний ханшийг өнөөдрийнхтэй харьцуулахад бэрх. Хоёрдугаарт, усны үйлчилгээний төлбөрийг ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд төлдөг. Энэ нь зөвхөн бохир усыг татан зайлуулсны төлбөр гэнэ. 2002 оны Хот, суурингийн усан хангамж, ариутгах татуургын тухай хуулиар зохицуулагддаг аж. З.Батбаяр “Манайд ус эдийн засгийн эргэлтэд огт ороогүй байна. Аж ахуйн

нэгж, байгууллагууд зөвхөн бохир ус татан зайлуулсны л төлбөр төлж байгаа” хэмээн тэмдэглэсэн. Мөн тэрбээр “Сүүлийн жилүүдэд гол мөрнүүдийн бохирдол асар ихэссэн. Нөгөө талаас Улаанбаатарт тулгамдаад буй нэг асуудал усны бохирдол юм. Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрээс бохир ус их гардаг. Түүнчлэн бидэнд одоо байгаа нөхцөл байдлаа сайжруулахад асар их хөрөнгө оруулалт шаардлагатай. Ийм гурван шалтгааны үүднээс Ус бохирдуулсны төлбөр бий болгох зайлшгүй шаардлагатай байгаа юм” хэмээн учирласан. Ус бохирдуулагчийн тухай хууль Казахстан, Орос, Голланд Европын улсуудад байдаг гэнэ. Манай урд хөршид л гэхэд Ус бохирдуулагчийн гэсэн гуншинтай тусгайлсан хууль байхгүй ч усны төлбөрийг нэлээд өндөр авч, ус бохирдуулагчийн төлбөрөө дотор нь шингээсэн байдаг аж. Хэн ус бохирдуулагч вэ гэсэн асуултад Батбаяр дарга ус ашиглагч болгон бохирдуулагч хэмээн хариулав. Тиймээс ус ашиглаж байгаа бүхэн төлбөр төлнө гэсэн үг. Ус бохирдуулагчийн төлбөрийн дээд доод хэмжээг Засгийн газар тогтооно. Иргэд ус бохирдуулагчийн тухай хуулиар төлбөр төлөх эсэхийг УИХ шийдэх аж. Харин бусад ус бохирдуулагчийн төлбөрийг хуулинд заасны дагуу авах аж. Өөрөөр хэлбэл, бохирдуулж байгаа хэмжээ, усны найрлагаас шалтгаалж төлбөр төлөх гэнэ. Одоогийн тодорхойлж буйгаар усны физик, химийн шинж чанарт өөрчлөлт орсон л бол ус бохирдсон гэж үздэг байна.

Түүнчлэн бохир усны стандарт хүлцэх хэмжээг тогтоож, стандартад заасан хүлцэх хэмжээн дотор байх

юм бол төлбөр төлнө. Хэмжээнээс хэтэрсэн бол нөхөн төлбөр төлөх юм байна. Нөхөн төлбөрийн асуудал нь Эрүүгийн тухай хуулиар тусдаа зохицуулагдах юм. Үүнээс гадна Засгийн газар бохир ус шинжилдэг лабораториудыг байгуулах шаардлагатай болно. Өнөөдрийн байдлаар манайд хром зэрэг хүнд металл илрүүлэх чадалтай лаборатори улсын хэмжээнд 2-3-хан бий. Түүнчлэн Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн засварлах бөгөөд шаардлагатай бол дахин шинэчлэн барих хүртэл арга хэмжээ авах ёстой юм. Эдгээрт мэдээж их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд ус бохирдуулагчийн улсад төлсөн төлбөр эргээд усныхаа дээрх хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа зүйлүүдэд зарцуулагдана гэсэн үг. Тиймээс ч дэлхий дахинд ус усаа санхүүжүүлдэг гэдэг үг байдаг аж. Ус бохирдуулагчийн тухай хуулийг батлан, хэрэгжүүлснээр нэгдүгээрт, усны ашиглалт талд хэмнэлт гарна. Хоёрдугаарт, усны бохирдлын хэмжээ багасна. Гуравдугаарт, салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болно гэж Усны газрын орлогч дарга үзэж байна. Мөн тэрбээр Ус бохирдуулагчийн тухай хуулийг зургаан сар тутам авч үздэг, шинжлэх ухаан технологийн ололтыг дагадаг, Засгийн газрын тогтоолоор шинэчлэл хийдэг байх юм гэж онцолсон.

Хуулийн төслийг боловсруулж яамдад хүргэж санал авах шатандаа яваа юм билээ. Чуулган завсарлахаас өмнө амжиж батлуулах төлөвлөгөөтэй ажиллаж буй аж. ■

KHATAN TUUL

Pure Water



Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/
0.6 L /bottled/
1 L /bottled/
19 L /balloon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494



Богд хаант төрийн “ногоон бодлого”

Ө нөөдөр дэлхий даяар ногоон хөгжлийн талаар ярьцгааж, нийгэм, улс төр, эдийн засгийн томоохон ногоон өөрчлөлтүүдийн хөтөлбөрийг батлан гаргаж, улс орондоо, дэлхий нийтийн хүрээнд уралдан хэрэгжүүлцгээж байна. Ногоон хөгжлийн үзэл баримтлал нь, олон хүний хэлдгээр, XXI зууны улс төрийн гол сэдэв, мөн орчин үеийн соёл иргэншлийн хөгжлийн шинэ загвар болж байгаа мэт.

Харин монголчууд бид өөрийн түүх, соёл, амьдарч ирсэн уламжлалт арга хэлбэрээ эргэцүүлэн ухаарвал ногоон гээд байгаа энэ үзэл бодол нь бидний хувьд цоо шинэ зүйл бол огт биш, аль эртнээс л бидний амьдрах ухаанд (амьдралын философид) үргэлж оршин ирсэн зүйл мэт. Энэ талаар нэгэн сонирхолтой жишээг энд иш татья. Одоогоос 100 жилийн өмнөх Монголын хаант төрийн “ногоон бодлогын” талаар ингэж өгүүлсэн байна ...

Жавзандамба хутагтын дэргэд ноёд Монголын тухайн үеийн болон ирээдүйн нөхцөл байдлын талаар XIX – XX зууны зааг үеэр олон удаа хэлэлцэж байжээ. Харин 1909 онд болсон Богд болон ноёдын хуралдаанаар онцгой асуудал хэлэлцсэн байна. Учир нь Манжийн эрх баригчид, тухайлбал Манжийн Сангийн яамнаас Хүрээнд буй амбангаараа дамжуулан Монголын чуулган дарга, засаг ноёдоос дараах асуултуудад тодорхой хариулт авахыг шаардсан байв.

Эдгээр асуултууд нь:

А. Яагаад Монголын уудам газар нутаг цөөн хүн амтай байж хятад иргэдийг нүүлгэн оруулах, газар тариалан эрхлүүлэх боломжгүй хэмээн үзэж байгаа,

Б. Дээр дурьдсан нөхцөл байдалд Хаалган Хүрээ хоёрын хооронд төмөр зам байгуулах асуудал юугаар нөлөөлж байгаа, үүнд ямар хүндэтгэх үндэслэл байгаа,

В. Хятад иргэдийг суурьшуулах, газар тариалан эрхлэх, төмөр зам барих, авто машины зам тавих зэрэг нь үнэхээр Монголын нүүдэлчид болон мал аж ахуйг шахах үндэслэлтэй юм бол уул уурхайн үйлдвэр эрхлэх нь ямар шалтгааны улмаас бас шахах халгаатай гэж үзээд байгаа

талаар хоёрдмол утгагүй нэгэн хариулт өгөхийг Жавзандамба хутагт болон Монголын ноёдоос Манжийн хааны Засгийн газар шаардсан байжээ. Иймээс Богд болон ноёд эл асуудлыг нухацтай хэлэлцэж, маш болгоомжтой хариулт өгөх шаардлагатай болсон байна.

Удтал хэлэлцсэний дүнд Манжийн эрх баригчдад өмнө өгсөн хятад иргэдийг Монгол нутагт суурьшуулах болон газар тариалан эрхлэх боломжгүй гэсэн байр сууриа хамгаалж, бэлчээрийн мал аж ахуй нь өвлийн ууланд нүүдэллэх хэрэгцээтэй байдаг тул уул уурхай нь төрөл бүрийн муу үр дүн авчирна хэмээн үзэж байгаагаа Хутагт хийгээд ноёд илэрхийлжээ...

(“Монгол үндэстэн төр улсаа сэргээн тунхагласны 99 жилийн ойд” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд, 2010 оны арванхоёрдугаар сар)

Зөвхөн энэ баримтад үндэслэн Богд Жавзандамба хутагт болон Монголын төрийн эрх баригч ноёд чухам байгаль дэлхийдээ санаа зовсон учир хятад иргэдийг Монголд нүүлгэн ирүүлэх, уул уурхай эрхлэхэд татгалзав уу, эсвэл байгаль дэлхийн асуудлыг урдаа барьж шалтаглан Манж-Хятадын бодлогыг хааж байв уу гэдгийг шууд ялган хэлэхэд хэцүү. Гэхдээ аль ч хувилбараар нь авч үзсэн байгаль дэлхийн асуудал бол тэр үед ч гэсэн Монголын төрийн бодлогын чухал сэдэв байсан, мөн Манжийн төрийн хувьд ч монголчуудын энэ тайлбар нь үнэмшилтэй үндэслэл болж байсныг эндээс харж болно.

Түүхийн энэ жишээ нь өнөөгийн бидэнд нэгэн чухал сургамж, санааг хэлж өгч байна.

Хэрэв монголчууд бид байгаль орчноо хамгаалан хөгжих үндэсний бодлогоо цэгцтэй томьёолон, тууштай хэрэгжүүлж чадвал тэр нь гадаадын уул уурхайн компаниудын тулгалт, тэдний ард байгаа геополитикийн их дарамтыг даван гарах бидний хүчирхэг зэвсэг, тэдний хувьд бол дургүй байсан ч хүлээн дагахаас өөр аргагүй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “найрсаг” хаалт, зохицуулагч дүрэм байх болно. ■

XXI зуунд байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд

Дэлхийн улс орнуудын Засгийн газрын өмнө байгаль орчноо хайрлаж, хамгаалах явдал нь хамгийн тулгамдсан асуудал болоод буй билээ. Хөгжингүй аж үйлдвэржсэн орнуудад байгалийн нөөцийн ашиглалт болон хүлэмжийн хийн нөлөөлөл, тэдгээрийн сөрөг үр дагавар нь асар их юм. Гэхдээ хөгжиж буй орнуудын Засгийн газар байгаль орчныг

хамгаалах ажлыг маш бага төлөвлөж, шийдвэрлэж байгааг мэргэжилтнүүд шүүмжилдэг.

НҮБ-ын байгаль орчны хөтөлбөрийн 200 мэргэжилтэн, судлаачдын дунд энэ 100 жилд байгаль орчинд хамгийн их тулгамдаж болох асуудлаар санал асуулга явуулжээ. Санал асуулгын дүн хэрхэн гарсныг хүснэгтээс харна уу.





Made in Mongolia

Цорын ганц

Э.Зоригт

Манай сэтгүүл жуулчны улиралтай холбоотойгоор энэ дугаартаа аялал жуулчлалын салбарыг түлхүү хөндөж байгаа учраас Монголыг үзэхээр ирсэн жуулчдыг үндэсний үйлдвэрийн сайхан бэлэг дурсгалын зүйлтэй буцаахыг хүсэв. Сүүлийн үед олшироод байгаа бэлэг дурсгалын дэлгүүрүүдийн лангуундээр жуулчдын нүдийг хужирлах бараа цөөнгүй байдаг ч “Mongolian Economy” сэтгүүл арьс ширэн эдлэлийн үйлдвэрийг сонирхуулахыг зорилгоо. Тиймээс энэ чиглэлээр боломжийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийг нэлээд сурагласны эцэст “Only one” аж ахуй нэгжийг сонголоо. Эднийхийг аялал жуулчлалын болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын зарим хүн үйлдвэрлэлээ өргөжүүлэх, бараа бүтээгдэхүүнийхээ чанар, борлуулалтад нэлээд эрэл хайгуул хийж, санаачилгатай ажилладаг гэж онцлох юм билээ.

“Only one” “Бөмбөгөр” худалдааны төвийн урд талын орон сууцны 30-р байрны доод талын хоёр өрөөнд үйл ажиллагаа явуулдаг. Эхний өрөөний баруун урд буланд байрлуулсан ажлын ширээн дээр тус компанийн захирал, загвар зохион бүтээгч Т.Энхтөр шинээр ирсэн захиалагатайгаа танилцан сууна. Энэ өрөөнд мөн Италийн “Paff” брэндийн хамгийн сүүлийн үеийн хэд хэдэн оёдлын машин суурилуулжээ. Үйлдвэрийн түүхий эд болох арьс шир төрөл төрлөөрөө өрөөстэй. Түүнчлэн “Импортын барааг орлож чадах үндэсний шилдэг бүтээгдэхүүн” гэсэн хүндэт өргөмжлөл нүдэнд тусав. Харин нөгөө

өрөөнд нь ажил ид өрнөж байлаа. Уг өрөөнд эцсийн бүтээгдэхүүн бэлэн болгох бүхий л шат дамжлага явагддаг аж.

“Only one” арьс ширэн эдлэлийн үйлдвэрийг Та мэдэх үү гэж монголчуудаасаа асуувал мэдэх хүн тун цөөхөн байх вий. Гэтэл энэ жижигхэн үйлдвэр үйл ажиллагаагаа явуулаад 20 гаруй жил болж байгаа гэнэ. Өдий хүртэл оршин тогтнохдоо алдаатай оноотой, хүндрэл бэрхшээлтэй олон замыг туулсан тухайгаа Т.Энхтөр захирал өгүүлсэн. Зах зээл дөнгөж эхэлж байсан 1990-ээд оны эхээр Энхтөр, эр зориг, ирээдүйн тухай сайхан мөрөөдөлтэй үйл ажиллагаагаа эхэлсэн аж. Харин өдгөө энэ компани хайрт монгол орноо харийнханд сурталчлан таниулж байна. Жуулчид очсон орон бүрээсээ тухайн улсыг илэрхийлж чадахуйц бэлэг дурсгалын зүйлийг авах дуртай байдаг. Харин Монголыг төлөөлж чадахуйц тэр л зүйлсийг “Only one” арьс ширэн эдлэлийн үйлдвэр урладаг байна. Эднийх ширэн түлхүүрийн оосроос эхлээд бүс, цүнх, түрийвч гээд арьс ширээр хийж болох бүгдийг чанарын өндөр түвшинд хийдгээрээ ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэр, хувь хүн нийлсэн 60 гаруй үйлдвэрлэгчээс ялгарах онцлогтой гэнэ. Мөн хэрэглэгч бүрт цорын ганц загвартай бүтээгдэхүүнийг хийж өгөх нь тэдний зорилго хийгээд давуу тал ажээ. Энэ зорилгынхоо дагуу “Only one” гэдэг нэрийг сонгосон байна. Цорын ганц бүтээгдэхүүн хийлгэх захиалга ч цөөнгүй ирдэг гэнэ. Уг үйлдвэр нь бэлэг дурсгалын зүйлсээс гадна цагдаагийн бүрэн

» тоноглогдсон бүс, уурхайчдын нурууны хамгаалалт, бүхий л төрлийн ажлын болоод гоёлын цүнх зэргийг өнгө үзэмжтэй, чанартай хийдэг. Мөн зөвхөн танд зориулж цорын ганц бүтээгдэхүүнийг захиалгаар хийдэг гэхээр уншигч Та тэнгэрт тулсан үнэтэй биз гэж битгий бодоорой. Тун ч боломжийн үнэтэй бас чанартай гэсэн. Жишээлбэл, Та өөрт таалагдсан гоёлын загвартай цүнх хийлгэхэд 100 орчим мянган төгрөг болдог байна. Харин эдэлгээ сайтай ширэн бүс хийлгэхэд 20 орчим мянган төгрөг болдог аж. Бид гаднын үнэтэй бараа бүтээгдэхүүн хэрэглэж байхаар өөрсдийнхөө хийсэн бүтээгдэхүүнийг хэрэглэж заншвал сайнсан. Монголчууд үндэсний үйлдвэрээ мэдэхгүй байхад жуулчид “Only one”-ийг зорьж ирээд, зөвхөн өөртөө зориулсан цорын ганц “Made in Mongolia” гэсэн арьсан эдлэлийг хийлгээд сэтгэл хангалуун буцдаг гээд бод доо.

Бид жижиг гэлтгүй сайн бүтээгдэхүүн хийж байгаа үндэсний үйлдвэрийнхээ бараа бүтээгдэхүүнийг хэрэглэж, бусдад таниулан сурталчилж байж дэлхийд нэртэй үйлдвэрлэлтэй болох учиртай. Түүнчлэн бид “дэлгүүрийн лангуун дээрээс авсан бэлэг дурсгалын зүйлээрээ жишээ татан манайх арьсаар чанар муутай бараа хийх юмаа гэж голж, гоочилдог. Тэгвэл Энхтөр захирал дэлгүүрийн лангуун дээрх бэлэг дурсгалын зориулалттай бараагаар үндэсний үйлдвэрийн ахуйн хэрэглээний барааны чанарыг таньж мэдэх нь учир дутагдалтай. Тиймээс Монголын арьс ширэн эдлэл хийц загвар, чанар тааруу байдаг гэж ам дамжуулан ярихаа битгий урьтал болгоорой”. Эхлээд бараа бүтээгдэхүүнтэйгээ сайн танилцаж, учир начрыг нь ялгах хэрэгтэй” хэмээн учирлаж байна. Учир нь, дэлгүүрийн лангуун дээр өрөөстэй бэлэг дурсгалын зүйл бол бэлэг дурсгалын зориулалтаар хийж байгаа учраас чанарын асуудал нэг их яригдахгүй, харин гоё ганган чамин, шилэн хоргонд тавихад хээнцэр харагдах нь л чухал гэнэ. Харин хэтэвч, цүнх, гутал гээд ахуйн хэрэглээний арьсан эдлэлийг хамгийн сайн материалаар хийдэг учраас чанартай байдаг аж. Тэгэхээр угшигчдадаа зөвлөхөд арьс ширэн эдлэл авахыг хүсвэл үйлдвэрлэгчдэд өөрсдөд нь хандах нь илүү чанартай байх нь. Бид өөрсдөө үүнийг ялгаж салгаж ойлгоод зогсохгүй гаднынхан болон жуулчдад бэлэг дурсгалын бус арьс ширэн эдлэл авбал ингэх боломжтой гэж зөвлөж бас болох нь байна. Энэ ялгааг мэдэхгүй тохиолдолд монголчууд юу ч хийж чаддаггүй юм байна лээ гээд манай улсын нэр муугаар гарна шүү дээ. Худалдан авагч гэдэг чанаргүй барааг арван хүнд муулдаг бол чанартайг нь гуравхан хүнд мэдээллэдэг гэсэн судалгаа байдаг аж. Тиймээс энэ нь эрхэм хөтөч нарын үүрэг, ухамсраас ихээхэн шалтгаалах зүйл гэж үзэж ч болох.

“Only one” үйлдвэр нь Англи, Турк, ОХУ, БНХАУ зэрэг оронтой хамтын ажиллагаатай. Хэдийгээр уг үйлдвэр нь гаднын цөөнгүй оронд танигдсан хэдий ч эх орондоо олны танил биш байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлбэ, бараа бүтээгдэхүүнээ экспортлох, дотоодын зах зээлээ хангая гэхээр төр, засгийн дэмжлэг дутагддаг тухай Т.Энхтөр захирал ярьсан. Төр, засгаас дэмжлэг хүсэхээр нэлээд хүндрэл бэрхшээл тулгардаг байна. Энэ нь бодлого шийдвэр гаргагчдад тухайн салбарын талаар мэдлэг дутмаг

байдагтай холбоотой аж. Тухайлбал, холбогдох дарга нарт үйл ажиллагаагаа өргөжүүлэх талаар санал хүсэлтээ илэрхийлэх гэхээр өмнөөс нь учиргүй том үйлдвэр яриад бэрхшээгээд байдаг зовлонтой гэнэ. “Уг нь үйл ажиллагаагаа өргөтгөнө гэдэг том том үйлдвэр барихдаа гол нь биш. Харин жижиг, дунд үйлдвэрээ дэмжих, эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх л хамгийн чухал. Гэтэл манай дарга нар барилга байшин бодоод явчих жишээтэй. Зарим нь танайх ажлын байр ихээр бий болгох ёстой гэдэг мундаг шаардлага тавих нь ч бий. Гэтэл ажлын байр бий болгохын тулд тухайн байгууллага маань үйл ажиллагаагаа тогтвортой явуулах хэрэгтэй биз дээ. Тогтвортой ажиллахын тулд ажилчдынхаа цалинг тавьж чадахуйц мөн ашиг олохуйц ажиллаа ёстой. Гэтэл манайх том, жижиг ялгаагүй өндөр татвар ногдуулчихаар мөнөөх жижиг, дунд үйлдвэрүүд нь яаж ашигтай ажиллах билээ. Уг нь тэр их авсан татвараа эргээд энэ төрлийн байгууллагаа туслаж дэмжихэд зориулах учиртай. Гэтэл тэр тогтолцоо хаа байна” хэмээн Т.Энхтөр учирлалаа. Турк улсаар жишээ татахад л манайх шиг ийм арьс ширэн эдлэл хийдэг үйлдвэрлэлээ хөл дээрээ тогтол огт татвар ногдуулдаггүй байна. Тэгээд зогсохгүй тал бүрээс нь дэмжиж, зээлийг гар татахгүй өгдөг гэсэн. Гэтэл манайд үйлдвэр байгуулах гэсэн юм газар өгөөч гээд өргөдөл гаргахаар үгүй гэдэг хариулт өгөх жишээтэй.

Арьс ширэн эдлэлийн жижиг, дунд үйлдвэрийнхэн маань үйл ажиллагаагаа өргөтгөх үүднээс хоёр жилийн өмнөөс өөрсдийн гэсэн холбоог байгуулжээ. Уг холбооны гүйцэтгэх захирлаар Энхтөр ажилладаг байна. Тус холбоо нь одоогоор 65 гишүүнтэй бөгөөд бээлий, сурагчийн цүнх, хүүхдийн гуталны эрүүл ахуй зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх саналтайгаа шийдвэр гаргаж, бодлого тодорхойлогчдод хүргээд буй аж. Түүний ярианаас үзэхэд, төр нь түмнээ дэмжинэ гэдэгт тэд итгэлтэй байна.

Тус үйлдвэр байнгын 10-аад ажилтантай бөгөөд захиалга эрс нэмэгдэх үеэр гэрээт ажилчид нэмж авдаг байна.

“Only one” үйлдвэр нь бусад салбатай нягт уялдаа холбоотой ажиллахыг хичээдэг. Жишээлбэл, аялал жуулчлалын “Жуулчин” компанитай хамтран ажилладаг гэнэ. Энэ нь тухайн байгууллагыг гаднынханд сурталчлаад зогсохгүй эх орноо ч гэсэн сурталчлахад нь тус дэм болдог байна. Мөн цагдаа нарт буу, гав, бороохойн гэр зэргийг нь хамгийн найдвартай бөх бат хийж өгдөг. Бас Бээжингийн олимпийн үеэр тамирчдадаа бүс хийж өгсөн ажээ. Тэдний хийж өгсөн бүсийг зүүгээд нэг бус олимпын медалийг эх орондоо авчирсанд тус үйлдвэрийн ажилчид ихэд бэлгэшээдэг аж. Тэд ярихдаа “Бүс гэдэг монгол түмний хийморь сүлдийн бэлгэдэл билээ. Хэрвээ тамирчид маань гаднын бүс зүүгээд явсан бол түүрүүлээ ч үү, үгүй ч үү” хэмээн хошигнон хэллээ.

Монгол хүн монголоороо гоёно оо гэж. Хэдийгээр үйлдвэрийн сурвалжлага ч гэлээ Ш. Гүрбазарын “Би Монголоороо гоёдог” гэдэг монгол хүний омогшлыг бадраах сайхан үгээр төгсгөлөө хиймээр санагдчихлаа. Тиймээ би, чи, та, бүгдээрээ захиалгын дагуу цорын ганцыг ч хийж өгөх боломжтой монгол брэндээрээ гоёцгооё. ■

Хоромд дамжих мэдээлэл буюу “жиргээ”-ний ноёрхол


Ж.Тэргүүн

Хэрэглэгчийнхээ тоог 50 саяд хүргэхийн тулд радиод 38 жил, телевизэд 13 жил, интернэтэд дөрвөн жилийн хугацаа шаардагдсан бол нийгмийн сүлжээний цахим хуудас Фэйсбүүкесөн сарын дотор 100 сая хүн өөртөө нэгтгэсэн нь шинэ мянганы дуулиант “нээлт” болсон юм.

2011 оны нэгдүгээр сарын байдлаар уг цахим хуудасны хэрэглэгчийн тоо 600 саяд хүрсэн бөгөөд хэрэв Фэйсбүүк улс байсан бол хүн амын тоогоороо БНХАУ, Энэтхэг, АНУ-ын дараа дөрөвдүгээрт жагсах байв. Гэхдээ фэйсбүүктэй харьцуулбал дээрх гурван орны аль нь ч долоохон жилийн дотор ийм өнөр болж чадаагүй гэдгийг онцлох нь зүйтэй.

2006 оны долдугаар сарын 15-нд мэндэлсэн Твиттер цахим хуудас тогтмол хэрэглэгчдийн тоо энэ оны гуравдугаар сарын байдлаар 200 саяд хүрсэн нь фэйсбүүк-ийн ард гишгэх үзүүлэлт. Сонирхолтой нь Твиттер-ийг хэрэглэгчдийн 80 хувь нь гар утаснаасаа “жиргэдэг”. Мэдээллийн хэмээн тодорхойлсон XXI зууны түүчээ нь мэйл, мэссэнжэр, сайтууд байх болно гэж төсөөлж байсан үе ард хоцорч, нийгмийн харилцааны цахим хуудсуудын ноёрхлын эрин иржээ.

Хүмүүс яагаад зурагт, радио, сонин, сэтгүүлээс фэйсбүүк, твиттер тэргүүтэй нийгмийн харилцааны сайтуудыг илүүд үзэх болов. Твиттерийг үүсгэн байгуулагчдын нэг Биз Стоуны хэлж буйгаар нийгмийн харилцааны сайтуудыг ашиглан



мэдээллийг хамгийн түргэн шуурхай солилцож, ийн мэдээлэл дамжуулах хэрэгсэл нь хүмүүст хамгийн ойр гар утас болсон учраас олон хүний сонирхлыг татаж байна.

Бид өдөр тутмын сонины мэдээг нэг өдрийн дараа хүртэж, телевизийнхийг 19.00 цагийн мэдээ эхэлтэл, сайтынхыг үйл явдлын гэрч ажлын компьютер дээрээ ирэх хүртэл хүлээдэг бол Твиттер, Фэйсбүүкээр мэдээлэл дамжуулах нь хэдхэн секундын ажил буюу таны хуруу гар утасны товчлуур дээр хэр хурдан гүйхээс шалтгаалан богино хугацаанд авах боломжтой юм. Гэвч нийгмийн харилцааны дээрх цахим хуудсууд зөвхөн мэдээлэл дамжуулах, солилцох үндсэн үүргээсээ хэдийнэ хальсан.

Нэгэнт ийм олон хүн нэг дор цугларч, дэлхийн хаанаас ч мэдээлэл солилцох боломжтой

болсон нь томоохон компаниудын маркетингийн ажилчдын гол өгөөш болж байна. Телевизээр хэчнээн сая доллар зарцуулж реклам явуулснаас фэйсбүүк, твиттер ашиглан телевизээс хэдэн сая илүү хүнд, хамгийн хурдан бас хамгийн хямд зардлаар түгээх боломжтой нь бизнесийн гол түлхүүр болов.

Твиттерийн “жиргээ”, фэйсбүүкээс юугаараа ялгаатай вэ?

“Форбес” сэтгүүлээс саяхан гаргасан нийгмийн харилцааны цахим хуудсуудын статистик үзүүлэлтээр Монгол фэйсбүүкт хамгийн хурдацтай нэгдэж байгаа улсуудын тоонд багтсан бөгөөд өдгөө 177.420 монгол хүн фэйсбүүкийг тогтмол ашиглаж байна. Харин твиттерээр “жиргэх” үзүүлэлтээр монгол базаахгүй үнэлгээ авсан. Монголын хүн

Та ямар ном уншиж байна вэ?


Д.Болор

“Мобиком” корпорацийн ерөнхий захирал/:

Д.Болор захирал “Маркетинг, онол, хэрэглээ” номыг уншиж байгаа гэлээ.

“Интер ном” дэлгүүрийн 2010 оны эдийн засаг, бизнесийн чиглэлийн шилдэг бүтээлээр шалгарсан “Маркетинг, онол, хэрэглээ” бүтээлийг ШУТИС-ийн КТМС-ийн багш Д.Баярмаа бичсэн байна. Энэхүү номонд маркетингийн мөн чанарын тухай ойлголтоос эхлүүлэн удирдлагын үндсэн үзэл баримтлал, маркетингийн

төлөвлөлт, мэдээллийн систем, хэрэглэгчийн болон байгууллагын зах зээл, худалдан авагчдын зан төлөв гэх мэт онол практикийн асуудлыг тусгажээ. Олон улсын нэртэй брэнд төдийгүй, дотоодын бизнесийн байгууллагуудын жишээнээс оруулж, номын төгсгөлд зөвлөмжүүдийг хавсаргасан байна.



И.Сэр-Од

“Монголын Бизнесийн зөвлөлийн дэд захирал/:

И.Сэр-Од нь Энэтхэгийн нийгэм улс төрийн нэрт зүтгэлтэн Ж.Неругийн “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” номыг амтархан уншиж байгаа аж.

“Мон Судар” хэвлэлийн газраас гаргасан гурван боть зохиолыг Ж.Неру нь шоронд байхдаа охиндоо тайбарлах үүднээс ертөнцийн түүхийг МЭӨ үеэс дэс дараатай бичжээ. Тэрээр охин Индира Ганди-д дэлхийн түүхийн гол үйл явдлуудыг захидал хэлбэрээр хүргэсэн байна. Жишээлбэл, Италийн Ром хотноо ийм үйл явдал болж байхад, Исламын шашин үүсэж, мөн Монгол оронд яг

тухайн түүхийн тэр үед ямар үйл явдал өрнөж байсныг зэрэгцүүлэн харуулснаараа онцлогтой.

Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн удирдагчдын нэг Ж.Неру нь Ази тивийн энх амгалан байдлын төлөө ихээхэн хүчин зүтгэл гаргасан. Тэрбээр мөн боолчлол, фашизмын эсрэг тууштай тэмцэхийн зэрэгцээ эрдэмтэн, түүхч, зохиолч, философич хүн байв.



О.Батболд

“Герман Монголын бизнес эрхлэгчдийн холбооны менежер/:

Эрих Фоллат, Александер Юунг нарын “Шинэ хүйтэн дайн” (“Der neue Kalte Krieg”) номыг уншиж байгаа. Өнөөдөр байгалийн баялгийн төлөөх ил болон далд тэмцэл дэлхийн аль ч өнцөг буланд явагдаж байна. Энэхүү тэмцлийн учир шалтгааныг газар дээр нь очиж судалсан Германы “Шпийгель” (“Spiegel”) сэтгүүлийн олон улсын харилцааны чиглэлээр мэргэшсэн хоёр сэтгүүлч энэхүү номыг нэгтгэн бичсэн юм.

Мөн дэлхийн газрын зураг дээр байгалийн баялгийг, мөн хаана ямар ил болон далд тэмцэл болж байгааг ойлгомжтойгоор зурж харуулсан нь алдарт “Шпийгель” сэтгүүлийн сайн арга барилыг харуулж байна. Дэлхийн бусад орон баялгаа яаж ашигласан болон одоо хэрхэн ашиглаж байгааг өгүүлсэн ба эдгээрээс аль нь хөгжилд хүрсэн, аль нь одоог хүртэл дайн байлдаантай, ядуу байгааг маш энгийнээр ойлгомжтойгоор гаргаж ирсэн. Үүнээс гадна хэн нь хэнийгээ байгалийн баялгийн улмаас

хараат болгож байгаа тухай бичсэн нь сонирхол татаж байна. Манай улс ч гэсэн одоо нефтийн бүтээгдэхүүнээрээ Оросын хараанд байгааг бид яг одоо нэмэгдэж буй дизель түлшний үнээр бэлээхэн харж байна. Тиймээс бусад орон ийм замаас зөв бодлого баримтлан хэрхэн ухаалгаар гарч чадсан, аль орнууд нь насан туршдаа хараат болсон талаар мэдэж болох юм. Номын төгсгөлд дэлхийн эрчим хүчний хэрэглээг нөхөн сэргээгдэх эрчим хүчээр бий болгохыг олон учир шалтгаанаар тайлбарласан зохиол юм. Энэ номыг заавал уншихыг О.Батболд уриалаад, “Бид дэлхийн сайн муу туршлагатай танилцсаны үндсэн дээр л байгалийн баялгаа зөв бодлого боловсруулан ашиглаж эхлэх ёстой гэж үзэж байна” хэмээн тэмдэглэв. ■



Бизнес эрхлэгч хүний хувьд хамгийн чухал 20 асуулт

1. Таны саналын үнэ цэнэ юунд оршиж байна вэ?



Хэрэв Та санал болгож буй бараагаа яагаад хүмүүст хэрэгтэйг гурван өгүүлбэрээр тайлбарлаж чадахгүй бол үнэ цэнэгүй гэсэн үг. Үүнээс үүдээд танд бизнес байхгүй байна гэж ойгож болно.

2. Таны бараа эрэлт хэрэгцээтэй байх уу?



“Сайнфелд” хэмээх цуврал киноны нэгэн дүр баялагт хүргэх зам бол хөхний даруулга хийх явдал гээд ойлгогчихсон байдаг. Тэр өөрийнхөө үйлдвэрлэх гэж буй барааг эрэлт хэрэгцээтэй байх эсэх талаар ямар ч судалгаа хийгээгүй юм. Та ч гэсэн судалгаа, дүгнэлт хийж, мэдээлэл цуглуулахгүйгээр эрэлт хэрэгцээг бий болгоно гэж байхгүй шүү. Битгий л эрэгтэй хүнд тохирох хөхний даруулга хийх гэж зүтгээрэй дээ.

3. Өрсөлдөгчөөсөө юугаараа ялгарч чадах вэ?



“Starbucks” дөрвөн долларын үнэтэй кофены

чанамал хэрэгтэй гэж хүмүүст итгүүлж чадсан бол “Louis Vuitton” жинсэн цүнхний төлөө 1500 доллар үрэх шаардлагатай юм шиг сэтгэгдлийг худалдан авагчдынхаа толгойд суулгаж дөнгөдөг. Энэ бол зүгээр нэг маркетинг биш. Хэрэв Та бизнесээ өргөжүүлж, амжилт олохыг хүсэж байвал бусдаас ялгарах зүйлийг хий. Амжилтад хүрсэн брэндүүд бүгд л ямар нэгэн юмаар содон байдаг шүү дээ. Жишээ нь “Wal-Mart” хямд үнээрээ, “Apple” өвөрмөц загвараараа, “FedEx” хэрэглэхэд хялбар байдлаараа ч юм уу ялгарч байдаг. Товчхондоо, бүтээгдэхүүнийхээ давуу талыг олоод, үүгээрээ л дайралт хий.

4. Таны бизнес өргөжиж байна уу?



Хуримтлуулсан жаахан хөрөнгө, төсөөлшгүй их баялаг хоёрын хооронд хамрах цар хүрээний л ялгаа байдаг. Таны үйлдвэрлэл өргөжих тусам аль болох бага зарлага гарах нь сайн талтай. Жишээ нь программ хангамжийг аваад үзье л дээ. “Microsoft” код боловсруулалтад ганц удаа хөрөнгө мөнгө гаргасан байхад л дараа дараагийн “Windows”-ын шинэчлэгдсэн хувилбарын өртөг хямд байна. Гэтэл зарим бизнес цар хүрээгээ тэлэхэд хэцүү байдаг. Ялангуяа үйлчилгээний салбарт орлого нэмэгдэх тусам хүч хэрэгтэй болж, зарлага ч дагаад өсөх жишээтэй.

5. Та хийж буй ажилдаа хэр үнэнч вэ?



Та гэр бүлтэй, хоёр хүүхэдтэй гэж бодъё. Гэтэл эхэлсэн ажлаа өргөжүүлж, хөгжүүлэхийн тулд танд долоо хоногт 100 цагийг ажилдаа зориулах хэрэг гарч мэднэ. Ийм байдлаар бүтэн хоёр жил зүтгэж чадах уу? Бүхнийг захирахын тулд та бүхнээ золиослоход ч бэлэн байх хэрэгтэй шүү дээ. Мэдээж бизнесээ хөл ▶

► дээрээ зогсох хүртэл нь бол гарцаагүй.

6. Таны хүч юунд оршиж байна вэ?



“Google” асар хүчтэй хайлтын цахим хуудсыг зохион бүтээсэн бол “Steinway” модоор гайхамшигийг туурвиж, “Cisco” ирээдүйтэй төслүүдийг “үнэртэж” олоод худалдаж авдаг. Та зөвхөн барьж авсан зүйлээ л тууштай хийвэл бүх зүйл болно гэдэгт итгээрэй. Энэ нь хэнд ч ойлгомжтой юм шиг санагдахаар зүйл. Гэхдээ олон бизнесмэн энэ л “шалгалт”-ад унадаг юм шүү. Хорвоо ертөнц боломжоор дүүрэн, гагцхүү өөртөө тохирохыг нь л шүүрч авах хэрэгтэй.

7. Таны сул тал юу вэ?



Та юуг сайн, юуг муу хийж байна вэ гэдгээ мэдэх хэрэгтэй. Тухайлбал, “Apple” компани “iPhone” утсандаа зориулан камер үйлдвэрлэдэггүй, харин гаднаас худалдаж авдаг юм. Их орлого олдог онлайн дэлгүүрүүд өөр байгууллагаар цахим хуудасны загвараа гаргуулж, өөр компанийн төлбөрийн системийг ашиглах жишээтэй. Бүхнийг өөрөө хийж, ашгаа хэнтэй ч хуваалцахгүй авна гэж хамаг хүчээ шавхах нь амиа хорлолтоос өөрцгүй. Өөрийнхөө чаддаг зүйлийг л хий, тэгээд найдвартай хамтрагчдаа ол, бусдыг нь тэд хийг!

8. Таны үйлчлүүлэгч хэдийг төлөх бол?




Яагаад хүмүүс “Vanish”-ийг ердийн цайруулагчаас хоёр дахин илүү мөнгө төлөн байж худалдан авдаг вэ? Хэрэглэгчийн төлж чадах хамгийн дээд үнэтэй дүйцэхүйц чанартай зүйл үйлдвэрлэнэ гэдэг ашиг олох гол үүр уурхай юм шүү. Бараандаа яг тохирох үнийг тогтоохын тулд үйлдвэрлэгчид зөвлөх нарт өндөр хөлс төлдгийг Та мэдэх үү?

9. Хэрэглэгчид тань хэр их эрх мэдэлтэй вэ?



Танай хотод цонх угаах үйлчилгээ эрхэлдэг ганцхан компани байлаа гэж бодъё. Гэтэл та цонх угаах төхөөрөмжийн резинэн хавчаар үйлдвэрлэж тэр компанид нийлүүлдэг бол юу болох вэ? Мэдээж худалдан авагч тань “Big Sale” шаардаад эхэлбэл бизнес тань сүйрнэ шүү дээ. Тиймээс аль болох эртхэн олон үйлчлүүлэгч, худалдан авагчтай болоорой. Зах зээлээ томруулах тал дээр анхаар.

10. Тэгвэл танай ханган нийлүүлэгчид хэр их эрх мэдэлтэй вэ?



Та олон худалдан авагчтай байх тусам сайн гэсэн бол ханган нийлүүлэгчийн тал дээр яг эсрэгээрээ. Учир нь танай бизнест түүхий эд нийлүүлэгч нь цөөхөн байх тусмаа илүү эрх мэдэлтэй байх болно. Царс модоор цагны тавиур хийх бол сайхан санаа, гэхдээ тэр царс модыг бэлтгэж нийлүүлдэг ганцхан л компани, эсвэл хувь хүн байвал яах вэ? Хэрэгцээтэй зүйлээ авахын тулд Та мэдээж тэр хүний хэлсэн бүхнийг л өгөх хэрэг гарна. Гэхдээ нөгөө талаас хэтэрхий хямд үнээр түүхий эд нийлүүлж буй хүмүүсээс сэрэмжлэх хэрэгтэй. Учир нь тэд чанарын тал дээр анхаарахгүй байж мэднэ.

Үргэлжлэл бий.
 (“Forbes” сэтгүүлээс орчуулав) ■

Валютын зах

Дотоодын бэлэн бус валютын зах

Валют	Код	6/15		5/16		Өөрчлөлт (авах ханш)
		авах	зарах	авах	зарах	
Доллар	USDMNT	1,252	1,264	1,221	1,235	2.5%
Евро	EURMNT	1,800	1,835	1,711	1,745	5.2%
Иен	JPYMNT	15.3	15.78	15	15.45	2.0%
Юань	CNYMNT	193.5	198	187.7	192	3.1%
Фунт	GBPMNT	2,017	2,106	1,947	2,037	3.6%
Рубль	RUBMNT	44.5	45.9	42.9	44.4	3.7%
Вон	KRWMNT	1.14	1.19	1.1	1.15	3.6%

Дотоодын бэлэн валютын зах

Валют	Код	6/15		5/16		Өөрчлөлт (авах ханш)
		авах	зарах	авах	зарах	
Доллар	USDMNT	1,258.00	1,262.00	1,225.00	1,231.00	2.7%
Евро	EURMNT	1,817.00	1,823.00	1,730.00	1,755.00	5.0%
Иен	JPYMNT	15.70	15.75	15.20	15.40	3.3%
Юань	CNYMNT	196.50	197.50	189.50	190.70	3.7%
Фунт	GBPMNT	2,050.00	2,070.00	1,960.00	2,000.00	4.6%
Рубль	RUBMNT	45.50	46.00	44.20	44.60	2.9%
Вон	K R W - MNT	1.20	1.22	1.16	1.19	3.4%

Монголбанкнаас зарласан ханш

Валют	6/15	5/16	Өөрчлөлт
Доллар	1,255.33	1,219.85	2.91%
Евро	1,814.77	1,744.75	4.0%
Иен	15.62	15.15	3.1%
Юань	193.78	187.76	3.21%
Фунт	2,061.13	1,987.93	3.7%
Рубль	45.03	43.86	2.7%
Вон	1.16	1.12	3.6%

Олон улсын валютын зах

Суурь валют	6/15		5/16		Өөрчлөлт
1 EUR =	1.4119	USD	1.413	USD	-0.1%
1 USD =	80.65	JPY	80.94	JPY	-0.4%
1 GBP =	1.6157	USD	1.6204	USD	-0.3%
1 EUR =	113.78	JPY	114.52	JPY	-0.6%
1 USD =	6.48	CNY	6.5	CNY	-0.31%
1 USD =	28.19	RUB	28.12	RUB	0.2%
1 USD =	1089.72	KRW	1091.18	KRW	-0.1%

М нг ний зах

UBIBOR 0.71 хувиар өсөв


UBIBOR тавдугаар сарын 15-наас зургадугаар сарын 15-ны хооронд 0.71 хувиар өссөн нь арилжааны банкуудын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгө буурсантай холбоотой. Энэ хугацаанд арилжааны банкууд 300 гаруй тэрбум төгрөгийн зээл нэмж гаргасан бөгөөд ингэхийн тулд Төвбанкны үнэт цаасанд байршуулсан хөрөнгөө 200 тэрбумаар багасгасан байна. Түүнээс гадна тавдугаар сард гаргасан Засгийн газрын 72 тэрбумын бондноос зарим банк худалдан авсан нь системийн хувьд төгрөгийн үлдэгдлийг нь бууруулжээ. Дээр дурдсан шалтгаануудын улмаас арилжааны банкууд банк хоорондын захаас зээл авах хүүгээ нэмэгдүүлсэн байна.

Гадаад худалдааны алдагдал 7.4 дахин нэмэгдлээ

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны зургадугаар сарын 15-ны байдлаар 4.1 тэрбум ам.доллараас давсан нь өмнөх оны мөн үеэс 82.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлт аж. Энэ хугацаанд гадаад худалдааны алдагдал жилийн өмнөхөөсөө 7.4 дахин өсөж, 566.6 сая ам.долларт хүрчээ. Эрдэс баялгийн салбар хөгжиж буйтай холбоотойгоор хүнд машин механизм, тоног төхөөрөмж, түлш, шатахууны импортын хэмжээ огцом нэмэгдсэн нь худалдааны алдагдал өсөхөд голчлон нөлөөлж буй. “Бид алдагдал гэхээсээ илүү үүний үр дүнд үйлдвэрлэл хэр их эрчимжиж байгааг харах ёстой. Учир нь, тоног төхөөрөмж оруулж ирснээр үйлдвэрлэлийг сэргээж, ажлын байр бий болгож, эдийн засагт эергээр нөлөөлдөг юм” хэмээн Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал С.Жавхланбаатар “Mongolian Economy” сэтгүүлд ярилцлага өгөхдөө тайлбарласан билээ. Дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өндөр байгаагийн зэрэгцээ Монголд ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом нэмэгдэж байгаа боловч сүүлийн үед гадаад валютын ханш өсөх хандлагатай болоод байна. Өнгөрсөн тавдугаар сарын 16-наас зургадугаар сарын 15-ны хооронд Монголбанкнаас зарласан ам.долларын ханш 2.9 хувиар, юанийнх 3.2 хувиар чангарсан байгааг хүснэгтээс харна уу. Гадаад худалдааны алдагдал нэмэгдэж байгаа нь ханшийн хэлбэлзэлд тодорхой хэмжээгээр нөлөөлж байх талтайг зарим мэргэжилтэн тайлбарлаж байгаа юм.



UBIBOR (1 хоногтой)



» Бондын зах

Улс	Валют	Хугацаа	Купон	Өгөөж	Өгөөж	
			6/15		5/16	
Монгол	Төгрөг	3 сар	-	11.86	-	11.86
АНУ	Доллар	3 сар	-	0.05	-	0.02
	Доллар	2 жил	0.75	0.43	0.75	0.52
	Доллар	5 жил	2.12	1.67	2.12	1.82
	Доллар	10 жил	3.37	3.08	3.37	3.16
Герман	Евро	3 сар	-	1.09	-	0.92
	Евро	2 жил	1.25	1.58	1.25	1.80
	Евро	5 жил	2.50	2.21	2.50	2.44
	Евро	10 жил	3.25	3.00	3.25	3.09
Англи	Фунт	6 сар	-	0.70	-	0.84
	Фунт	2 жил	3.25	0.84	3.25	0.99
	Фунт	5 жил	5.00	2.05	5.00	2.04
	Фунт	10 жил	4.50	3.29	4.50	3.36
Япон	Иен	6 сар	-	0.11	-	0.12
	Иен	2 жил	0.30	0.18	0.30	0.19
	Иен	5 жил	0.70	0.45	0.70	0.44
	Иен	10 жил	1.30	1.17	1.30	1.15

Хувьцааны зах

Топ 20 индекс 5.3 хувиар буурчээ

2010 онд 138 хувиар өсөж, рекорд тогтоож байсан Топ 20 индекс хаврын эхэн сараас унаж эхэлсэн билээ. Өнгөрсөн тавдугаар сарын 16-наас зургадугаар сарын 15-ны хооронд уг индекс 5.3 хувиар доошилж, 19430.3 нэгж болоход “Тавантолгой”-н хувьцааны ханш 11.4, “Шарын гол”-ынх 17.6 хувиар хямдарсан нь голчлон нөлөөлжээ.

Дашрамд сонирхуулахад, Монголын хөрөнгийн биржид 335 компани бүртгэлтэй байдаг боловч 30 томоохон компанийн үнэлгээ тус биржийн нийт зах зээлийн үнэлгээний 94.1 хувийг бий болгодог аж.

Топ 20



Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Топ 20 компанийн хувьцааны ханш

Нэр	Код	VI.15	Нэг сарын өөрчлөлт (хувиар)	Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)
Тавантолгой	TTL	700,000	-11.4%	368.66
Багануур	BAN	18,000	-1.6%	377.57
Шивээ-Овоо	SHV	24,050	0.2%	322.73
АПУ	APU	2,850	-4.4%	211.72
Шарын гол	SHG	14,000	-17.6%	101.24
Монголын цахилгаан холбоо	MCH	2,700	-7.8%	69.85
Би ди сөк	BDS	4,100	2.5%	45.1
Говь	GOV	5,280	-0.4%	41.19
Могойн гол	BDL	44,000	7.3%	36.5
Адуун чулуун	ADL	10,000	6.5%	31.51
Монголиа девелопмент ресорсез	MDR	1,850	-2.6%	25.44
Хөх ган	HGN	192	2.7%	19.45
Ремикон	RMC	120	1.7%	15.32
Улаанбаатар зочид буудал	ULN	42,000	-8.7%	14.08
Улсын их дэлгүүр	UID	400	14.3%	14.72
Баянгол зочид буудал	BNG	31,500	26.5%	13.33
Женко тур бюро	JTB	90	-4.3%	9
Махимпэкс	MMX	2,350	51.1%	8.93
Ээрмэл	EER	2,300	35.2%	8
Дархан нэхий	NEH	6,000	-14.3%	6.63

Market Data

FTSE 100



Nikkei 225



DAX



Shanghai



RTS



Kospi



Hang Seng



Dow Jones



ММС Баруун наран уурхайд ажиллана

Хонконгийн хөрөнгийн биржээс өнгөрсөн аравдугаар сард 750 сая ам.доллар босгосон “Mongolian mining corp” (ММС буюу бидний мэдэхээр “Энержи ресурс”) Баруун наран нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулах гэж байна. Уг ордыг өөрийн болгохын тулд ММС нь 464.5 сая ам.доллараар “Kerry Holdings”-ийн салбар компани болох QGX-тай гэрээ хийжээ. Ингэхдээ 379.5 сая ам.долларыг бэлнээр, 85 сая ам.долларыг хувьцаанд хөрвөх эрх бүхий бондоор худалдан авах тухай “Bloomberg” мэдээлэв. “Kerry Holdings” нь QGX-ийн 90 хувийг эзэмшдэг бол үлдсэн 10 хувь ба хяналтын багц нь ММС-ийн мэдэлд байдаг аж.

“Ихээхэн хэмжээний коксжих нүүрсний нөөцтэй Баруун наран уурхайг эзэмшсэнээр тус групп бүтээгдэхүүнээ төрөлжүүлэн орлогын үүсвэрээ нэмэгдүүлнэ” хэмээн ММС-ийн удирдлага мэдэгдсэн байна. Түүнчлэн олборлолт болон тээвэрлэлтийн дэд бүтцээ хамтран ашиглах давуу талтай тухай тайлан дээрээ дурджээ.


Хонконгийн хөрөнгийн биржид хувьцаагаа арилждаг ММС-ийн үнэт цаасны ханш өнгөрсөн тавдугаар сарын 16-наас зургадугаар сарын 15-ны хооронд 0.4 хувиар өсөж, 1.21 ам.доллараар үнэлэгдэж буй. Ухаа худагт үйл ажиллагаа явуулдаг тус компанийн зах зээлийн нийт үнэлгээ эдүгээ 4.6 тэрбум ам.долларт хүрээд байгаа билээ.

Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хувьцааны ханш

Нэр	Бирж	Код	V.16 (ам. доллар)	Нэг сарын өөрчлөлт (хувиар)	Зах зээлийн үнэлгээ (сая ам.доллар)
Ivanhoe Mines	NYSE, TSX	IVN	22.63	-2.2%	16,356.9
Mongolian Mining Corp	HKEx	975	1.21	0.4%	4,613.1
Centerra Gold	TSX	CG	14.97	-23.3%	4,538.1
SouthGobi Energy Resources	TSX, HKEx	SGQ, 1878	10.36	-10.2%	2,018.7
Mongolia Energy Corp	HKEx	276	0.16	-26.5%	1,402.3
Petro Matad	LSE	MATD	2.29	-4.4%	504.6
Aspire Mining Limited	ASX	AKM	0.66	-12.5%	451.9
Hunnu Coal	ASX	HUN	1.46	-6.8%	265.8
Entrite Gold	TSX, AMEX	ETG, EGI	20.7	-12.5%	280.9
Erdene Resource Development	TSX	ERD	0.98	-8.6%	115.5
Xanadu Mines	ASX	XAM	0.44	-17.6%	74.0
Haranga Resources	ASX	HAR	0.3	-12.5%	55.2
Khan Resources	TSX	KRI	0.31	0.0%	18.7

► Таваарын зах


Хонгон цагаан (тн/ам.доллар)



Цайр (тн/ам.доллар)




Хар тугалга (тн/ам.доллар)




Никель (тн/ам.доллар)




Газрын тос (баррель/ам.доллар)




Байгалийн хий (MMBtu/ам.доллар)



Алт (унци/ам.доллар)



Монгол (унци/ам.доллар)



Зэсийн үнэ өндөр хэвээр

Лондоны металлын бирж дэх тонн зэсийн үнэ өнгөрсөн тавдугаар сарын 16-наас зургадугаар сарын 15-ны хооронд таван хувиар өсөж, 9147 ам.долларт хүрсэн байна. “Нөхцөл байдал ийм хүнд байхад металлын ханш өндөр хэвээр байгаа нь гайхалтай” хэмээн “Olympus Futures” компанийн ахлах шинжээч Чарльз Недосс онцолсныг <http://www.metaltorg.ru> цахим хуудсанд мэдээлжээ.

Өнгөрсөндөрөвдүгээр сард манай урд хөршийн зэсийн импорт жилийн өмнөхөөсөө 21 хувиар, тавдугаар сард бүр 36 хувиар огцом буурсан. Дэлхийн зах зээл дэх үнэ хэт өндөр байгаагаас хятадууд металл худалдан авахаасаа илүү хуримтлуулсан нөөцөөсөө ашиглаж эхэлснийг


мэргэжилтнүүд тайлбарласан байна. Үүний хажуугаар Хятадын Төвбанк инфляцитай тэмцэх зорилгоор мөнгөний бодлогоо үе шаттайгаар чангаруулж байгаа нь зэсийн үнэд сөргөөр нөлөөлнө хэмээн шинжээчид таамаглаж байв. Дэлхийн нийт зэсийн хэрэглээ 18 орчим сая тонн байдгийн 30 хувийг хятадууд дангаараа хэрэглэдэг учраас урд хөрш яах аргагүй зах зээлд нөлөөлөхүйц тоглогч юм. Түүнчлэн Европын өрийн хямрал, Грекийн санхүүгийн асуудал хүнд байгаа нь металлын зах зээлд муу үр дагавартай зарим мэргэжилтэн сануулж буй. Гэвч энэ бүхнийг үл харгалзан Лондоны металлын бирж дэх зэсийн үнэ өндөр хэвээр байгаа

нь нийлүүлэлтийн хомсдолтой холбоотой байж мэдэх аж.

Чилийн зэсийн уурхайнуудын хүдрийн чанар муудаж, үйлдвэрлэлийн хэмжээ багасаж байгаа бөгөөд “Рио Тинто”-гийн энэ жил гаргах зэсийн хэмжээ өнгөрсөн оныхоос доогуур байх тухай мэдээлэл цацагдсан билээ. Уурхайчид хурдан хугацаанд хангалттай үйлдвэрлэл явуулж чадахгүй байгаагаас дэлхий нийтэд зэсийн хомсдол үүснэ гэж өнгөрсөн зургадугаар сарын эхээр “Goldman Sachs Group” мэдэгдсэн аж. Тэгвэл “Barclays Capital”-ын шинжээчид “улаан металл”-ын хомсдол энэ онд жилийн өмнөхөөсөө хоёр дахин өсөж, 822 мянган тонн хүрэхийг анхааруулсан удаатай. Зэсийн хомсдол нүүрлэх аюул байгаа учраас үнэ өндөр хэвээр байна хэмээн зарим шинжээч дүгнэж буй.

Дэлхийн зах зээл дэх зэсийн ханш өндөр байгаа учир уурхайчид, үйлдвэрлэгчид нэлээд шамдуу ажиллаж байгаа юм. Чилийн “Коделко” ирэх таван жилд шинэ уурхайнууд ашиглалтад оруулахын тулд 15 тэрбум ам.доллар зарцуулна хэмээн мэдэгдсэн бол монголчууд 2012 он гэхэд Оюутолгойн уурхайгаа ажиллуулчих гээд үзэж байх жишээтэй. Харин Хятадын цэвэр зэсийн үйлдвэрлэл өнгөрсөн тавдугаар сард 10 хувиар нэмэгдэж, 439 мянган тонн хүрчээ. “Түүхий эд хангалттай, бүтээгдэхүүний үнэ өндөр байна, тэгэхээр зэс хайлуулах үйлдвэрүүд бүх хүчээ дайчлах нь лавтай шүү дээ” хэмээн Хятадын трейдер ярьсныг <http://www.metaltorg.ru> цахим хуудсанд онцолсон байна. Үүний хажуугаар энэ оны хоёрдугаар хагаст хятадууд жилдээ нэг сая тонн цэвэр зэс гаргах хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад оруулах төлөвтэй буй аж. “Ойрын саруудад Хятадын зэсийн эрэлт хэрэгцээ нэмэгдэнэ гэж үзэж байгаа” хэмээн “Bohai Futures” компанийн шинжээч Ю Хай Жиан ярьсныг “Bloomberg” дамжуулсан юм.

Зэс (тн/ам.доллар)



Only One

Made in Mongolia

Business



This edition of Mongolian Economy Magazine in connection to the tourist season devotes considerable amount of its pages to the issues of the tourism industry. Among all the tourism related companies, Mongolian Economy Magazine drew its attention to one leather product manufacturing factory. After inquiring for some time, the "Only One" factory was elected to be subject of this article.

If you ask any Mongolian if they know "Only One" leather product manufacturing factory, very few will probably say they heard about it. However, the small factory has been operating for more than 20 years. Director EnkhTUR tells about many mistakes and difficulties the factory has encountered until today. In 1990's when the market economy was just starting, EnkhTUR launched his business with great resolve and dream about the future. The company is promoting Mongolia to foreigners by selling the types of souvenirs that are commemorative of the country. This factory distinguishes itself from more than 40 other factories and individuals that conduct the same kind of activities by manufacturing high quality leather products starting from leather key chains up to belts, bags and purses. They hope selling at least one kind of designed product to every consumer, which constitutes their competitive advantage, hence the name of the company "Only One". There are many orders for the manufacturing of one and only type of products. This factory, apart from souvenirs, makes also fully equipped police belts, back plate for miners, and all types of attractive and good quality office and decorative bags. Also, when we say that this factory makes only one design product of a kind, do not think that they are very expensive to order. Orders are placed for a reasonable price and products are of good quality. For example, a decorative bag will cost around MNT100,000 thousand. Good quality leather belt costs around MNT20,000. Instead of purchasing expensive foreign products manufactured in south east Asia, it is better to purchase Mongolian made products. While Mongolians do not know about their national factories, tourists come to Only One factory and order "Made in Mongolia" leather products. It is necessary to purchase and promote Mongolian made products; only then will Mongolia be able to have a world renowned manufacturing industries. Although some people scorn souvenir shops, complaining they make poor quality leather products, "It is impossible to assert the quality of nationally produced goods based on the quality of souvenirs sold in souvenir shops," EnkhTUR says. "Therefore, please, do not be quick in declaring that the quality and design of Mongolian leather products are inadequate. Firstly, it is important to get to know the products and understand the reasons behind their

"Only One" factory cooperates with many of its counterparts in the UK, Turkey, Russia, and China. Despite the fact that the factory is well-known to quite a lot of countries, it is not very well-known in Mongolia. They established two years ago the Small Medium Enterprises Association for the purpose of expanding their operations. EnkhTUR is the Executive Director of this Association, which currently holds 65 members. The association has submitted a proposal to decision-makers to implement various programs on gloves, student bags and children's shoes complying with sanitary standards. It seems that they have a firm belief in the government support this time.

This factory has around 10 permanent staff. At peak order periods, they hire additional workers, and work with a full capacity of around 20 staff. "Only One" strives to closely cooperate with other sectors. For example, they cooperate with Tourism companies. This aids them in not only promoting their organization to foreigners but also to promote the country. They also make good quality gun holders, handcuff and bat for policemen. They have made belts for sportsmen during the Beijing Olympic Games. Factory workers take as a good omen the fact that by wearing their nationally produced goods based on the quality of souvenirs sold in souvenir shops, "Therefore, please, do not be quick in declaring that the quality and design of Mongolian leather products are inadequate. Firstly, it is important to get to know the products and understand the reasons behind their

and the commitment of those executives to growing their companies – not simply growing rich, Eurasia and Doran Capital are not about just making money, we are about living a dream to build something of value for our partnership, for Mongolians, for Koreans.

For us management is critical – it is, in fact, the primary component in evaluating an investment opportunity. When we consider any investment we look to the management to assess the level of their integrity, their level of commitment to building a successful company, to their underlying motivations and avoiding the “get rich quick” crowd. We ask the hard questions: How does the investor make money? Investing is not a missionary expedition. The investors are looking to make returns in exchange for the risks they are taking. They are going to look for companies they feel they can trust in making an investment. It is simply a fact that the first investments that we recommend to Korean investors will be the measure by which any future success we might have in raising future investment capital for Mongolia will be determined.

-What was your first investment success story in Korea?

-My first investment was in me! When I came to Korea as an entrepreneur, I had to survive on the little financial resources I had (which were at the time almost none). Four years later I had 15 people working for me. 2 years after that Morgan Stanley bought my company and I suddenly found that I had the responsibility for investing 2 billion USD of foreign capital in Korea as the President of Morgan Stanley's Korean real estate investments. Doran Capital Partners now has offices in Hong Kong, Seoul, Melbourne, London and we are going to soon open an office in New Delhi – and now, through our partnership with Eurasia, we are in Mongolia! You asked me about the big success. Surviving and being able to see how the small idea can be turned into a global company – that is the essence of success. And I felt just as excited by each small success in the beginning, among which was simply being surprised that I survived, as I now feel in some of the multi-million dollar projects we are now involved with. And, now, here I am in Mongolia having the honor to work in partnership with my good friend Alisher who is as a person and a professional demonstrates the highest standards of integrity and honesty and who has built an extraordinary investment banking business in Mongolia that exactly reflects those qualities.

-What is the risk you are taking on?

-The biggest risk we are taking I would say is the risk to our reputations given the expectations for our success in Mongolia. But then, that's okay, after all I have been taking risks all my life. I go to a place I've never been to before and I try to create something out of nothing or I undertake an investment in which I just might get (metaphorically) killed in the attempt to have the experience of accomplishing something extraordinary. You see, I don't climb mountains or jump out of planes. Do you know why? It is because I take huge business risks all the time. On Sunday, I can assure you, all I want to do is to quietly read a book. My entire life has been one long exercise in taking risks – I wouldn't want to live in any other way.

I said, when I came to Mongolia yesterday I felt the same surge of excitement that I did coming to Korea 20 years ago. Mongolians want their country to take its place in the world, everybody in Mongolia feels this is their country's time. I can tell you without hesitation that I have never met so many incredibly intelligent, risk taking, ready for anything the future might offer young professionals as I have in the past two day in Ulaanbaatar. Yes, it all feels like the Korea of 20 years ago.

-What were the 3 reasons you came to Mongolia?

-Because where I was once young I am now mature, because where I was once adventurous I am now wiser, because where I was once just stupid I am now experienced. Mongolia doesn't need just young, stupid and adventurous. It needs maturity, wisdom and experience to guide its future and avoid the mistakes of other developing nations (think of the tragedy of the Philippines). What I see from the advantage of experience is I can guess where Mongolia is heading in the next 10 years. What I see is not challenge in Mongolia and I don't focus on the disadvantages but what I do see are the opportunities that Mongolia offers and what I am convinced of is that Doran Capital Partners working together with Eurasia Capital have once in a lifetime opportunity to contribute to the building of a great economy. Well, perhaps because of my Korean experience I can say that this is actually a twice in a life time chance! We can be part of creating solutions for Mongolians and Korean investors because of our experiences in similar places with similar histories of development. We didn't come here full of professional arrogance, we are coming here on the basis of hard earned wisdom and experience gained from living and working in countries with a similar development experience and having lived through the mistakes as well as the successes made in those places. We believe we can actually be part of bringing Mongolian business and foreign investors together and for mutual success by helping both to avoid the errors made in other places. In doing so, may be we can have the privilege of having made a small contribution to building a successful Mongolian development model that other emerging markets can follow.

-Have you established the Fund?

-We have not established the fund. We have reached the first stage of creating a fund in that we both agree and are committed to working together to bring Mongolian and Korean firms and investors together and through this effort make our contribution to bringing both countries closer together.

-What is the first step?

-First step is defining the purpose and mission of the Fund. To do so we must first refine our investment goals and, then we need to identify the optimum target investor groups in Korea those who would most benefit from investing in Mongolia. Of course, the first real step is to identify, assess and verify those investment opportunities that we believe will be most attractive to Korean investors.

-What would be the guideline for the sectors of the investment?

-We will look for discipline in governance of the companies, we would look for the energy of the principles

-When I came to Mongolia yesterday for the first time in my life, I felt the same surge of energy and excitement that I did 20 years ago coming to Korea. When I first arrived to Korea, everybody said: "6 months and you will go running home to Boston". But now, 20 years later, I have built my own companies in Korea, I have headed the real estate investment division of one of America's major investments banks in Korea, I have built a brand new city in Korea and I have raised global capital for investment into Korea. As

-How do you feel during your first visit in our country?

-How do you feel during your first visit in our country?

